


ТАЙЛАН 2016/2017



Independence

Quality

Impact

АГУУЛГА

БУСАД

БОЛОВСРОЛ

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ЗАСАГЛАЛ

УУЛ УУРХАЙ

1	Бидний үзүүлдэг үйлчилгээ	2
2	Өмнөх үг	3
3	IRIM тухай	4
4	IRIM тоогоор	5
5	2016 оны онцлох үйл явдал	6
6	2016 оны хурлууд	7
7	IRIM-ийн санаачлан хэрэгжүүлсэн төслүүд	10
	1) Монголчуудын субъектив сайн сайхан байдлын талаарх судалгаа	10
	2) Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдал	14
	3) ACEAN орнуудын үнэлгээний стандартын ерөнхий хүрээг Монголд нэвтрүүлж нутагшуулах нь	17
8	Хэрэгжүүлсэн төслүүд	19
	4. "Нүүрснээс нийлэг байгалийн хий гаргах үйлдвэрлэл" төслийн бүс нутгийн байгаль орчны үнэлгээ	19
	5. Монголын уул уурхайн салбарын дахь авлигын эрсдлийн үнэлгээ	21
	6. Бичил уурхай бүхий аймгуудын орон нутгийн хөгжилд бичил уурхайгаас оруулж буй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтөд бичил үзүүлж буй хөрөнгө нөлөөлөл: давтан судалгаа	25
	7. "Монголд институцийн өөрчлөлт хийх замаар төрийн эрдэс баялгийн менежментийг сайжруулах санаачлага" төслийн суурь судалгаа	29
	8. Аж үйлдвэрийн салбарын хэрэгцээг тодорхойлох судалгаа	32
	9. "Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-гийн бодлого төлөвлөлтийг боловсронгуй болгох зөвлөх үйлчилгээ	34
	10. Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд хийгдсэн жендерийн үзүүлэлтүүдэд хийсэн суурь үнэлгээ	37
	11. Монгол улсад нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэх хөтөлбөрийн суурь судалгаа	40
	12. Бүс нутгийн эдийн засгийн интеграцилал: Монгол дахь эрсдэл ба боломж	44
	13. Авлигын чиглэлээр хийгдсэн судалгааны материалд хийсэн дүн шинжилгээ	46
	14. Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II /БОХТОН-II/ Үр дүнгийн судалгаа	49
	15. Хотын засаглал" төслийн бүрэлдэхүүн 5: "Чадавхи бэхжүүлэх хөтөлбөрүүдийг институцлэх"-д дэмжлэг үзүүлэх төсөл	53
	16. Төрийн байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ	56
	17. Иргэдийн хууль зүйн туслалцааны хэрэгцээг тодорхойлох судалгаа	59
	18. Цагдаагийн байгууллагын хэрэглэгчийн үнэлгээний судалгаа	63
	19. Тогтвортой хөгжил ба Ногоон хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн боловсролын байгууллагуудын суурь судалгаа	66
	20. МБС-ын удирдах ажилтанд тавигдах мэргэжлийн шаардлагыг тодорхойлох зөвлөх үйлчилгээ	69
	21. Дээд боловсролын шинэчлэлийн төсөл "Дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах нь" зөвлөх үйлчилгээ	72
	22. Булган орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн үр нөлөөний үнэлгээ	75
	23. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд үнэлгээ	79
	24. "Эзлүүд тал II: Монголын ан амьтны хууль бус худалдааны хямралтай асуудлууд	82
	25. Монгол дах мөнгөн усны менежментийн техникийн хэрэгцээг тодорхойлох судалгаа	85
9	Хэрэгжиж буй төслүүд	88
	26. Эрх зүйт ёс ба Монголын уул уурхайн салбар дахь байгаль орчны засаглал	88
	27. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй	91

ЭРХЭМ ЗОРИЛГО

Дэлхийн жишигт нийцсэн хараат бус, судалгаа, зөвлөх үйлчилгээ хүргэдэг, Монголын туршлагад тулгуурласан мэдлэгийн төв болно.

БИДНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

СУДАЛГАА - Бид судалгааны тоон болон чанарын аргыг ашиглан шинэлэг, салбар хоорондын судалгааны төслийн дизайныг боловсруулж, хэрэгжүүлж ирсэн. Өргөн хүрээтэй асуудлыг хамарсан судалгааны ажлыг түвшин түвшинд гүйцэтгэж ирсэн туршлагатай.

ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ - Хяналт, үнэлгээний ажлууд манай байгууллагын гүйцэтгэж буй ажлын гуравны нэг орчим хувийг эзэлдэг. Бид төсөл, хөтөлбөрүүдэд хараат бус, хөндлөнгийн шинжилгээ хийж, нэг талыг баримтлаагүй дүгнэлт гаргахыг эрмэлздэг. Хяналт, үнэлгээний төслүүдээрээ дамжуулан нийгэмд тодорхой үр дүн, ахиц дэвшлийг бий болгохоор зорин ажиллаж байна


Нөлөөллийн ажил болон олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагаа - Бодлогод нөлөөлөх, аливаа сэдвийн талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, тодорхой бүлэгт хүрэх гэх мэт зорилгоор олон төрлийн нөлөөллийн болон олон нийт рүү чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг.

ТӨСЛИЙН МЕНЕЖМЕНТ - Манай байгууллагын хэрэгжүүлдэг төслүүд судалгаагаар хязгаарлагддаггүй. Бид өөрийн орны нөхцөл байдлын талаар хуримтлуулсан туршлага, мэдлэгээ ашиглан Монголын нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчинд үр өгөөжтэй төслүүдийг санаачилж, хэрэгжүүлэх чадавхтай.

СУРГАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ - Бид сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахдаа олон төрлийн аргачлал, арга зүйг ашиглахаас гадна өөрсдийн туршлагаараа байнга баяжуулж шинэчилдэг. Сургалтууд төсвийн нээлттэй байдал, иргэдийн оролцоо, байгууллагын чадавхийг бэхжүүлэх болон суралцах арга барил гэх мэт өргөн хүрээтэй сэдвийг хамардаг. Бид сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахдаа дараах үйлчилгээг бүрэн хариуцдаг. Үүнд,

- Зохион байгуулалт
- Оролцогчдын хэрэгцээний үнэлгээ
- Оролцогчдод зориулсан сургалтын материал, модулийн боловсруулалт
- Видео бичлэг, зураг, тэмдэглэл гэх мэт баримтжуулалт.

ӨМНӨХ ҮГ

Онц бөгөөд бүрэн эрхэт
элчин сайд, IRIM-ийн
Ерөнхийлөгч
Х.Бэхбат




Гүйцэтгэх захирал
А.Долгион

IRIM судалгааны хүрээлэнгийн Монголын хөгжилд гүйцэтгэж буй онцлон тэмдэглэхүйц үүрэг нь шийдвэр гаргахад ашиглахуйц найдвартай, салбарын онцлогийг тусгасан нотолгоо мэдээллийн санг бүрдүүлэх явдал юм. Өнгөрсөн 9 жилийн хугацаанд, хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд нотолгоог бодитой 'ашиглах'-ын тулд бодлого боловсруулагчид, хөгжлийн мэргэжилтнүүд болон иргэд тус тусдаа бус хоорондоо нягт хамтран ажиллах нь нэн чухал болох нь тодорхой харагдлаа. Иймээс бид өөрсдийн хараат бус, бодитой байр сууриа хадгалахын сацуу эдгээр талуудтай илүү нягт хамтран ажилласаар байна.

Дэлхий дахины болон үндэсний хэмжээнд хөгжлийн зорилгуудыг дахин тодорхойлж буйтай холбоотойгоор бид байгууллагын шинэ алсын хараа, үнэт зүйл болон 2020 он хүртэлх Стратеги төлөвлөгөөг боловсрууллаа.

ОУ-ын чанарын удирдлагын ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх хүрээнд бид байгууллагынхаа чанарын бодлого, үйл ажиллагааны болон чанарын удирдлагын системийг улам боловсронгуй болголоо. Үүний үр дүнд илүү төслүүдээ чанарын илүү өндөр түвшинд гүйцэтгэж, нийгэмдээ эерэг үр нөлөөг бий болгоход анхаарч ажиллах боломжийг бүрдүүллээ.

Үндэсний хэмжээнд бид засаглал, боловсрол, хөдөлмөрийн зах зээл болон уул уурхайн салбаруудад судалгаа, үнэлгээ, хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлсээр байна. 2016 онд бид эдгээр чиглэлд төрийн болон ОУ-ын олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлснийг уг тайлангаас харж болно. Мөн түүнчлэн, бид өөрсдийн санаачилгаар Нийгмийн итгэлцэл ба Субъектив сайн сайхан байдлын талаарх судалгааг эхлүүлсэн ба бид

жил тутам үндэсний хэмжээнд зохион байгуулж, судалгааны үр дүнг олон нийтэд нээлттэй хүргэнэ.

Цаашилбал, IRIM нь Монголын Үнэлгээний Үндэсний Сүлжээг үүсгэн байгуулахад голлох үүрэгтэй оролцлоо. Бид төрийн байгууллагын үнэлгээ, үр дүнд суурилсан удирдлагын системийг сайжруулах, үүн дотроо Хяналт-Шинжилгээ, Үнэлгээний нийтлэг журмын талаарх ЗГ-ын тогтоолыг шинэчлэн сайжруулах талаар ЗГ-тай зөвлөлдөн ажиллаж байна. Одоогоор бид Монголын Үнэлгээний Сүлжээний гишүүдтэйгээ хамтран Үндэсний Үнэлгээний Стандартыг Монголдоо нэвтрүүлэхээр ажиллаж байна.

ОУ-ын түвшинд бид дэлхий дахины үнэлгээний хэрэглээг дэмжих, Глобал Үнэлгээний Хөтөлбөр 2016-2020-г хэрэгжүүлэх хүчин чармайлтанд нэгдэн орлоо. Бид Венад болсон Олон Улсын Социологийн Холбооны Форум, Вашингтонд болсон Дэлхийн банк, ОУВС-ийн Хаврын хурал болон Хятадын Шианьд Азийн Үнэлгээний долоо хоногт оролцож тэгш хөгжлийн талаарх глобал хэлэлцүүлэгт хувь нэмрээ орууллаа.

Эдгээр бүх ололт амжилтууд нь бидэнд итгэсэн захиалагчид, хараат бус, мэргэжлийн, өндөр чанар бүхий зөвлөх үйлчилгээг гүйцэтгэсэн зөвлөх болон судлаачдын баггүйгээр хэрэгжих боломжгүй юм. Энэ дашрамд бидэнтэй хамтран ажилласан захиалагчиддаа талархал илэрхийлье. Уламжлал ёсоор, энэхүү тайлангийн гол зорилго нь Монголын хөгжлийн асуудлаар сонирхон судалдаг хэн бүхэн, судалгаа, шийдвэр гаргалтанд оролцож буй оролцогч талуудад IRIM-н хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнгийн талаарх мэдээллээ хуваалцах юм. Тиймээс, энэхүү тайлантай цаг гарган танилцаж буй танд талархал илэрхийлж байна.

БИДНИЙ ТУХАЙ



Хараат Бус Судалгааны Хүрээлэн (IRIM) нь анх 2008 оны дөрвөн сард дөрвөн хүний бүрэлдэхүүнтэй үүсгэн байгуулагдсан.

Бид төслийн удирдлага, сургалт, судалгаа, үнэлгээний чиглэлээр төрийн болон төрийн бус, олон улсын болон донор байгууллагуудад үйлчилгээ үзүүлдэг бөгөөд хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд бодитой хувь нэмрээ оруулахаар зорьж ажиллаж байна.

Бид өөрийн орны онцлогийг тусгасан, үр дүнг чухалчилсан, үйлчлүүлэгч төвтэй төслийн менежментийн шийдлүүдийг санал болгохоос гадна нотолгоонд суурилсан чанартай мэдээлэл бий болгох, хараат бус, хөндлөнгийн байр сууриа хадгалах зарчмыг үргэлж баримталдаг.

Бид одоогийн байдлаар 16 үндсэн, 20 гаруй гэрээт ажилтантай ба манай мэдээллийн санд үндэсний ба олон улсын 300 гаруй зөвлөх бүртгэлтэй байдаг. Манай судлаачид жилийн туршид Монгол улсын өнцөг булан бүрт хүрч ажилладаг.

Байгуулагдсан цагаасаа хойш бид 2 охин компанийг байгуулаад байна. Үүнд:

1. MIRIM (Marketing and Innovation Research Institute of Mongolia) буюу МИРИМ Консалтант компани нь маркетинг, инновацийн судалгаагаар мэргэшсэн, хувийн хэвшлийн салбарын онцлог, хэрэгцээнд нийцсэн судалгаа хэрэгжүүлдэг.
2. OSHMI (Occupational Safety and Health Management Institute of Mongolia) буюу нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүйн стандартуудтай холбоотой үйлчилгээ үзүүлдэг, энэ чиглэлээр мэргэшсэн байгууллага юм.

IRIM ТООГООР



2008 ОНЫ
4 Сарсаас

2017 ОНЫ
4 Сар

59

Засаглал

21

Маркетинг,
Эдийн засаг

24

Боловсрол

12

Нийгмийн
эрүүл мэнд

10

Хөдөөгийн
ерх

19

Уул уурхай,
байгаль орчин

2

Бусад

127131
Респондент




81 Захиалагч



136 Хамтрагч


ТӨСӨЛ ХЭРЭГЖСЭН ГАЗРУУД



Улаанбаатар 109
Ховд 43
Өмнө 36
Дундговь 33
Дархан-Уул 33
Баянхонгор 32
Говь-Алтай 32
Өвөрхангай 31

Увс 30
Сэлэнгэ 30
Дорнод 28
Хөвсгөл 27
Хэнтий 27
Архангай 26
Дундговь 25
Төв 25

Сүхбаатар 24
Завхан 24
Орхон 24
Баян-Өлгий 22
Говьсүмбэр 19
Булган 16
Хятадын Эрээн хот 1
Нийт 697



Бидний ёс зүйн болон мэргэжлийн зарчим



Олон улсын социологийн холбоо (ISA)-ийн гишүүний хувьд бид тус холбооны Гүйцэтгэх зөвлөлөөс баталсан Ёс зүйн дүрмийг хатуу баримтлан ажилладаг.




Манай хүрээлэнд Нийгмийн хариуцлагын Азийн сүлжээний Гүйцэтгэх хорооны гишүүн байгууллага. Иймээс бид нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааг дэмжин ажиллахыг зорьдог.



IRIM нь Ази-Номхон далайн үнэлгээний сүлжээнд албан ёсоор нэгдэн орсон Монголын анхны байгууллага болсон.



2016 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛЯВДАЛ



2017

2016 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

IRIM СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ Х.БЭХБАТ ФРАНЦЫН ХҮНДЭТ ЛЕГИОНЫ ОДОН ХҮРТЛЭЭ



Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, IRIM судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч Х.Бэхбат Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хүндэт Легион” төрийн дээд одонгоор шагнууллаа. Одон гардуулах ёслол 2016 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Бүгд Найрамдах Франц Улсын Элчин сайдын яаманд зохион байгуулагдлаа.

“Хүндэт легионы одон” нь Францын цэргийн бөгөөд иргэний хамгийн дээд шагнал бөгөөд 1802 онд Наполеон Бонапарт анх бий болгож байжээ. Энэ одонг Францын Ерөнхийлөгчийн зарлигаар дотоодын болон гадаадын онцгой гавьяа байгуулсан иргэдэд олгодог.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ А.ДОЛГИОН АНУ-ЫН ВАШИНГТОН ХОТОД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОЛОН УЛСЫН ВАЛЬЮТЫН САН БОЛОН ДЭЛХИЙН БАНКНЫ ХАВРЫН ХУРАЛД ОРОЛЦЛОО



Олон Улсын Валютын Сан (ОУВС) болон Дэлхийн Банкны (ДБ) Хаврын хуралдаан 2016 оны 4-р сарын 15-наас 17-ны хооронд Вашингтонд зохион байгуулагдлаа. Энэ жилийн Хаврын хуралдаанд 10,000 гаруй оролцогчдыг (Төв банкны ажилтнууд, санхүү болон хөгжлийн асуудал хариуцсан яамд болон эрдэм шинжилгээний ажилтнууд гэх мэт) хамруулсанаас 1000 гаруй нь Иргэний Нийгмийн Байгууллагын (ИНБ) төлөөлөгчид байлаа. Уг хуралдааны үеэр дэлхий дахинд анхаарал хандуулж буй дэлхийн эдийн засгийн төлөв байдал, ядуурлын бууруулах, олон улсын хөгжлийн асуудлуудыг хэлэлцлээ.

Хуралдааны чухал салшгүй хэсэг нь Иргэний Нийгмийн Бодлогын хэлэлцүүлэг байлаа. Энэхүү үйл ажиллагааны хөтөлбөр нь ИНБ-ууд болон ОУВС, Дэлхийн Банк, Засгийн Газрын төлөөлөгч хооронд бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэхэд чиглэж байсан. Сүүлийн 13 жилийн хугацаанд Хаврын хуралдааны үеэр зохион байгуулж буй ИНБ-уудын дуу хоолой, оролцоо нь ОУВС-г цаг уурын өөрчлөлт, эмэгтэй ажиллах хүчний оролцоо ба тэгш бус байдлын асуудалд анхаарлаа хандуулахад ихээхэн хувь нэмэр болсон байдаг. Энэ жилийн Хаврын хуралдаанд IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэх захирал А.Долгион ОУВС-ийн Иргэний Нийгмийн Тэтгэлэгт Хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр оролцлоо. Тэрээр уг хуралдааны үеэр татвар ба тэгш байдал, санхүүгийн ил тод байдлын хэрэгцээ шаардлага, авлигын эсрэг тэмцэл, жендэрийн тэгш байдал, Дэлхийн Банк болон ОУВС-аас ядуурлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлж буй санаачилгуудын үр нөлөөний асуудлаар өөрсдийн байр суурь, үзэл бодлоо илэрхийллээ.

АНУ-ЫН ВАШИНГТОН ХОТОД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН ОЛОН УЛСЫН МОНГОЛ СУДЛАЛЫН АРАВДУГААР БАГА ХУРАЛД ОРОЛЦЛОО



ИРИМ судалгааны хүрээлэнгийн төслийн зохицуулагч С. Өлзийсайхан 2016 оны 5 сарын 13-14 өдөр АНУ-ын Вашингтон хотод зохион байгуулагдсан Олон улсын Монгол судлалын Аравдугаар бага хуралд оролцож өөрийн судалгааны үр дүнгээс танилцуулсан.

Тус хуралд Монгол, АНУ, ОХУ, БНХАУ, БНСУ улсаас нийт 17 монгол судлаач эрдэмтэн ирж Монголын Түүх, Утга зохиол, шашин, хэл шинжлэл, боловсрол, соёлын чиглэлээр илтгэл тавьж оролцсон. ИРИМ судалгааны хүрээлэнгийн зүгээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын талаарх судалгааны үр дүнгээр илтгэл тавьсан.

ИРИМ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭНГИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН Н. БАТЧИМЭГ АЗИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДОЛОО ХОНОГ ОЛОН УЛСЫН ХУРАЛД ОРОЛЦЛОО



ИРИМ судалгааны хүрээлэнгийн ТУЗ-ийн хараат бус гишүүн Н. Батчимэг нь 2016 оны 9 сарын 5-9 өдөр Хятад улсын ШиАн хотод АХБ-ны Хараат бус үнэлгээний газар болон Хятад улсын Ази номхон далайн санхүү хөгжлийн хүрээлэнгээс зохион байгуулагдсан Азийн үнэлгээний долоо хоног олон улсын хуралд оролцож Жендэрийн мэдрэмжтэй төсвийн талаарх Монголын туршлага сэдвээр илтгэл тавьж оролцлоо.

Тус хуралд 35 орны 100 гаруй төлөөлөгч, хөгжлийн түнш байгууллагууд оролцож Үнэлгээ ба төрийн бодлого, Боловсролын үнэлгээн дахь тэгш байдал, Эмэгтэйчүүд ба

жендэрийн асуудал, Санхүүгийн удирдлагын шинэчлэл, Төслийн эдийн засаг ба нийгмийн үр өгөөж, Мэдлэгийн удирдлага ба үнэлгээ, Тогтвортой хөгжлийн зориултууд, Шинжлэх ухаан ба технологийн хөгжлийн үнэлгээ зэрэг чиглэлээр нийт 33 салбар хуралдаж илтгэлүүд хэлэлцүүлээ.

ХУРЛЫН ЗОРИЛГО:

1. Ази болон бусад бүс нутаг хоорондын (Африк болон Латин Америк гм) үнэлгээний сүүлийн үеийн санал санаачлагыг хуваалцах

2. Үнэлгээний ажлын туршлага хуваалцаж мэдлэг дээшлүүлэх, тэр дундаа үнэлгээний үр дүнг хэрхэн ашиглах талаар
3. Салбарын, сэдэвчилсэн үнэлгээний ажил болон үнэлгээний арга зүй, практикт гаргаж буй дэвшилтүүдийг хуваалцах
4. Хөгжлийн үр дүнтэй байдалд үнэлгээний үүргийг таниулан сурталчлах

Тус хурал нь Ази-Номхон далайн орнуудад үнэлгээг илүү үр нөлөөтэй, хариуцлагатай байдлын төлөө ашиглах шаардлага үүсч байгаа тэр дундаа Sustainable Development Goals 2030-тай холбоотойгоор улс орнуудад зорилт, зорилгуудаа илүү үр дүнтэйгээр хянах шаардлага тулгарч байгаатай холбоотойгоор зохион байгуулсан ба цаашид жил болгон зохион байгуулагдах юм.

“ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД БА МОНГОЛ УЛС: ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮҮРЭГ” СЭДЭВТ УЛАМЖЛАЛТ ХҮЛЭЭН АВАЛТАА АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



IRIM судалгааны хүрээлэн нь 2015 оноос эхлэн өөрийн ажиллаж буй зарим чухал асуудлыг оролцогч талуудад таниулах, ойлголт хандлагыг нь эерэгээр өөрчлөх зорилготой “Уламжлалт хүлээн авалт”-ыг санаачилсан юм. Энэ жилийн хүлээн авалтыг “Тогтвортой хөгжлийн зорилтууд ба Монгол Улс: Хөндлөнгийн үнэлгээний үүрэг” сэдвийн доор амжилттай зохион байгууллаа. IRIM-н Гүйцэтгэх захирал А. Долгион үндсэн илтгэлийг тавьж, үнэлгээний чанар, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэхэд үнэлгээний нэгдсэн хүрээг боловсруулах шаардлагатай байгааг тэмдэглэсэн юм. Засгийн Газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн Б.Цэнджав үнэлгээний чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлж, чадавхийг нэмэгдүүлэх хэрэгцээ байгаа талаар оролцогчдод мэдээллээ. Харин НҮБ-ын Суурин зохицуулагч Беате Транкманн хөгжлийн хөтөлбөр, төслүүдийг Тогтвортой хөгжлийн зорилгуудтай уялдуулах нь маш чухал байгаа талаар санал бодлоо илэрхийлэв. Арга хэмжээнд төрийн байгууллагууд, хандивлагчид болон хөндлөнгийн үнэлгээний байгууллагууд оролцсон бөгөөд үнэлгээний чиглэлээр саналаа солилцлоо.

IRIM-ИЙН САНААЧЛАН ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛЫН САЙН САЙХАН БАЙДЛЫН ТАЛААРХ СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM Судалгааны Хүрээлэн

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Монголчуудын амьдралын сайн сайхан байдлыг судалснаар нийгэм, эдийн засгийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх баримт нотолгоог бий болгох, орчин цагийн хурдтай өөрчлөгдөж байгаа нийгэмд иргэд амьдралаа хэрхэн үнэлж байгаа талаарх ойлголт, мэдэгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилготой.

Зорилт:

- Олон улсын стандартын түвшинд (OECD) судалгааны удирдамжийг боловсруулах
- Улсын хэмжээнд олон давтамжтай түүвэр судалгаа зохион байгуулах
- Судалгааны үр дүнд шинжилгээ хийж, үндэсний болон олон улсын хурал цуглаанд хэлэлцүүлэх
- Төр засгийн шийдвэр гаргах түвшинд нөлөөлөхүйц бодлогын зөвлөмж боловсруулах




2016

6-р сар

2016

12-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Судалгаа Улаанбаатар хот болон Архангай, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Завхан, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймагт хийгдсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Иргэдийн амьдралын чанарыг сайжруулахад чиглэсэн бодлого үйл, ажиллагааг зөвхөн орлого сайн сайхны бодит үзүүлэлтийг харуулсан мэдээлэл тулгуурладаг байв. Ингэх нь хүмүүс өөрсдийн амьдралаа сайжирсан эсэхийг орхигдуулдаг нь маш олон бодлого, хөтөлбөрүүд хүлээгдэж байсан үр дүнгээ харуулдаггүй.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны арга зүйг Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас гаргасан гарын авлагад тулгуурлан боловсруулсан. Судалгааны асуулгад дараахи асуултуудыг багтаасан.

- Сайн сайхан байдлын суурь үнэлгээ
- Амьдралын үнэлгээ
- Юдемоник /eudaimonic/ амьдралын утга учир

- Амьдралын олон талт үнэлгээ - амьдралынхаа нөхцлийг бүтнээр нь болон нэг хэсгийг нь үнэлэх (эрүүл мэнд, амьдралын стандарт зэрэгт өгөх үнэлгээ)
- Сэтгэл хөдлөлийн үнэлгээ

Судалгааны мэдээллийг тоон аргаар цуглуулсан бөгөөд түүврийн бүлгүүдийг харилцан адилгүй цаг хугацаанд сонгон авч харьцуулагдахуйц байдлыг нэмэгдүүлсэн.

ҮР ДҮН

ХАРИЛЦАН ИТГЭЛЦЭЛ

Энэхүү хэсэг респондентуудын бусдад итгэх итгэл болоод бусад хүмүүсийн тэдэнд итгэх байдлыг таамаглуулсан судалгааны үр дүнг харуулна. Респондентуудын дунд ерөнхий итгэлийн түвшин бага байв. “Та хүмүүст хэр зэрэг итгэдэг вэ?” гэсэн асуултын хариултын дундаж оноо 6.2 байсан.

Судалгаанд оролцогчдын 65.8% нь “Та ихэнх хүмүүст итгэж болно гэж боддог уу эсвэл хүмүүстэй харилцахдаа болгоомжтой байх ёстой гэж боддог уу?” гэсэн асуултанд 5 болон түүнээс доош оноог өгсөн. Үүний адилаар респондентуудын 69% нь хүмүүс боломж гарвал тэднийг ашиглахыг оролддог гэж үзсэн байв. Эдгээр хоёр асуултын дундаж оноо 4.4 байна. Зураг 8-д респондентуудын өөр өөр бүлгийн хүмүүст итгэх итгэлийг дундаж оноог харуулав.

Зураг.1: Өөр бүлгийн хүмүүсийн итгэлийн дундаж түвшин



Өөр бүлгийн хүмүүсийн итгэл түвшинд асар том ялгаа харагдаж байсан ба найз нөхөд, гэр бүлийн гишүүддээ илүү итгэж байгаа бол танихгүй хүмүүс болон харьяаллын бус бүлэгт итгэх итгэлийн түвшин сул байна.

Олон улсын судалгаанаас авч үзвэл иргэдийн итгэлийн түвшин бага байх нь нийтлэг үзэгдэл юм. Ларсений 2014 оны болон 2010 онд хийгдсэн Дэлхийн Үнэ Цэнийн Судалгааны үр дүнгээс үзвэл нийгмийн итгэлийн түвшин өндөр байх нь маш ховор үзэгдэл ажээ. Энэ судалгаанд хамрагдсаг 52 орноос зөвхөн 5-ны орны үр дүнд л респондентуудын “ихэнх хүмүүст итгэж болно” гэсэн хариулт “хэн нэгэнтэй харилцахдаа болгоомжтой байх ёстой” гэдэг хариултаас өндөр байгаа юм.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэвэл дэлхийн бусад орнуудын судалгааны үр дүнтэй ижил үр дүн буюу Монголчуудын итгэлийн түвшин бага, бусадтай хамтарч ажиллахдаа бэлэн байгаа байдал харьцангуй сул байна. Харин Монгол дахь нийгмийн нягтрал нь гэр бүл төвтэй. Монголчуудын хувьд өөрсдтэйгөө төстэй шинж чанартай бүлгүүдэд итгэх, тэдэнтэй хамтарч ажиллах сонирхол өндөр буюу илүү механик эв нэгдэл зонхилсон шинж чанартай. Энэ нь Монгол улс маш олон талаараа уламжлалт нийгмийн шинж чанарыг агуулсан хэвээр байна.

Харилцан итгэлцэл болон хамтарч ажиллахад бэлэн байгаа байдал нь нийгэм дэх харилцааны алслалтай холбоотой юм. Монголчууд бусдыг өөрт нь итгэж, хамтран ажиллахдаа бэлэн байгаа гэж үзэхээс илүүтэй өөрсдөө тэдэнд итгэж, хамтарч ажиллахдаа бэлэн байна. Харин нийгмийн харилцааны алслал нь энэ ойлголтыг багасгаж, нийгмийн хувьд хэн нэгэнтэй илүү ойр байх нь харилцан итгэлцэл болон хамтарч ажиллахдаа бэлэн байх байдал илүү их байна гэж ойлгогдож байна.

Респондентийн нас, хүйсийн нөлөө итгэл болон хамтарч ажиллахад бэлэн байх байдалд нөлөөлөх байдал хэд хэдэн газар ажиглагдсан. Нас, боловсролын түвшин, орлогын түвшин, тухайн хүний амьдарч байгаа газар бүгд статистикийн хувьд ач холбогдолтой хүчин зүйлүүд юм. Харин хүйсийн хувьд ач холбогдолгүй.

Энэ судалгаа нь Монголд нийгмийн субъектив нягтралын талаар чухал мэдээллийг өгөхөөс гадна энэ нийтлэл дурьдсан үр дүнд нөлөөлж

буй хүчин зүйлүүдийг илүү сайн ойлгохын тулд судалгааг цаашид тасралтгүй үргэлжлүүлэх хэрэгтэй. Энэ төрлийн судалгаа Монголд анх удаагаа хийгдэж байгаа тул энэ хандлага хэрхэн өөрчлөгдөж ирснийг тодорхойлох мэдээлэл хомс байна. Энэ судалгаа нь онолын хувьд Монгол дахь объектив болон субъектив бүрэлдэхүүнийг багтаасан нийгмийн нягтралын талаар илүү цогц ойлголтыг бий болгох анхны алхам болсон гэж найдаж байна.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ВЭБСАЙТЫН ИЛ ТОД БАЙДЛЫН СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

IRIM Судалгааны Хүрээлэн

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэ судалгаа нь “ Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль-ийн дагуу төрийн байгууллагуудын вебсайтад мониторинг хийн хуулийн хэрэгжилтийг холбогдох үзүүлэлтүүдээр үнэлэх, цаашдын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах зорилготой.

Энэ хүрээнд дараах зорилтуудыг тавьсан юм. Үүнд:

- Энэ удаагийн судалгаанд 2011 онд хийгдсэн АТГ-аас хийсэн мониторингийн судалгааны арга зүйг зарчмын хувьд баримтлан ажилласан ба ингэснээр судалгааны үр дүнгийн харьцуулагдахуйц байдлыг хадгалах юм. Мөн төрийн байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг зэрэг үзүүлэлт тус бүрээр үнэлэх
- Төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүдийг “Шилэн дансны тухай хууль”-ийн заалтуудыг баримтлан хэрэгжилтийг үнэлэх
- Мониторингийн үр дүнг 2011 оны судалгааны үр дүнтэй харьцуулан шинжлэх;
- Судалгаанд хамрагдсан төрийн байгууллагуудын цахим хуудсыг ил тод байдлын үзүүлэлтээр эрэмбэлж, төрөл тус бүрээр нь жагсаалт гаргах;
- Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.



2016

10-р сар

2016

12-р сар



ХАМРАХ ХҮРЭЭ

Судалгааны хүрээнд төрийн 81 байгууллагын цахим хуудсанд үнэлгээ хийн мэдээллийг цуглуулан ажиллаа. Үүнд:

- Монгол Улсын яам -13;
- Монгол Уулсын хэрэгжүүлэгч агентлаг -17;
- Монгол Улсын тохируулагч агентлаг -10;
- Монгол Улсын орон нутгийн захиргаа- 21;
- Нийслэл, дүүргийн захиргаа - 11
- Улсын Их Хурал болон түүний харъяа байгууллага -9

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Сайн засаглалын үндсэн элементийн нэг нь ил тод байдал юм. Төрийн байгууллагын ил тод байдлыг хангах мэдээллийн гол эх сурвалж бол тухайн байгууллагын цахим хуудас байдаг. 2010-2011 онуудад ИРИМ судалгааны хүрээлэн НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн санхүүжилттэйгээр Авилгатай Тэмцэх Газартай хамтран “Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын үнэлгээ”-г хийж гүйцэтгэсэн билээ. 2016 онд ИРИМ судалгааны хүрээлэн өөрийн санаачилгаар “Төрийн байгууллагын цахим хуудсын ил тод байдлын үнэлгээ” судалгааг хийж гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төсөл нь дараах 3-н үе шатын дагуу хэрэгжсэн. Үүнд:

1. Цахим хуудасуудад шалгуур үзүүлэлтээр хуулийн хэрэгжилтийг ямар түвшинд байгааг үнэлэх

2. 2011 оны судалгаатай харьцуулагдахуйц байдлаар үзүүлэлтүүдийг харуулах
3. Байгууллагуудыг эрэмбэлэх

Мониторингийн арга зүйд ашиглагдсан үзүүлэлтүүдийн аль нь ил тод байдлыг илтгэхэд илүү ач холбогдолтой үзүүлэлт вэ? гэдгийг ялгаатай байдлаар тогтоосон. Эдгээр үзүүлэлтийн нийт үнэлгээний системд эзлэх ач холбогдлыг Дүрс 1-д харуулав.


Дүрс. 1: Шалгуур үзүүлэлт бүрийн үнэлгээ, хувиар



ҮР ДҮН

Төрийн байгууллагын цахим хуудсын үнэлгээ 2011 оноос 2015 он хүртэл тасралтгүй өсөлттэй үр дүнг харуулж байсан ч 2016 оны үнэлгээгээр үр дүн мэдэгдэхүйц буурсан байна. 2016 оны УИХ-ын сонгуулийн үр дүнгээр ЗГ-ын яамд болон агентлагууд бүтцийн хувьд шинэчлэгдэн, зарим төрийн байгууллагуудын цахим хуудас өөрчлөгдөх, зарим нь хаагдах, нэг хэсэг нь шинээр нээгдсэн байна. Энэ нь 2016 онд төрийн байгууллагын цахим хуудсын үнэлгээг буурахад нөлөөлсөн юм.


Дүрс. 2: Төрийн байгууллагын цахим хуудсын үнэлгээ, оноор



Цахим хуудсын үнэлгээний үр дүн 2011 оноос хойш тасралтгүй сайжирсан хэдий ч 2016 онд 50 доош хувьтай үнэлэгдсэн нь энэ чиглэлээр олон ажил хийх шаардлагатай шаардлагатай байгааг харуулж байна.

Дараах дүрсээр ил тод байдлын шалгуур үзүүлэлт тус бүрийн нарийвчилсан үнэлгээг харууллаа. Төрийн байгууллагын “үйл ажиллагааны ил тод байдал” бусад үзүүлэлттэй харьцуулахад илүү ил тод байгаа бол “худалдан авах ажиллагааны ил тод байдал” хамгийн бага хувьтай үнэлэгдсэн байна.

Дүрс. 3: Үнэлгээний индикатор, хувиар. 2016 он



ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Судалгааны үр дүнд үндэслэн төрийн байгууллагуудын цахим хуудсын ил тод байдлын

чиглэлээр дараах давуу болон сул талууд ажиглагдаж байгааг хүснэгт 4-т харууллаа.

Хүснэгт. 4: Төрийн байгууллагын цахим хуудсын ил тод байдлын ололттой болон дутагдалтай тал

ОЛОЛТТОЙ ТАЛУУД	ДУТАГДАЛТАЙ ТАЛУУД
“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль”-ийн хүрээнд төрийн байгууллагууд цахим хуудсандаа мэдээлэл оруулах байдал сайжирч байна.	Вебсайтад тавигдаж буй мэдээлэл нь ихэнхидээн найдваргүй, хуучирсан, мэдээллийн шинэчлэл муу байна.
Бүх төрийн байгууллага албан ёсны цахим хуудастай болсон бөгөөд хэрэглэгч, иргэдийг цахим хуудсан дах мэдээллээр хангах боломжтой болсон байна.	Мэдээллийн нэг талын урсгал давамгайлж байгаа бөгөөд иргэдийн санал хүсэлтийг авах, оролцоог хангах зэрэг эргэх холбоо дутагдалтай байна.
Вэбсайтууд нь техникийн энгийн шалгууруудыг хангаж, ашиглахад боломжийн байгаа нь төрийн байгууллагууд вэбсайтыг ашиглахад анхаарал хандуулж байгааг харуулж байна.	Шинэ мэдээлэлийг тавихдаа зөвхөн техникийн талаас анхаарахаас мэргэжлийн салбар, хэлтэс, нэгжээс чанартай мэдээллийг тогтмол ханган нийлүүлэх тал дээр анхаарахгүй байна.
Шилэн дансны нэгдсэн цахим хуудас ажиллаж эхэлсэн, төрийн байгууллагууд цахим хуудсандаа холбоос, линкийг байршуулж эхэлснээр худалдан авах ажиллагаа болон төсөв санхүүгийн холбогдолтой мэдээллийн ил тод байдал сайжирч байна.	МУ-ын ЗГ солигдсон тохиолдолд яамд болон агентлагуудын цахим хуудас өөрчлөгдөх, хаагдах, шинээр солигдох зэрэг асуудал үүсч байгаа нь мэдээллийн ил тод байдалд сөргөөр нөлөөлж байна.

АСЕАН ОРНУУДЫН ҮНЭЛГЭЭНИЙ СТАНДАРТЫН ЕРӨНХИЙ ХҮРЭЭГ МОНГОЛД НЭВТРҮҮЛЖ НУТАГШУУЛАХ НЬ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Евал Партнерс Интернейшнл

Олон улсын үнэлгээний хамтын ажиллагааны байгууллага

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь АСЕАН-ы бүсийн үнэлгээний стандартын хүрээг Монголд нэвтрүүлж, Монголын үнэлгээний сүлжээг бий болгон үнэлгээний чиглэлээр оролцогч талуудын үйл ажиллагааг дэмжих юм.



2016

2-р сар

2016

3-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Төсөл Улаанбаатар хотод хэрэгжсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

АСЕАН-ы орнуудын Үнэлгээний стандартын ерөнхий хүрээг (АРФЭС) боловсруулах үйл ажиллагааг Евал Партнерс Интернейшнл (Eval Partners International) байгууллагаас санаачилж, Олон Улсын Үнэлгээний Хамтын Ажиллагааны Байгууллага (IOCE)-ын хэрэгжүүлж буй Харилцан суралцах хөтөлбөрөөс (Peer-to-Peer) санхүүжүүлсэн юм. АРФЭС төслийг Малайзийн Үнэлгээний Холбоо (MES) удирдаж байгаа бөгөөд АСЕАН-ы бүсийн дөрвөн байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.

АСЕАН бүсийн хөгжиж буй орнуудын олонхи нь үндэсний хэмжээний үнэлгээний стандартгүй байгаа тул ийм баримт бичиг боловсруулах зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм. АРФЭС зүгээс баримт бичгийг боловсруулах санаачлага гарсан ба хөгжиж буй болон буурай эдийн засагтай улс орнуудын аль алинд нь дунд болон урт хугацаанд үнэлгээ хийлгэх хэрэгцээ нэмэгдэж байгаа ч, мэргэжлийн үнэлгээ хийх туршлага сул, тодорхой стандарт байхгүй байгаа нь ихээхэн бэрхшээлийг учруулж байна. Тиймээс ч, энэхүү АРФЭС төслийн зорилго нь улс орнуудыг өөрсдийн үндэсний үнэлгээний стандартын ерөнхий хүрээг боловсруулахад нь дэмжлэг үзүүлэхүйц өргөн хүрээтэй ерөнхий тогтолцоог санал болгоход чиглэж байна.

IRIM судалгааны хүрээлэн нь Монголын Үнэлгээний Сүлжээг байгуулах санаачилгыг эхлүүлсэн бөгөөд үнэлгээний чиглэлээр ажилладаг, үнэлгээний санал санаачилгыг дэмжигч оролцогч талуудыг нэгтгэх зорилготой юм. Энэхүү сүлжээ нь АСЕАН бүсийн үнэлгээний стандартын хүрээг Монголд нэвтрүүлж, нутагшуулах төслийг Малайзын Үнэлгээний Холбоо болон Вьетнамын Хяналт, Шинжилгээ Үнэлгээний Сүлжээтэй хамтран хэрэгжүүлэх гол тал болж байна. Энэхүү төсөл нь мөн АСЕАН-ы үнэлгээний хүрээнд суурилан Монголын Үнэлгээний Стандартын хүрээг боловсруулах зорилготой юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН:

Монголын Үнэлгээний Сүлжээ нь АСЕАН бүсийн үнэлгээний стандартын хүрээг Монголд нэвтрүүлж, нутагшуулах төслийн хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулсан ба уулзалтанд дараах оролцогч талууд хамрагдсан.

- Монголын үнэлгээний сүлжээний гишүүн, зөвлөхүүд
- Засгийн газрын төлөөлөгчид
- Төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид
- Байгууллагууд болон их сургуулиудын төлөөлөгчид
- Үнэлгээний чиглэлээр бие даан судалгаа явуулдаг зөвлөхүүд

ҮР ДҮН:

АСЕАН бүсийн үнэлгээний стандартын хүрээг Монголд нэвтрүүлж, нутагшуулах төслийн хэлэлцүүлэг уулзалтын хүрээнд АРФЭС баримт бичгийн бүлэг тус бүр дээр хэлэлцэж оролцогч талуудаас маш үнэ цэнэтэй, бүтээлч саналуудыг авсан. Уулзалтын үеэр гарсан саналын дагуу Монголын Хяналт Шинжилгээний Хүрээний эхний хувилбарыг боловсруулсан. Уулзалтын явцад оролцогч талуудаас дараах үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж гаргасан.

- Монголын үнэлгээний сүлжээг өргөжүүлэх, үйл ажиллагааг тогтмолжуулах
- Үнэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон, төрийн бус байгууллага, бие даасан судлаачидын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
- Хэлэлцүүлгийн явцад гарсан (АРФЭС) баримт бичигтэй холбоотой саналуудыг хэлэлцэж (АРФЭС) баримт бичгийг батлах
- Монголын үнэлгээний сүлжээний орчинг боловсронгуй болгох

ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД

НҮҮРСНЭЭС НИЙЛЭГ БАЙГАЛИЙН ХИЙ ГАРГАН АВАХ ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХ ТӨСЛИЙН БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

“ГрийнТрендс” ХХК

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн бүс дэх сум, дүүргийн эдийн засаг, дэд бүтэц, нийгмийн хөгжлийн өнөөгийн төлөв байдал болон төслийн хууль эрх зүйн зохицуулалтыг судална. Судалгааны хүрээнд дараах гол зорилтуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэхэд тавигдах шаардлагууд, хууль, эрх зүйн орчныг судална
- Төслийн бүсийн сумдын эдийн засгийн хөгжил, чадавхи, өнөөгийн түвшинг тодорхойлох
- Төслийн бүсийн сумдын хүн ам зүй, нийгмийн үйлчилгээний түвшинг тодорхойлох




2016

5-р сар

2016

8-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Төслийн судалгаа нь Төв аймгийн Баян сум, Говьсүмбэр аймгийн Шивээговь сум, Дундговь аймгийн Сайнцагаан сум, Улаанбаатар хотын Багануур дүүргийг хамарсан.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Дэлхийн Банкнаас санхүүжилттэйгээр хэрэгжүүлж буй “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих” төсөл (УУДБХОДТ)-ийн гол зорилго нь дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн, түлш, эрчим хүч, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг үл харгалзан нэмүү өртөг шингэсэн үйл ажиллагааг дэмжих болон дэд бүтцийн төслүүдийн бэлтгэлийг хангах, хэрэгжүүлэхэд дотоодын чадавхийг сайжруулах зорилгоор дэд бүтцийн төслүүдийн хөрөнгө оруулалтыг дэмжих юм.

Нүүрснээс Нийлэг Байгалийн Хий (НБХ) гарган авах үйлдвэр нь түүхий хүрэн нүүрсний үнэ цэнийг нэмж, Монгол улсын эдийн засгийн чадамжийг дээшлүүлэх, Улаанбаатар хотын иргэдийн эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж буй агаарын бохирдлыг шийдвэрлэх, дотооддоо хийн түлшний эх үүсвэртэй болох, импортыг багасгаж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой. НБХ гарган авах төсөл эхрэгсэнээр бүс нутгийн болон орон нутагт байгаль орчин, нийгмийн асуудлуудад үзүүлэх нөлөөллийг судалж холбогдох мэдээллийг ТЭЗҮ-д тусгаснаар төслийн хөрөнгө оруулалт, түүний шийдвэр гаргахад чухал шаардлагатай бүх мэдээлэл, эдийн засгийн үнэлгээний үзүүлэлтүүдийг агуулсан байх ёстой.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Энэ төслийн арга зүй хэд хэдэн хэсгээс бүрдсэн болно.

1. Баримт, бичгийн судалгаа
Дүн шинжилгээ хийхдээ дараах гурван гол хүрээг хамарсан:
 - Төслийн хамрах хүрээний аймаг, сумын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүд
 - Төслийн хамрах хүрээний орон нутгийн хөгжлийн стратеги төлөвлөгөө, аймаг, сумын жилийн тайлан
 - МУ-ын уул уурхайн бодлого, бүс нутгийн хөгжил, салбарын бодлого, эрх зүйн шинжилгээ
2. Ганцаарчилсан ярилцлага
 - Холбогдох яам болон төслийн холбогдох талуудтай ярилцлага, уулзалтууд хийсэн.
3. Статистик шинжилгээ
 - Улсын бүртгэлийн ерөнхий газрын статистикийн албан ёсны эх сурвалж, аймаг, нийслэл, сум, дүүргийн статистик мэдээлэлд шинжилгээ хийсэн.

ҮР ДҮН, ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Мэдээллийг захиалагч байгууллагын зөвшөөрөлгүйгээр нийтлэх боломжгүй тул энэ хэсгийн мэдээллийг оруулаагүй болно.

МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн гол зорилго нь геологи, уул уурхайн салбар дахь шийдвэр гаргалтын үе шатууд дахь авлигын эрсдлийг тодорхойлж, нарийвчилсан үнэлгээ хийх юм.




2015

11-р сар

2016

6-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



*Төсөл Сэлэнгэ аймгийн Мандал сум, Өмнөговь аймгийн Цогтцэций сум болон
Улаанбаатар хотод хэрэгжсэн.*

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын эдийн засагт томоохон байр суурь эзэлдэг уул уурхайн салбар нь ил тод, хариуцлагатай, авлигаас ангид байх нь туйлын чухал юм. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа, авлигын эрсдэлийг системтэй судалсанаар авлигаас урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй арга хэмжээ авах боломжтой болно. Энэ нийгмийн хэрэгцээ шаардлагад үндэслэн IRIM судалгааны хүрээлэнгийн судалгааны баг уул уурхайн үйлдэрлэлийн хайгуулын үе шат, ашиглалтын өмнөх, ашиглалтын, хаалтын үе шат гэсэн 4 шат дахь авлигын эрсдэлийг тодорхойлох судалгааг гүйцэтгэлээ.

Төслийн хэрэгжүүлэхдээ НҮБХХ-өөс боловсруулсан “Олборлох салбар дахь авлигын эрсдэлийг бууруулах” олон улсын аргачлалыг ашигласан. Энэ удаагийн төслөөс өмнө ижил зорилгоор авлигын эрсдэлийг тодорхойлсон судалгаа хийгдээгүй байна. Уг салбарын авлигын эрсдэлтэй холбоотой дүгнэлтүүд нь олон нийтийн санал бодлын судалгаанд үндэслэсэн болно.

ТӨСЛИЙН ДИЗАЙН:

Төслийг гүйцэтгэхдээ “Олборлох салбар дахь авлигын эрсдэлийг бууруулах” аргачлалд заасан дараах 5 алхмыг баримтласан. Үүнд:

- Авлигын эрсдэлийн үнэлгээний төлөвлөгөөг боловсруулах
- Мэдээлэл цуглуулах
- Авлигын эрсдэлийг тодорхойлох мэдээлэл цуглуулах
- Үр дүнг баталгаажуулах
- Авлигын эрсдэлийг бууруулах арга хэмжээг боловсруулах

Уул уурхайн олборлолт хийгдэж байгаа байршил, зөвшөөрлийн тоогоор тэргүүлж байгаа Сэлэнгэ, Өмнөговь аймгуудын нутаг дахь 2 суманд ганцаарчилсан ярилцлага болон баримт бичгийн аргаар судалгааны мэдээллийг цуглуулсан. Оролцогч талууд болох төрийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, уул уурхайн компаниудын төлөөллүүдтэй нийт 43 ярилцлагыг зохион байгуулсан. Ганцаарчилсан

ярилцлагын зорилго нь уул уурхайн салбарын өнөөгийн нөхцөл байдал, оролцогч талуудын санал бодол, байр суурь, болзошгүй авлигын эрсдэлүүд, авлигын эрсдэлийг бууруулах стратеги боловсруулах явдал юм. МУ-ын “Ашигт малтмалын тухай хууль” (2006) болон холбогдох эрх зүйн баримт бичгүүдэд үндэслэн, оролцогч талуудыг тодорхойлсон. Баримт бичгийн судалгааны хүрээнд салбарын болон орон нутгийн хууль, эрх зүйн зохицуулалтууд, эрх зүйн болон бодлогын 70 гаруй баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийсэн.

ҮР ДҮН:

Судалгааны баг нийт 15 төрлийн авлигын эрсдэлийн үнэлгээг тодорхойлсон. Олонхи эрсдэлүүд нь тодорхой холбогдох шийдвэр гаргагчдад шийдвэр гаргах явцад нь хууль бусаар нөлөөлөлөхтэй холбоотой эрсдэлүүд байна. Эдгээр эрсдэл нь гол төлөв байгууллага хоорондын мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломж дутмаг, бүтэц үүрэг давхардсантай холбоотой байна. Энэ шалтгаанууд нь цаашид уул уурхайн компаниудыг энэхүү төвөгтэй асуудлуудыг хурдан шийдвэрлүүлэхийн тулд авлига өгөх болзошгүй эрсдэл рүү дагуулж байна.

Уул уурхайн компаниуд нь зөвшөөрөл авах, хяналт шалгалтын үйл явцын талаар мэдлэг, мэдээлэл дутмаг байгаа нь зөвшөөрөл олгох явц дах шийдвэр гаргалтын ил тод бус байдлыг бий болгож байна. Мөн төрийн агентлагуудаас хийж буй хууль бус хяналт шалгалт, дарамтыг даван туулахын тулд, зохих хууль журмын дагуу бус авлигын асуудалд холбогдоход нь нөлөөлж байна.

Геологи хайгуулын шатанд: Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөл (ЭБМЗ) нь өргөдлийн дагуу сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл өгөхдөө компаниудад ашигтай, хурдан шуурхай шийдвэр гаргаж байгаа нь авлига авах эрсдэлийг бий болгож байна. Учир нь энэхүү зөвшөөрөл өгөх үйл явцыг зохицуулах нарийвчилсан хуулийн зүйл заалт болон зохицуулалтууд боловсронгуй бус байна. Эдгээр шийдвэр гаргах үйл явцыг заасан нарийвчилсан зүйл заалт байхгүй байгаа нь авлигын эрсдэлийг бий болгож байгаа нь харагдсан. Ийм зохицуулалт байхгүйн улмаас, шийдвэр

гаргагч талууд шаардлага хангасан компаниудад хайгуулын зөвшөөрлийг олгохгүй байж болох нөхцөл байдал үүсээд байгаа юм.

Ашиглалтын өмнөх үе шатанд: Ашиглалтын өмнөх үе шатанд олон тооны зөвшөөрөл, дүгнэлт гаргуулдаг учраас энэ нь хамгийн их авлигын эрсдэл үүсч болох үе шат болж байна. Юунд түрүүнд, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгож буй төрийн албан хаагчдын ажлын ачаалал их, хэт төвлөрсөн, шийдвэр гаргах үйл явцын ил тод байдал хязгаарлагдмал зэрэг нь аль таатай хандсан уул уурхайн компаниудын зөвшөөрлийг богино хугацаанд олгох нөхцөл байдал руу түлхэж байна.

Хоёрдугаарт, уул уурхайн компаниуд ашигт малтмалын нөөцийн үнэлгээг буруу мэдүүлэх тохиолдол байдгаас ирүүлсэн өргөдлийн талаас илүү хувь нь дахин буцаагддаг байна. Мэргэжлийн инженерүүд цөөн байгаатай холбоотойгоор эрдэс баялгийн нөөцийн үнэлгээг бодитой гаргах, буруу гарсан үнэлгээг илрүүлж, дахин сайжруулах хариуцлагын механизм дутмаг байна.

Гуравдугаарт, эцсийн шийдвэрийг гаргаж буй ЭБМЗ-д хувийн хэвшил, төрийн байгууллага болон төрийн бус байгууллагуудын оролцоо, квот харилцан адилгүй байна. Энэ нь эцэстээ өөрсдийн гэр бүлийн гишүүдэд зөвшөөрөл олгох гэх мэт ашиг сонирхлын зөрчилтэй, шударга бус шийдвэр гарахад нөлөөлж байна.

Ашиглалтын дараах шатанд: Уул уурхайг хаалтын үйл ажиллагааг зохицуулах хуулийн заалт, журмууд тодорхойгүй, хэт ерөнхий байгаа нь компаниудыг нөхөн сэргээлт хийх, орон нутагт уурхайг хүлээлгэн өгөх шатанд хариуцлагаас зайлсхийхэд хүргэж байна. Тухайлбал “Уурхайг түр болон бүрмөсөн хаах журам”-д зааснаар биелэлтийг газар дээр нь хянах хамтарсан комиссийг томилно гэсэн боловч комиссын гишүүдийг хэрхэн томилох, томилогдсон комисс нь ямар удирдамжийн дагуу хяналт, шалгалт хийж акт үйлдэх талаар нарийвчлан заагаагүй эсвэл үүнийг зохицуулах журам алга байна.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ:

Нэгдүгээрт, уул уурхайн үйл явцад оролцож буй олон яам, агентлагууд байгаа ба эдгээр үндэсний болон орон нутгийн оролцогч талуудын хооронд мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг сайжруулах, тогтмол идэвхитэй ашиглах, нэгдсэн мэдээллийн систем үүсгэх нэн шаардлагатай байна. Энэхүү систем дутмаг байгаа нь байгууллагуудын хооронд зөрчил үүсгэж, өөр хоорондоо нийцгүй үйл ажиллагаа явуулахад нөлөөлж байна. Мөн, энэхүү асуудлын хүрээнд мэдээллийн менежмент болон тайлагналттай холбоотой сургалтуудыг төрийн албан хаагчдын дунд зохион байгуулах шаардлагатай байна.

Хоёрдугаарт, уул уурхайн салбарын байгууллагуудын засаглал болон ил тод байдлыг сайжруулах шаардлагатай. Онцлон дурдвал ил тод байдал ба засаглалын байдал нь дутмаг буй байгууллагын нэг нь ЭБМЗ юм.

Гуравдугаарт, зөвшөөрөл олгох үйл явцад тодорхой, нарийвчилсан зохицуулалтыг бий болгож, ил тод байдлыг нь хангах арга хэмжээ авах шаардлагатай. Мөн ашиг сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргагчдыг шийдвэр гаргах бүтэц, бүрэлдэхүүнд орохоос урьдчилан сэргийлэх шаардлагатай.

Бидний боловсруулсан энэхүү тайлан нь олборлох салбар дахь авлигын эрсдэлийг тогтмол үнэлж, хянах суурь судалгаа бол байгаа тул дүгнэлт, санал зөвлөмжид үндэслэн, авлигын эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг боловсруулан холбогдох яамдын ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь Авлигатай Тэмцэх Газраас авлигыг бууруулах чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон иргэний нийгмийн байгууллагуудын олборлох салбар дахь ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн санал санаачлагуудад дэмжлэг болох юм.

БИЧИЛ УУРХАЙ БҮХИЙ АЙМГУУДЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД БИЧИЛ УУРХАЙГААС ОРУУЛЖ БУЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД БИЧИЛ ҮЗҮҮЛЖ БУЙ ХӨРӨНГӨ НӨЛӨӨЛӨЛ: ДАВТАН СУДАЛГАА



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү судалгаа нь Тогтвортой Бичил Уурхай (ТБУ) төслийн зорилтот аймгууд дахь хувираа ашигт малтмал олборлогч болон ашигт малтмалын худалдаачдын орон нутгийн эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийг тодорхойлох зорилготой. Энэ удаагийн давтан судалгааны үр дүнг 2015 онд хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулан өөрчлөлтийг үнэлэх юм. Ингэхдээ дараах шалгуур үзүүлэлтээр нарийвчлан мэдээлэл авахыг зорьсон юм. Үүнд:

- Бичил Уурхай эрхлэгчид (БУЭ) ба ашигт малтмалын худалдаа эрхлэгч (АМХЭ)-дийн орон нутгийн эдийн засагт үзүүлж буй хувь нэмэр
- БУЭ-ийн зүгээс орон нутагт хийж буй хөрөнгө оруулалтын төрөл, эзлэх хувь хэмжээ
- БУЭ-ийн зүгээс үзүүлж буй нөлөөллийн үр шимийг хүртгэгчид
- БУЭ-ийн орлогыг төрөлжүүлэх боломж




2016

10-p cap

2016

12-p cap

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Төслийн судалгааг 8 аймгийн 15 сумыг хамарч хийсэн. Үүнд: Баянхонгор (Баян-Овоо, Бөмбөгөр), Дархан-Уул (Шарын гол), Дорноговь (Айраг), Дундговь (Хулд, Өлзийт), Говь-Алтай (Есөнбулаг), Ховд (Булган, Цэцэг, Үенч), Сэлэнгэ (Мандал), Төв (Заамар, Борнуур), Увс (Тариалан, Өмнөговь)

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Тогтвортой бичил уурхай төслийн зорилго нь зорилтот аймгууд дахь хувиараа ашигт малтмал олборлогч болон ашигт малтмалын худалдаачдын орон нутгийн эдийн засагт үзүүлж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх юм. ТБУ төсөл нь 2005 оноос хойш хэрэгжиж байгаа бөгөөд одоо төслийн 4 дэх үе шат хэрэгжиж байна. Энэ төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зорьж байна. Үүнд:

- Улсын БУЭ-ээс авдаг үнийн дүнг нэмэгдүүлэхийн тулд нийлүүлэлтийн сүлжээг албажуулах
- БУЭ болон АМХЭ-ийг өргөнөөр хамруулах уян хатан нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, бүх холбогдох талуудыг албажуулах
- БУЭ болон АМХЭ-ийн бизнес загварыг бий болгож бусад орлогын эх үүсвэрийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

- БУЭ болон АМХЭ-ийнг дэмжих замаар тэдний орон нутгийн эдийн засагт оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх

БУЭ-ийн эдийн засаг дахь хувь нэмэрийн суурь судалгааг 2015 онд ИРИМ судалгааны хүрээлэн нь хэрэгжүүлсэн. Цаашид ТБУ төслийн үнэлгээг жил тутам хийхээр төлөвлөж байгаа бөгөөд 2016 оны давтан судалгаа нь анхны судалгаа болж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны дизайн нь “өмнөх болон дараах” үнэлгээний төрөлд суурилсан.

1. Мөн 2015 онд хийгдсэн төслийн суурь судалгааг хэрэгжүүлэхэд ашигласан арга зүйг энэ удаагийн давтан судалгаанд ашигласан бөгөөд тодорхой хугацааны дараа яг ижил аргачлалаар судалгааг

давтан хийж, төслийн явцад гарсан ахиц, өөрчлөлтийг үнэлэх зорилготой юм.

2. Бичил уурхайн салбарын талаарх үндэсний болон орон нутгийн хэмжээний хоёрдогч тоон мэдээлэл ховор тул бид тус салбарын оролцогч талуудыг түүвэрлэн, анхдагч тоон мэдээллийг хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар цуглуулсан. Тус ярилцлагыг 2016 оны 11 дүгээр сард сонгон авсан 9 аймагт хийсэн. Судалгааны мэдээллийг хагас бүтэцлэгдсэн ярилцлага хэлбэрээр цуглуулсан. Судалгаанд албан болон албан бус бичил уурхай эрхлэгчид (147), малчид (50), жижиг дунд бизнес эрхлэгчид (33), ашигт малтмалын худалдаачид (28) болон бичил уурхайчдын төрийн бус байгууллагууд (16) болон 17 сумын захиргааны албан хаагчид хамрагдсан.

Судалгаанд хамрагдагчдыг сонгохдоо дараах арга зүйг баримталсан. Үүнд:

- Бичил уурхай эрхлэгчид: Тухайн сумын бичил уурхай дээр үйл ажиллагаа явуулж буй иргэдээс санамсаргүй түүврээр сонгон мэдээлэл авсан.
- Ашигт малтмалын худалдаачид: Орон нутгийн ТББ-уудын тусламжтайгаар ашигт малтмалын худалдаа эрхлэгчидтэй холбоо тогтоон ярилцлага хийсэн.
- Орон нутгийн бизнес эрхлэгчид: Бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газарт болон түүнтэй ойролцоо жижиг дэлгүүр, худалдаа эрхлэгч зэрэг бизнес эрхэлж буй иргэдээс сонгон ярилцлага хийсэн.
- Малчид: Бичил уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газар нутагт хамгийн ойр амьдарч буй малчдыг сонгон судалгаа авсан.
- Бичил уурхай эрхлэгчдийн ТББ: Зорилтот сум бүрээс нэг ТББ-ыг сонгосон. Монголын Бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбооноос (МБУНДХ) ТББ-ын дэлгэрэнгүй мэдээллийг авсан.
- Төрийн байгууллагын ажилтнууд: Сумын ЗДТГ-т судалгааны танилцуулга, шаардлагатай мэдээллийг өгч, судалгаанд хамрагдах төрийн албан хаагчдыг томилуулсан.
- Судалгааны баг орон нутгийн удирдлага болон төрийн бус байгууллагуудаас бүрдүүлсэн мэдээлэлд баримт бичгийн судалгааг хийн ажилласан.

ҮР ДҮН

Судалгаан хамрагдсан сумууд дахь БУЭ-ийн эдийн засгийн хувь нэмэр 10.4 тэрбум төгрөг байгаа ба 2016 оны давтан судалгаагаар 7.9 тэрбум дахин буюу 18.3 тэрбум төгрөг болж өссөн байна. Энэ өсөлтийн 5.9 тэрбум төгрөг нь судалгааны түүвэрт нэмэгдсэн сумдын хувь нэмэртэй холбоотой бол 1.9 тэрбум төгрөг нь үйл ажиллагааны хүрээнээс хамааралтай өсөлтийг зааж байна. Зорилтот сум дахь эдийн засгийн үржүүлэгч нь 1.64-өөс 1.68 болж өссөн байна.

Шууд хувь нөлөө: Суурь судалгаа болон давтан судалгааны хүрээнд судалгаанд оролцогчдоос АМНАТ болон орон нутгийн удирдлагад төлдөг тодорхойгүй зардлыг тодруулах асуултуудыг асуусан. “Төсвийн тухай хууль”-д зааснаар, тухайн орон нутгаас гарсан ашигт малтмалын орлогын тодорхой хувийг орон нутагт хуваарилагдах ба Орон Нутгийн Хөгжлийн Сангийн хөрөнгөд шилжүүлдэг. Гэвч АМХ-ын Монгол Банканд тушааж буй алтны гарал үүсэл тодорхойгүй, тодорхойлох боломжгүйн улмаас АМНАТ-ийн тодорхой хувь нь тухайн сумын Орон нутгийн хөгжлийн санд хуваарилагдаж чаддаггүй байна. Энэ нь бичил уурхайн албан ёсны нийлүүлэлтийн сүлжээний оролцогч талуудын эдийн засгийн чадавхийг бэхжүүлэхэд нэг том бэрхшээл учруулж байна. Энэ нь БУЭ-дийн орон нутгийн эдийн засагт оруулж буй шууд нөлөөг дутуу тооцоход хүргэж байна.

БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд хувь нэмрийг сум бүрээр нэгтгэн харууллаа. Давтан судалгаанд хамрагдсан 15 суманд үйл ажиллагаагаа явуулж байгаа нийт БУЭ болон АМХЭ нар 1.013 ажлын байр бий болгож, сард ойролцоогоор 218.7 сая төгрөгийн орлогыг бичил уурхайн үйл ажиллагаанаас олж, 91.3 тэрбум төгрөгийг цалин олголтонд зарцуулж, 7.3 тэрбум төгрөгийн татвар төлсөн байна. Нийтдээ 317.3 тэрбум төгрөгийн шууд хувь нэмрийг орон нутгийн эдийн засагт оруулсан байна.

Суурь судалгаатай харьцуулахад БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулах шууд хувь нэмэр сумдын түвшинд 207.1 сая төгрөгөөс 317.4 сая төгрөг болж өссөн байна. Энэхүү өсөлтийн 10.44 сая нь судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумдын БУЭ болон АМХЭ-дийн хувь нэмэр бол үлдсэн 1.5 тэрбум нь суурь судалгаанд хамрагдсан сумдын БУЭ болон АМХЭ-дийн тооны өөрчлөлтөөс үүдэлтэй бол 110.9 сая төгрөг

нь суурь судалгаанд хамрагдаж байсан арван сумд өсөлттэй байгааг харж болно.

Шууд бус хувь нэмэр: БУЭ болон АМХЭ-дэд бүтээгдэхүүнээ нийлүүлснээр судалгаанд хамрагдсан 15 суманд үйл ажиллагаагаа явуулж байгаа нийт бизнес эрхлэгчид 1013 ажлын байр бий болгож, сард 91.3 сая төгрөгийг ажилчдын цалинд зарцуулж, сард 218.7 сая төгрөгөөр худалдан авалт хийж, 7.3 сая төгрөгийг татварт төлж байна. Нийтдээ тэд сард 317.4 сая төгрөгийг зарцуулж байгаа бөгөөд энэ нь БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмэр юм.

Суурь судалгаатай харьцуулахад БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулах шууд бус хувь нэмэр сумдын түвшинд 1.5 дахин буюу 110.3 сая төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлт нь бүхэлдээ давтан судалгаанд шинээр нэмэгдсэн 5 сумын БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулж буй шууд бус хувь нэмэр юм. Харин суурь судалгаанд хамрагдсан сумдын БУЭ болон АМХЭ-дийн эдийн засагт оруулах шууд бус хувь нэмэр суурь судалгаанаас 36 орчим саяар буурчээ.

Дам нөлөө: Судалгаанд хамрагдсан 15 сумын БУЭ, АМХЭ болон малчин өрхүүд нийтдээ 7.1 тэрбум төгрөгний зарцуулалтыг хийсэн бол үүний дийлэнхи хувь болох 5.6 тэрбум төгрөгийн зарцуулалтыг БУЭ болон АМХЭ-дийн өрхийн зардал эзлэж байна.

Эдийн засгийн үржүүлэгч: Давтан судалгаанд хамрагдсан 15 сумын нийт БУЭ болон АМХЭ-дийн эдийн засгийн нөлөө ба үржүүлэгч нь 18.3 тэрбум төгрөгийн сард бий болгодог бөгөөд үүний 10.9 нь орон нутгийн эдийн засагт татвар, төлбөр, ажил эрхлэлт болон орлого болж ордог байна. Үүнээс гадна, 317.4 сая төгрөг нь БУЭ, АМХЭ-ийн бараа, бүтээгдэхүүний борлуулалт, үйлчилгээ зэргээс үүдэлтэй байдаг бол 7.1 нь БУЭ, АМХЭ болон малчдын өрхийн хэрэглээний зарцуулалтаар шууд бус байдлаар ордог байна. Эдгээр сумдад үйл ажиллагаагаа явуулж буй нийт БУЭ болон АМХЭ-дийн хувьд тэдний бий болгосон 1 төгрөг эдийн засагт 1.68 төг болон үржигдэн орсон байна.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Төслийн давтан судалгааны үр дүнд үндэслэн дараахи дүгнэлт, санал зөвлөмжийг судалгааны баг хийж байна.

Нэгдүгээрт, албан бус БУЭ байгаа хүмүүсийн үйл ажиллагаа нь орон нутгийн эдийн засагт нөлөө багатай байгаа ба тул БУЭ-г албажуулах буюу төрийн байгууллага, ТББ-ын бүртгэлд хамруулах үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай. Ялангуяа, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй БУЭ-ийн бүртгэл, ТББ-аар дамжуулан төлсөн татварын дүн зэрэг мэдээлэл хангалтгүй байна.

Хоёрдугаарт, АМХЭ-д ноогдуулсан албан татварын тодорхой хувийг тухайн ашигт малтмал олборлосон сумын Орон Нутгийн Хөгжлийн санд орох ёстой ч АМХЭ-д албан ёсоор байгуулагдаагүй байгаагаас сумын бодит хөрөнгө оруулалт болж чадахгүй байна. Иймд орон нутгийн АМХЭ-дийг албажуулах, төрийн ба ТББ-ын бүртгэлд хамруулах ажлыг зохион байгуулах хэрэгтэй. Ингэснээр зөвхөн АМХ-аас авах татвар, хураамжийн орлого нэмэгдээд зогсохгүй албан бус БУЭ-дийн үйл ажиллагааны хяналт, хариуцлага дээшилнэ.

Гуравдугаарт, БУЭ, АМХЭ-дийн олборлолт, борлуулалтын үйл ажиллагаанд шаардлагатай материал, тоног төхөөрөмж, түүхий эдийг тухайн сумын бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүдээс ханган нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах, хамтын ажиллагааг бий болгох шаардлагатай байна гэж үзэж байна..

МОНГОЛЫН ИНСТИТУЦИЙН ӨӨРЧЛӨЛТ ХИЙХ ЗАМААР ТӨРИЙН ЭРДЭС БАЯЛГИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ САНААЧЛАГА ТӨСЛИЙН СУУРЬ СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (CESO)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (CESO) - аар удирдан Канадын дэлхийн их сургууль (WUSC) - тай хамтарч "Институцийн өөрчлөлт хийх замаар төрийн эрдэс баялгийн менежментийг сайжруулах санаачлага" төслийн эхлэхээс өмнөх суурь нөхцлийг тодорхойлох явдал юм.




2016

10-p cap

2016

12-p cap

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Төслийн судалгааг 8 аймгийн 15 сумыг хамарч хийсэн. Үүнд: Баянхонгор (Баян-Овоо, Бөмбөгөр), Дархан-Уул (Шарын гол), Дорноговь (Айраг), Дундговь (Хулд, Өлзийт), Говь-Алтай (Есөнбулаг), Ховд (Булган, Цэцэг, Үенч), Сэлэнгэ (Мандал), Төв (Заамар, Борнуур), Увс (Тариалан, Өмнөговь)

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (CESO) - аар удирдан Канадын дэлхийн их сургууль (WUSC) - тай хамтарч консорциум байгуулан Монгол Улсын Засгийн Газарт туслах зорилгоор Канад Улсын Засгийн газрын санхүүжилттэй "Институцийн өөрчлөлт хийх замаар төрийн эрдэс баялгийн менежментийг сайжруулах санаачлага" ТЭБМСС (MERIT) төслийн боловсруулалт болон хэрэгжилтийг Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (буюу CESO) удирдан явуулах ба эдгээрт: 1) Уул уурхайн яам, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам, Ашигт малтмалын газар, Монгол Улсын газрын тосны газар болон Монгол Улсын уул уурхайн үндэсний ассоциаци зэрэг стратегийн ач холбогдолтой уул уурхайн гол байгууллагуудын уялдаа холбоо, удирдлагын чадавхийг сайжруулах; 2) уул уурхайн салбарт хамааралтай төрийн байгууллагууд (төв, аймаг, сумын түвшинд), иргэний нийгмийн

байгууллагууд болон орон нутгийн иргэдийн хооронд үр дүнтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх; 3) төрийн байгууллагуудын сургалтын чадавхийг нэмэгдүүлэх. Энэхүү төсөл нь 2016 оноос 2020 он хүртэл үргэлжлэх, урт хугацааны төсөл юм.

Энэхүү төслийн хугацаанд дурьдсан яам, агентлаг, байгууллагуудад дэмжлэг үзүүлэх, манай төслийн үйл ажиллагааны үр дүнтэй хэрэгжилтийг урт болон богино хугацаанд хангаж ажиллахын тулд манай Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг энэхүү төслийн харилцан боловсруулсан зорилго, зорилтын эсрэг ахиц дэвшил гарах эсэхийг хэмжиж ажиллах болно.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Суурь судалгааг явуулахдаа чанарын болон тоон аргыг аль алийг нь ашигласан. Захиалагчийн боловсруулж санал болгосон судалгааны

хэрэглэгдэхүүнийг IRIM Монгол хэлрүү хөрвүүлэн энэхүү төслийн суурь судалгаанд ашигласан. Судалгааны зорилтот бүлгүүдээс хамааран мэдээлэл цуглуулах даа дараах аргуудыг ашигласан.

- Дээр дурьдсан яам, агентлагуудын албан хаагчдаас мэдээлэл цуглуулахдаа 20-н хаалттай асуулттай асуумжийг ашиглан ганцаарчилсан ярилцлага хийсэн. Эхний 10-н асуулт нь эдгээр байгууллагын менежментийн асуудлууд, дотоод харилцаа, болон мэдээлэл солилцох талаар байсан бол дараагийн 10-н асуулт нь агентлаг хоорондын холбоо, харилцаа, уялдаа холбоотой байдлын талаар байсан.
- Харин Удирдлагын Академийн багш нартай хийсэн асуумж нь Удирдлагын Академийн үйл ажиллагаа, нөөцийн хүртээмжтэй байдал болон нөөцийн боломжит байдалтай холбоотой асуудлыг хамарсан 3-н хаалттай асуулт болон чанарын стандарт, сургалтын хэрэгцээ, мэргэжлээрээ ахиж дэвших асуудлыг хөндсөн 7 нээлттэй асуулттай асуумжаар судалгаа авсан. Тэнхимийн багш нартай хийсэн ярилцлага бүр 30 минутаас нэг цаг үргэлжилсэн.
- Удирдлагын Академийн богино сургалтын төгссөн төгсөгчдөөс судалгааг утсаар авсан. Энэхүү судалгаанд Монголын өнцөг булан бүрээс төрийн албан хаагчид ирж хамрагддаг. Асуумж нь 3-н хэсгээс бүрдэх ба хөтөлбөрийн сонголтын хүрэлцээтэй байдал, боломжит байдлыг, өөрийн хамрагдсан хөтөлбөр дээр үндэслэн сургууль болон хөтөлбөрийн чанартай байдлыг 1-5-н оноогоор үнэлсэн. Нэг респонденттой хийх судалгаа ойролцоогоор 15-20 минут үргэлжилсэн.
- Хэдийгээр захиалагчийн зүгээс бүх судалгаанд үечилсэн түүврийн аргыг хэрэглэхийг санал болгосон ч респондентын онцлогоос шалтгаалан судалгааны түүврийн өөрөөр аргыг ашигласан. яам, агентлагуудын ажилчид болон Удирдлагын Академийн богино сургалтыг төгсөгчидтэй хийх судалгааны респондентыг сонгохдоо энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласан бол Удирдлагын Академийн багш нараас респондентыг сонгохдоо мужилсан буюу

кластер түүврийн аргыг ашигласан.

- Яамд болон агентлагуудын албан хаагчидтай хийсэн ярилцлага
- IRIM зүгээс санал болгосон түүврийн төрлийг Хяналт-Үнэлгээний олон улсын зөвлөх хянаж, эцэслэсэн. Түүврийн хэмжээг тухайн байгууллагын албан хаагчдын тооноос шалтгаалан 5-10%-иар тогтоосон. Нийт 40-н албан хаагчидтай ганцаарчилсан ярилцлага хийх нь түүврийн зорилтот хэмжээндээ хүрч ажилласан. Дараах шалгууруудыг үндэслэн албан хаагчдыг сонгосон. Үүнд:
 - а. Албан хаагчийн менежментийн түвшний эрх мэдлийн байдал,
 - б. Байгууллагыг төлөөлөх чадвар,
 - в. Албан хаагчийн хүйс зэргийг харгалзан үзсэн.
- Удирдлагын Академийн богино сургалтыг төгсөгчидтэй хийсэн ярилцлага
- Удирдлагын Академийн богино сургалтыг төгсөгчид болон багш нарын мэдээллийг Удирдлагын Академийн Мэргэжил Дээшлүүлэх Институтаас авсан хүснэгтэн мэдээлэл дээр үндэслэн сонгосон. 2014-2016 онд Удирдлагын академийн богино сургалтанд хамрагдсан төрийн албан хаагч нийт 1700 байсан бол багш нарын тоо 64 байв. Суралцагчдаас респондентыг сонгохдоо энгийн санамсаргүй түүврийн аргыг ашигласан бол богино сургалтын төрөл нь 60 гаруй болж байсан учраас багш нарыг сонгосон мужилсан буюу кластер түүврийн аргыг ашигласан. Боломжит 64-н багшаасаа менежментийн хичээл заадаг багш нарыг эхлээд сонгосны дараа тэдгээрээс уул уурхай, байгаль орчин, удирдахуйн ухааны хичээл ордог багш нарыг сонгон ганцаарчилсан ярилцлага хийсэн. Ингэхдээ тухайн багшийн ажилласан жил болон хүйсийг харгалзан үзсэн.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Тус судалгааны нууцлалын шалтгаанаас үүдэн судалгааны үр дүнг олон нийтэд харуулах боломжгүй.

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

МГТИ
МОНГОЛ-ГЕРМАНЫ АШИГТ МАЛТМАЛ
ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН)

Монгол Германы Ашигт Малтмал, Технологийн Их Сургууль (МГАМТИС)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь МГАМТИС-ийн хичээлийн төлөвлөгөөг үйлдвэрлэлийн хэрэгцээтэй хэр уялдаж байгааг судлах юм. Судалгааны хүрээнд дараах асуудлуудыг судлахыг зорьсон:

1. Бакалавр ба магистрийн хөтөлбөрийн чиглэл
 2. МГАМТИС-аас үзүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн ажил, үйлчилгээний хэрэгцээ
 3. Үйлдвэрийн ажилтнуудад зориулсан мэргэжлийн сургалтууд
 4. Дадлагын оюутны хөтөлбөр байдлын үзүүлэлтээр эрэмбэлж, төрөл тус бүрээр нь жагсаалт гаргах;
- Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.



2016


3-р сар

2016

6-р сар



ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Төслийн судалгаа нь Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Хөтөл, Багануур хот, Говь-Сүмбэр аймагт хийгдсэн.

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж болон ХБНГУ-ын Канцлер Ангела Меркел нар МГАМТИС-ийг байгуулахаар тохиролцсоны үндсэн дээр 2011 оны 11-р сард байгуулагдсан. МГАМТИС нь ашигт малтмал, технологийн инженерийн чиглэлийн мэргэжлийн ангиудтай. Сургалтын зорилго нь манай орны ашигт малтмал, технологийн чиглэлийн үйлдвэрүүдэд хэрэгцээтэй байгаа нарийн мэргэжлийн мэргэжилтнүүдийг бэлтгэх ба урт хугацааны зорилго нь монголын эдийн засгийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулж, үнэ цэнэ нэмэх явдал юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны баг захиалагчтай талтай ярилцан тохиролцсоны үндсэн дээр уул уурхай, хүнд машин механизм, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 60 компанийн удирдлагуудыг судалгаанд оролцуулан мэдээлэл авсан.

ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Мэдээллийг захиалагч байгууллагын зөвшөөрөлгүйгээр нийтлэх боломжгүй тул энэ хэсгийн мэдээллийг оруулаагүй болно.

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ГИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Говийн Оюу хөгжлийг дэмжих сан

ХАМТРАГЧ

Оюу Толгой ХХК

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэ төслийн гол зорилго нь “Говийн Оюу” Хөгжлийг Дэмжих Сангийн алсын хараа, эрхэм зорилго, стратегийн зорилго, зорилт зэрэг стратеги төлөвлөлтийн гол бодлого, баримт бичгийг боловсруулахад санд дэмжлэг үзүүлэх явдал байв.




2016

10-р сар

2016

11-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Улаанбаатар хот, Өмнөговь аймаг

ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

“Оюу Толгой” ХХК нь зэс-алтны уурхайн үйл ажиллагаа эрхлэх Австралийн хамгийн том компаниудын нэг юм. “Оюу толгой” ХХК нь Монголын компани бөгөөд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж “Эрдэнэс Оюу толгой” ХХК болон Канадын Туркойз Хилл Ресурс компаниуд эзэмшиж байна. Туркойз Хилл Ресурс компанийг Рио Тинто компани шууд бусаар эзэмшдэг бөгөөд Рио Тинто нь “Оюу толгой” төслийн менежментийг хариуцдаг.

“Говийн Оюу Хөгжлийг Дэмжих Сан” нь “Оюу Толгой” ХХК-ний түншлэгч сумд болох Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сумдын хөгжлийг дэмжих зорилгоор олгодог сайн дурын санхүүжилтийг хуваарилан зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд гүйцэтгэх захирал, санхүүгийн мэргэжилтэн, төслийн менежерийн бүрэлдэхүүнтэй баг тус санг удирддаг. Хөгжлийг Дэмжих Сангийн үйл ажиллагаанд Оюу Толгой

ХХК болон орон нутгийн удирдлагын төлөөллөөс бүрдсэн Удирдах Зөвлөл хяналт тавин ажиллаж байна. Мөн орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн төлөөлөгчид болон Оюу Толгой ХХК-ны үйл ажиллагаа хариуцсан ахлах менежерүүдээс бүрдсэн Харилцааны Хороо ажиллаж байна. Харилцааны Хорооны үүрэг нь орон нутгаас ирүүлсэн төсөл, хөтөлбөрийн саналыг хянан хэлэлцэж, санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн эрэмбэлэн Хөгжлийг Дэмжих Санд зөвлөмжийн хамт хүргүүлэх явдал юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээний баг нь байгууллагын тулгуур бодлого, төлөвлөлт зэргийг тодорхойлох аргачлалд тулгуурлан боловсруулж, олон талын оролцоотойгоор хэлэлцүүлсэн. Ингэхдээ дараах 5 асуултуудыг баримжаалан зөвлөх үйлчилгээний үр дүнг төлөвлөн ажилласан. Үүнд:

1. “Говийн Оюу” Хөгжлийг Дэмжих Сан гэж ямар байгууллага бэ?
2. Бид одоо хаана байна вэ?
3. Бид хэн байхыг хүсэж байна вэ?
4. Бидэнд ямар асуудал тулгарч байна вэ?
5. Бид хүссэн үр дүндээ хэрхэн хүрэх вэ?

Зөвлөх үйлчилгээний баг үүний тулд гадаад орчны шинжилгээ буюу улс төр, эдийн засаг, нийгэм-соёл, технологи, хууль эрх зүйн орчин, байгаль орчны (PESTLE) шинжилгээ, мөн дотоод орчны SWOT шинжилгээ зэрэг судалгааны аргачлалуудыг ашиглан тулгуур бодлогын эхний хувилбарыг тодорхойлсон. Энэ судалгааны үр дүнгээ Хөгжлийг Дэмжих Сангийн оролцогч талуудыг хамруулах зорилгоор Оюу Толгой ХХК-ны Харилцааны Хороогоор хэлэлцүүлэн сайжруулалт хийж Удирдах зөвлөлөөр батлуулсан юм.

Энэ төслийн хүрээнд ХДС-гийн стратегийн төлөвлөлт, суурийг бий болгох боломжтой болсон юм. Дараагийн алхам нь цаашид сан тогтвортой хөгжих чадавхийг бэхжүүлэх зорилготой дараах зөвлөх үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэхээр төлөвлөөд байна. Үүнд:

- Сангийн холбогдох дүрэм, журмыг сайжруулах, шаардлагатай баримт бичгийг боловсруулах
- Сангийн ажилтнуудын байгууллагын дотоод дүрэм, журмыг хэрэгжүүлэх чадавхитай холбоотой сургалтаар хангах
- Сангийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бий болгох төдийгүй цаашид сан стратегийн зорилгодоо хүрэх боломжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

ҮР ДҮН, ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Дээр дурьдсан үйл ажиллагаагаар дамжуулан ХДС-ийн дараах тулгуур бодлогыг амжилттай тодорхойлсон. Үүнд:

- Байгууллагын мандат
- Алсын хараа
- Эрхэм зорилго
- Баримтлах зарчим
- Стратегийн зорилго
- Стратегийн зорилт
- Гол эрсдэл зэргийг тодорхойлсон.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН ЖЕНДЕРИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДЭД ХИЙСЭН СУУРЬ ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн Монгол дахь Төлөөлөгчийн Газар

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэ судалгаа нь дараах үндсэн зорилгуудыг агуулж байна. Үүнд:

1. Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын 1, 5, 8, 10, 11, 13, 16-д дүн шинжилгээ хийн хүйсээр ангилсан суурь мэдээлэл гарах үзүүлэлтийг тодорхойлж, аль үзүүлэлтийн суурь мэдээлэл хаана бүрдээгүй байгааг тогтоох
2. Одоо баримталж буй арга зүйд тулгуурлан суурь мэдээллийг тодорхойлж, Тогтвортой Хөгжлийн Зорилго (ТХЗ)-ын үзүүлэлтийн дагуу мэдээлэл цуглуулах, боловсон хүчний чадавхитай холбоотой илүү нарийвчилсан санал зөвлөмжийг боловсруулах
3. НҮБ-ын "ТХЗ-ыг нэвтрүүлэх, эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх" хандлагыг ашиглаж Монголд ТХЗ-ын хяналт, тайлагналт болон хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр хийгдэх шаардлагатай ажлуудыг тодорхойлох.



2016

1-р сар

2016

3-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Төсөл Улаанбаатар хотод хэрэгжсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2030 он хүртэлх МУ-ын Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөр нь тогтвортой хөгжлийн 17 зорилгоос бүрдэх бөгөөд 2016 оны 1-р сарын 1-ний өдөр хэрэгжиж эхлэсэнтэй зэрэгцээд Монгол Улс дэлхийн хэмжээний шинэ хөтөлбөрийг өөрийн үндэсний хөгжлийн загвар, төлөвлөгөө болгож буулгах талаар томоохон алхмууд хийгдсэн юм. Тухайлбал бодлого, хууль эрх зүйн орчны хүрээнд УИХ-аас “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль”, “2016-2030 оны Монгол Улсын тогтвортой хөгжлийн урт хугацааны үзэл баримтлал”-ыг тус тус баталсан. Эдгээр баримт бичиг нь Монгол Улсын хөгжлийн бодлого, зорилгуудыг системчлэх, нийцүүлж уялдуулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхээс гадна оролцогч талуудын урт хугацааны тууштай байдал, зөвшилцөл бий болгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Үнэлгээ нь ТХЗ-уудын үнэлгээний хүрээг шалгаж тодруулах, түүний дотор хүйсээр ангилсан суурь мэдээллийн хүртээмж болон дутагдлыг тогтвортой хөгжлийн 7 зорилгын 39 дэд зорилтын 87 үзүүлэлтийг шалгахад чиглэсэн. Түүнчлэн тогтвортой хөгжлийн зорилгуудтай холбоотойгоор дээрх үзүүлэлтүүдийн дагуу суурь мэдээллийг тогтоох, мэдээллийн шинэ эх үүсвэр бий болгох, мэдээлэл цуглуулах аргачлалыг боловсронгуй болгох хэрэгцээг тодорхойлсон. Төгсгөлд нь, энэхүү тайлан Монгол Улсын ТХЗ-уудтай холбоотой хяналт, тайлагналт, хариуцлагыг улам бэхжүүлэх, НҮБ-аас гаргасан “Нэвтрүүлэх, эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх хандлага”-ыг ашиглах ямар боломжууд байгааг тодорхойлсон.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны хүрээнд чанарын болон баримт бичгийн шинжилгээг хийсэн. Үнэлгээний үр дүнд тулгуурлан ТХЗ-ын суурь мэдээллийг бүрдүүлэх санал, зөвлөмжийг НҮБ-аас гаргасан “Нэвтрүүлэх, эрчимжүүлэх, бодлогын дэмжлэг үзүүлэх” хандлагын хүрээнд боловсруулсан.

- Үнэлгээнд хамаарах жендэрийн холбогдолтой үзүүлэлт тус бүрээр суурь мэдээллийг цуглуулах, тоон мэдээлэл дээр тулгуурлан суурь мэдээллийг тодорхойлох аргачлал
- Мэдээлэл гарах өөр эх сурвалжуудыг тогтоож, холбогдох бэрхшээл болон боломжуудыг тодорхойлох
- Монголд ТХЗ-тай холбогдох мэдээлэл цуглуулалт, менежмент болон хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах талаар зөвлөмж боловсруулсан.

Үнэлгээг хийхдээ зургаан үндсэн шалгуурыг авч үзсэн ба үүнд, цаг үеийн байдал, харьцуулгадахуйц байдал, нөөцийн хүрэлцээ, технологи, хүртээмж, мэдээлэл болон тайлангийн ашиглагдахуйц байдал гэсэн шалгууруудыг баримталсан.

ҮР ДҮН

Хүйсээр ангилсан мэдээлэл болон жендэртэй холбоотой мэдээллийн хувьд тухайн үзүүлэлтийн зорилго болон статусаас хамаарч өөр өөр байв. Суурь мэдээлэл нь бүрдсэн эсвэл тодорхой хүчин чармайлтын дүнд мэдээллүүдийн ихэнх нь хүйсээр ангилагдсан байв. Харин мэдээлэл бэлэн бус үзүүлэлтийн хувьд хүйсээр ангилсан мэдээллийг цуглуулах боломж хязгаарлагдмал байсан бөгөөд улмаар мэргэжлийн зөвлөгөө авах, талбарын ажил гүйцэтгэх, мэдээллийн дүн шинжилгээний зардал гаргах гэх мэтээр илүү их хүчин чармайлт шаардаж байв. Үзүүлэлтийн нэг гол бэрхшээл нь өөр өөр шалгуураар задалсан явдал байв.

ҮНДЭСНИЙ ХЯНАЛТЫН БОЛОН ХАРИУЦЛАГЫН МЕХАНИЗМ

Тогтвортой Хөгжлийн Зорилготой холбоотой тайлагнах, мэдээлэл цуглуулах, удирдах болон жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл зарим талаараа бүрдсэн байна. Тухайлбал, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн урт

хугацааны үзэл баримтлал”, “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль” болон ЗГ-ын 322-р тогтоол нь Монгол Улсад хяналтын болон хариуцлагын механизмд шаардлагатай зүйл заалтуудыг агуулжээ. Гэсэн хэдий ч ЗГ-ын бүтцийн өөрчлөлт, бодлогын өөрчлөлт, санхүүгийн болон боловсон хүчний тогтворгүй байдал нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын тайлагналт, хэрэгжүүлэлт, мэдээллийн удирдлагад сөрөг нөлөө үзүүлсээр байна. Мөн хуулийн хэрэгжилт сул байгаа нь үр дүнтэй хариуцлагын механизмд саад бэрхшээл учруулж байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГЫГ ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАЖ, УЯЛДУУЛАХ

Тогтвортой Хөгжлийн Зорилготой холбоотой тайлагнах, мэдээлэл цуглуулах, удирдах болон жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн байгаа тул хууль эрх зүйн болон бодлогын томоохон шинэчлэл шаардлагагүй нь тогтоогдсон.Тухайлбал, Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого, холбогдох ЗГ-ын тогтоол, үндэсний хөтөлбөр болон санаачлагууд нь тогтвортой хөгжлийн зорилгуудын хяналт, үнэлгээний зарчим болон Мэдээллийн хувьсгалын зарчмын хүрээнд боловсруулагджээ. Тиймээс тогтвортой хөгжлийн зорилгуудын үзүүлэлт, зорилт, суурь мэдээллийг боловсруулах, ашиглахад илүү дэмжлэг хэрэгтэй байна.

Одоогоор үнэлгээний долоон ТХЗ-той холбоотой салбарын, үндэсний дунд болон урт хугацааны 40 орчим бодлого, төлөвлөгөө, стратеги бодлогууд байгаа боловч дунд хугацааны олон стратеги бодлогуудын хугацаа дуусах дөхөж байгааг анхаарах хэрэгтэй.

ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ТҮНШЛЭЛ БА ОРОЛЦОО

Монголын бодлогын судалгааны хүрээлэнгүүд болон иргэний нийгмийн байгууллагуудын дунд хийсэн одоогийн чадавхийн үнэлгээ болон дүр зураг гаргах судалгаанаас харахад ТХЗ-уудыг уялдуулах, тусгах, хурдасгах, дэмжихэд чамгүй их орон зай байна. Гэвч эдгээр оролцогчдыг мэдээлэл цуглуулалт, мэдээллийн удирдлага болон ТХЗ-уудад тайлагнах тал дээр үр дүнтэй оролцуулахад хэд хэдэн саад бэрхшээл учирч байсан юм. Тухайлбал улс төрийн нөлөөтэй төрийн бүтэц, боловсон хүчний тогтворгүй байдал, өөрийн үйл ажиллагаанаас орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгож чадахгүй байх зэргийг дурьдаж болно.

ЧАДАВХИЙН ХЭРЭГЦЭЭ

Оролцогчидтой хийсэн ярилцлагаас харахад ТХЗ, тэдгээрийн зорилт, үзүүлэлт, суурь мэдээлэл, жендэрийн мэдрэмжтэй байдал, хүйсээр задалсан мэдээлэл зэрэг чухал асуудлын талаарх мэдлэг, ойлголт, хүлээлт нь өөр өөр байна. Чадавхийн хоёр хэрэгцээг тодорхойлсноос эхний хэрэгцээг нэн даруй буюу 2016 онд багтааж, удаахийг нь дунд хугацаанд хангах ёстой.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ


Судалгааны үр дүнд тулгуурлан Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын суурь мэдээллүүдтэй холбоотой тодорхой санал, зөвлөмжийг боловсруулсан.

ХАНДЛАГА	ТОДОРХОЙЛОЛТ	САНАЛ ЗӨВЛӨМЖ
Зонхилох чиг хандлага болгох	Үндэсний болон бүс нутгийн түвшинд үндэсний, бүс нутгийн, орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөнд Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын санааг тусгах, түүнчлэн уг бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай төсвийг хуваарилах	- Боловсон хүчнийг сайжруулах. - Үндэсний мэдээлэл цуглуулалт болон менежментийг сайжруулахад олон талт оролцогч талуудын хандлагыг тусгах
Хурдасгах	Тодорхойлогдсон зонхилох чиг хандлага болгох үйл явц, саад тогторууд, санхүүжилт болон хамтын ажиллагаа болон хэмжигдэхүүн рүү үндэсний болон НҮБ-н нөөцийг чиглүүлэх	Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын тайлагналтыг үндэсний, бүсийн болон орон нутгийн онцлогт тохируулах
Бодлогын дэмжлэг	НҮБ-н Хөгжлийн Системийн ур чадвар, мэдлэгийг цаг тухайд нь хамгийн бага өртгөөр нэвтрүүлэх	Төсөв болон нөөцийн хуваарилалт хийх

Цаашилбал, НҮБ-с гаргасан MAPS хандлагыг ашиглан Монголд Тогтвортой Хөгжлийн Зорилгуудтай холбогдох мэдээлэл цуглуулалт,

менежмент болон хяналт, хариуцлагын тогтолцоог сайжруулах талаар зөвлөмж боловсруулсан.

МОНГОЛ УЛСАД НИЙГМИЙН ЭГЭХ ХАРИУЦЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙН СУУРЬ СУДАЛГАА



Swiss Agency for Development
and Cooperation SDC



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Дэлхийн Банк (ДБ) болон Швейцарийн Хөгжлийн Агентлаг (ШХА)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Суурь судалгааны үндсэн зорилт нь Монгол Улсад Нийгмийн Эгэх Хариуцлагыг Бэхжүүлэх(МУНЭХБ) хөтөлбөрийн хөтөлбөрийн логик хүрээнд тодорхойлогдсон индикаторын цаашдын үнэлгээг дэмжих суурь өгөгдлийг цуглуулах юм. Хоёрдахь зорилт нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг болж, тавьсан зорилгодоо хүрэх боломжийг нэмэгдүүлэхүйц өгөгдөл, мэдээллийг бүрдүүлэх юм.



2016


1-р сар

2016

11-р сар



ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Талбарын судалгааг Улаанбаатар хот, Увс, Ховд, Говь-Алтай, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл, Хэнтий, Говьсүмбэр, Дорнод болон Сүхбаатар аймгуудад гүйцэтгэсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

МУНЭХБ хөтөлбөрийг ШХА, ДБ-аас хамтран санхүүжүүлж байна. Энэ хөтөлбөр нь 2015-2019 оны хооронд хэрэгжих бөгөөд 10 аймаг, Улаанбаатар хотын зарим дүүргүүдийг хамарна. Хөтөлбөрийн хүрээнд улсын нөөцийн менежментийн үр нөлөөтэй, ил тод байдлыг дээшлүүлэх болон хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нийгмийн эгэх хариуцлагыг бэхжүүлэхээр зорьсон. Хөтөлбөрийн хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

- Засгийн газарт хариуцлага тооцох Иргэний Нийгмийн Байгууллага (ИНБ)-уудын чадавхийг сайжруулах
- ИНБ-ын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, хууль ёсны шинжтэй болгох, ил тод, оролцооны механизмын тогтвортой байдлыг сайжруулах замаар нийгмийн эгэх хариуцлагын институцыг бэхжүүлэх.

Хөтөлбөр хэрэгжсэнээр нийгмийн эгэх хариуцлагын туршлагаар дамжуулан, ядуурал ихтэй орон нутгийн иргэдэд хүргэж буй төрийн шийдвэр гаргах үйл ажиллагааны хүртээмж, үйлчилгээний чанар илүү сайжирна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Суурь судалгааны мэдээллийг дараах хэд хэдэн судалгааны аргуудыг ашиглан цуглуулсан. Үүнд:

- Асуумж - Жендерийн мэдрэмжтэй өрхийн асуумж, ТББ-уудын асуумж болон ганцаарчилсан ярилцлаганд оролцсон төрийн байгууллагын ажилтнуудаас авсан хураангуй асуумж
- Ярилцлага- ТББ, бодлогын хүрээлэн, төрийн байгууллагын ажилтнууд болон хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хийсэн ганцаарчилсан ярилцлагууд (Бүлгийн ярилцлага - Холбогдох бүлгүүд, хувь хүмүүс, оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт (фокус бүлгийн уулзалтууд)

- Баримт бичгийн судалгаа - Холбогдох ном, судалгааны баримт бичгийн судалгаа.

ҮР ДҮН

Суурь судалгааны логик хүрээ нь гурван шаталсан индикатораас бүрдэж байна. Үүнд:

Логик хүрээний дагуу МУНЭХБ хөтөлбөрийн ерөнхий зорилго нь “төрийн шийдвэр гаргах үйл явц болон чанартай үйлчилгээнд НЭХ-аар дамжуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх” юм.

1. Иргэдийн төрийн үйлчилгээг авах хүртээмж

Нийт суурь тоог гаргахдаа эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээний хүртээмж, чанарыг, хувиар гаргаж, улмаар эдгээр үзүүлэлтийн дундажийг гаргасан ба нийт хувийг тооцохдоо, дэд үзүүлэлт бүрээр судалгаанд оролцогчдын тоог харгалзан гаргасан (эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар). Судалгааны үр дүнд суурь түвшин нь 32 хувь байна.

2. ИНБ-ын хөрөнгө босгох чадвар

Энэ индикатор нь МУНЭХБ хөтөлбөрийн хүрээнд ИНБ-уудын хөрөнгө босгох чадвар хэрхэн нэмэгдсэнийг хэмжих зорилготой. Индикаторын үзүүлэлт нь МУНЭХБ хөтөлбөрийн явцад орсон сургалтын үр дүнг хэмжих зорилготой тул суурь тоо “0” байна. Ганцаарчилсан ярилцлага болон оролцооны зөвлөлдөх уулзалтын үр дүнгээс үзвэл ТББ-ууд өөрсдийн санхүүгийн тогтвортой байдал нь үйл ажиллагаанд хамгийн чухал гэж үзсэн байна. ТББ-ууд санхүүгийн тогтвортой байдлын ач холбогдлыг ойлгож байгаа ч, 2015 онд зөвхөн 18 хувь нь л тогтмол үйл ажиллагаанд зориулж хөрөнгө босгосон байна. Мөн 48 хувь нь тодорхой зориулалтаар хөрөнгө босгосон бол 33 хувь нь огт хөрөнгө босгож чадаагүй байна. Судалгаанд хамрагдсан ТББ-уудаас хэрэгцээтэй сургалтын төрлүүдийг тодорхойлох үед 225 хариултаас зөвхөн 8 нь л “хөрөнгө босгох” байв. Үүнээс харахад, ТББ-ууд нэг бол өөрсдийн хөрөнгө босгох мэдлэг дутуу байгааг мэдэхгүй эсвэл хөрөнгө хэрхэн босгохыг мэддэг боловч санхүүжилтээ удирдах боломжгүй байгааг харуулж байна.

3. Нийгмийн эгэх хариуцлагын талаар олон нийтийн мэдлэг ба сургалтад хамрагдсан байдал

Энэ үзүүлэлт нь МУНЭХБ хөтөлбөрийн хүрээнд сургалтанд хамрагдсан бэлтгэгдсэн ИНБ-уудын тоогоор илэрхийлэгдэх тул суурь тоо нь “0” байна.

ТББ-уудын төлөөллүүдтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаар чадавхийг бэхжүүлэх сургалтын өнөөгийн боломжит хүрээг тодорхойлсон юм. Энэ сургалтуудыг үндэсний болон олон улсын байгууллагууд, тухайлбал Дэлхийн Банк, Мерси Корп Монгол, Азийн Сан, Нээлттэй Нийгэм Хүрээлэн зэрэг байгууллагууд хийдэг байна. Эдгээр сургалтуудын ихэнхи нь танхимын сургалтаар явагддаг бол, ТББ-ууд нь “ажиллангаа суралцах” буюу ажлын байран дахь сургалтыг илүүд үзэж байна. Харин өрхийн судалгаанд оролцогчдын дөнгөж 6 хувь нь л 2015 онд НЭХ-ын чиглэлээр албан бус сургалтанд хамрагдсан байна.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

1. Хөрөнгө босгох болон санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд ИНБ-уудад туслалцаа үзүүлэх

МУНЭХБ хөтөлбөрт ИНБ-уудын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад туслэх хоёр гол арга зам байна. Үүнд:

Сургалтаар хангах болон хөрөнгө босгоход нь туслалцаа үзүүлэх

ИНБ-ын тогтвортой үйл ажиллагааны гол эрсдэл нь санхүүжилт олох, хөрөнгө босгох болж байгаа бол орлогын эх үүсвэрийг олох боломжийг хангахад нь дэмжих, орлогын олон урсгалыг тодорхойлох ажил хийх.

ИНБ-ын хүрэхийг зорьж буй санхүүгийн хараат бус байдалд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь гадаад хүчин зүйлс буюу Монголын эдийн засгийн хямрал байна. Эдийн засгийн хямрал нь ИНБ-д ихээр нөлөөлж байгаа ба цаашид үйл ажиллагаагаа тогтвортой үргэлжлүүлэн явуулахын төлөө өөрсдийн чадавхийг дайчлах, санхүүжилтийг шинэ эх үүсвэрийг олох зэрэг ИНБ-ууд нь хувьд бүр ч сорилт болж байна.

2. Сургалтын хэрэгцээ

МУНЭХБ хөтөлбөрийн зорилтот стратегиудын нэг нь оролцогч талуудад сургалт хийх, мэдлэг олгох үйл ажиллагаа юм. Энэ суурь судалгааны мэдээлэл нь стратегийн энэ зорилтын хувьд ихээхэн үнэ цэнэтэй мэдээлэл юм. Иргэдийн НЭХ-

ын талаарх ойлголтыг сайжруулах шаардлагатай хэмээн судалгаанд оролцогч бүх талууд, үүний дотор төрийн байгууллагууд, ИНБ-ууд хүлээн зөвшөөрч байна. Судалгааны дүнгээс үзвэл ИНБ-д хамгийн их хэрэгцээтэй, үр ашигтай сургалтуудын чиглэлд “гадаад хамтын ажиллагаа, түншлэлийг бий болгох”, “байгууллагын удирдлага”, “орон нутгийн иргэдтэй харилцаа тогтоох, тэднийг идэвхижүүлэх” сэдвүүд багтаж байна.

Төрийн байгууллагуудын хувьд, анхаарах гол асуудлуудын нэг нь ИНБ-ууд болон иргэдийн гомдол болон санал хүсэлтэнд цаг хугацаанд нь хариу өгөн ажиллах юм. Энэ байдалд сүүлийн жилүүдэд ахиц дэвшил гарч байгаа ч иргэд ихээхэн сэтгэл хангалуун бус байгаа тул дахин сайжруулах шаардлагатай байна. Тийм учраас энэ чиглэлээр зохион байгуулах ямар ч сургалт үнэ цэнэтэй байх болно.

3. Зорилтот бүлгийг онцлох нь

Судалгааны тоон мэдээллээс харахад, залуучууд ажилгүйдэлд өртөх нь түгээмэл байгаа ба иргэний оролцоотой уулзалтуудад хамрагдсан байдал ч бага байна. Залуус ахмад настнуудтай харьцуулахад шинэлэг зүйлс, үзэл санаанд нээлттэй хандах, олж авсан мэдлэгээ бусадтай хуваалцах чадвар ахмадуудаас илүү гэж үзвэл залуусыг гол зорилтот бүлгээ болгох нь үр дүнтэй юм.

Судалгааны дүнгээс харахад сарын 500000 төгрөгөөс доогуур орлоготой өрхүүд илүү орлоготой өрхүүдээс НЭХ-ын чиглэлээрх сургалтанд хамрагдсан байх магадлал нь 50 хувиар бага байгаа юм. Нийт өрхийн 16 хувийг өрх толгойлсон гэр бүл нь эзэлж байгаа ба үүний ихэнхи (84 хувь) нь өрх толгойлсон эмэгтэйчүүд байна. Өрхийн сарын орлого болон өрхийн хэлбэрийн хоорондох хамаарлыг авч үзвэл өрх толгойлсон эмэгтэйчүүдийн өрхийн орлого бага байна. Тиймээс ийм өрхүүдийг зорилтот бүлэгт зайлшгүй оруулах шаардлагатай байна.

Судалгаанд оролцсон нийт ТББ-уудын 56 хувь нь өмнө нь НЭХ-ын хөтөлбөрт оролцож байгаагүй байна. МУНЭХБ хөтөлбөрийн тогтсон зорилго нь НЭХ-ыг олон нийтийн хандлага болгоход чиглэж байгаа н тул эхний ээлжинд өмнө нь энэ талбарт огт оролцож байгаагүй эдгээр ИНБ-уудыг сонгосон нь үр дүнтэй арга юм. ИНБ-ын сүлжээ нь ТББ-уудыг сайн хамруулж байгаа ба судалгаанд оролцогчдын 75 хувь нь ИНБ-ын сүлжээ, эвсэлд хамрагддаг гэж мэдэгдсэн байна. Иймд ИНБ-ын сүлжээг хөтөлбөрийн зорилтот бүлэг болгон сонгох нь зүйтэй байна.

“БҮС НУТГИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ИНТЕГРАЦИЧЛАЛ: МОНГОЛ УЛСЫН БОЛОМЖ БА ЭРСДЭЛ”

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Гадаад Хэргийн Яам (ГХЯ),

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь Монгол Улсын бүс нутгийн интеграцид нэгдэх боломж, түүний Монголын эдийн засг дахь үр өгөөж, улс төр, эдийн засаг, аюулгүй байдалд тулгарах эрсдэл, сөрөг нөлөөг судлан судалгааны үр дүнд түшиглэн зөвлөмж боловсруулахад оршино.



2016

3-р сар

2016

9-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Уг төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн.



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс (МУ) нь Дэлхийн Худалдааны Байгууллага (ДХБ)-ын гишүүн 162 орноос бүс нутгийн интеграцид дөнгөж хамрагдаж эхэлж байгаа орон бөгөөд хөнгөлөлтгүй нөхцөлөөр худалдаа хийж, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Нөгөө талаас Монгол Улсын олон улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд нэг орон хэт давамгайлж, үндэсний болон эдийн засгийн аюулгүй байдал эрсдэлд орж болзошгүй орнуудын нэгд тооцогдож байна. ДХБ-ийн судалгаагаар дэлхийн хамгийн эмзэг эдийн засагтай 20 орны тоонд манай улсыг оруулжээ. Энэ байдлыг Олон Улсын Байгууллага (ОУБ), гадаад, дотоодын судлаачдын зүгээс анхааруулсаар байгаа юм. Тухайлбал, 2014 онд МУ-ын худалдааны илтгэлийг ДХБ-ын Худалдааны Бодлогыг Хянах Хорооны хуралдаанаар хэлэлцэхэд хорооны хуралдааныг даргалагчаас “МУ- эдийн засаг суурь муутай байгаа, дээр нь цөөн хэдэн бүтээгдэхүүнээс хамааралтай байгаа нь эрсдэлийг нэмэгдүүлж байна гэж үзэх үндэстэй байна. Энэ байдлыг засах нь амаргүй учраас сайн бодлого хэрэгтэй. Монгол Улс чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) байгуулаагүй (Япон улстай байгуулсан эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЭЗТХ) нь 2016 оноос хэрэгжиж эхэлсэн), бүс нутгийн интеграцчилалд оролцоогүй байгаа нь байдлыг улам хүнд болгож байна” гэж хэлсэн байдаг бол, уг хуралдаанд оролцогч олон төлөөлөгчөөс, Монгол нь бүс нутгийн дэд бүтцийн сүлжээнд холбогдоогүй байгаа нь байдлыг амаргүй болгож байна. Гэвч Засгийн газраас гаргаж байгаа авто зам, төмөр замын талаар гаргасан томоохон төлөвлөгөө хэрэгжих байх гэж найдаж байна” гэж дүгнэж хэлжээ.

МУ-ын Үндэсний Аюулгүй Байдлын Үзэл Баримтлалын 3.2.2.5-д “...гадаад худалдааны дамжин өнгөрөх тээврийн нөхцөлөөс хэт хараат байдлыг бууруулж, далайд гарцгүй орны хувьд тээврийн салбарт хөрш орнуудтай хоёр болон гурван талын урт хугацааны, харилцан ашигтай хэлэлцээр байгуулна. Экспортын бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах далайн боомтуудтай болох, боомт хүртэл тээвэрлэлтийг оновчтой зохион байгуулах, МУ-ын нутгаар дамжин өнгөрөх тээврийн эргэлтийг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ” гэсэн бол, МУ-

ын гадаад бодлогын үзэл баримтлалын 21.4-д “олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэж заасан нь манайхаас бүс нутгийн интеграцид нэгдэх зорилтыг тодорхойлж, эрх зүйн орчныг бүрдүүлжээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааг хийхдээ олон улсын харилцааны реалист онолд тулгуурлан тоо баримт, мэдээллийг үндсэн эх үүсвэрээс нь авч статистикийн болон үр дүнд суурилсан үнэлгээний аргаар боловсруулалт хийлээ. Евразийн эдийн засгийн холбооны хэсэгт ЧХХ-т нэгдэхэд үүсэх боломж, эрсдэлийн тооцоог GTAP шинжилгээний аргыг, Ази-Номхон Далайн Эдийн засгийн хамтын ажиллагаа(АПЕК), Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага (ШХАБ), Евразийн Эдийн Засгийн Холбоо (ЭЗХ), гурван талт хамтын ажиллагааны хэсэгт свот шинжилгээний аргыг хэрэглэсэн.

Гадаад худалдааны татварын хөнгөлөлт эдэлснээр эдийн засагт бий болох үр ашгийг тооцохдоо макро үзүүлэлтүүд буюу дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ), цэвэр экспорт, гадаад худалдааны тэнцэл, өрхийн орлого зэрэг үзүүлэлтийг ашигласан.Дээрх үзүүлэлтүүдийн тусламжтайгаар эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох бөгөөд үзүүлэлт бүрт гарах өөрчлөлтийг дэлгэрэнгүй танилцуулсан. Мөн ганцаарчилсан ярилцлагын аргыг ашиглан тухайн салбарын экспертүүдтэй ярилцлага хийж Монголын гадаад худалдааны бодлогынболомж ба эрсдлийг тодорхойлсон. Ганцаарчилсан ярилцлагын үеэр CBOT шинжилгээний аргыг ашиглан илүү системчлэгдсэн мэдээллийг бүрдүүлсэн.

Хамрах хүрээний хувьд АПЕК, Евразийн эдийн засгийн холбоо(EAEU), Бүс нутгийн иж бүрэн эдийн засгийн түншлэл (RCEP), Номхон далай дамнасан түншлэл(TPP), Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг (EEC), Европын чөлөөт худалдааны нийгэмлэг (EFTA), АСЕАН, АСЕАН+3, АСЕАН+6 зэрэг интеграрциудаас гадна төслийн баг судалгааны хүрээг тэлж Шанхайн хамтын ажиллагааны байгууллага, Орос-Монгол-Хятадын гурван тал тэдийн засгийн коридорыг нэмж судалсан.

АВЛИГЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙГДСЭН СУДАЛГААНЫ МАТЕРИАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ



The Asia Foundation



Australian Government



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан

Австралийн Засгийн Газар

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны ажлын зорилго нь 2006 оноос хойш хийгдсэн авлигын судалгааны арга зүй, хамрах хүрээ, зорилгод дүн шинжилгээ хийх юм. Энэ ажлын хүрээнд МУ-ын “Авлигын эсрэг хууль”-ийн шинэчлэлээс хойш хэрэгжсэн авлигатай холбоотой судалгааны жагсаалтыг бүрдүүлэн, судалгааны арга зүй, аргачлал, давуу сул талуудад шинжилгээ хийн харьцуулалт хийнэ. Судалгааны үр дүнд үндэслэн санал зөвлөмж, дүгнэлт гаргахгүй бөгөөд харин энэ чиглэлээр судалгааны ажил гүйцэтгэдэг олон тал оролцогчид талуудад үр дүнг танилцуулж, авлигын чиглэлийн судалгааг цаашид хэрхэн сайжруулах талаар зөвлөлдөх уулзалт хийсэн.



2016

5-р сар

2016

6-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатарт хэрэгжсэн



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2006 онд “Авлигын эсрэг хууль” батлагдаж, 2007 онд Авлигатай Тэмцэх Газар байгуулагдсан. Энэ хугацаанд авлигын чиглэлээр олон төрлийн судалгааны ажлууд хийгдсэн байна. Авлигын ихэнх судалгааг төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд нэг удаа болон тогтмол давтамжтайгаар гүйцэтгэсээр байна. Эдгээр судалгаануудыг сэдэв, хамрах хүрээ, чиглэл, үр нөлөө зэргийг нь бүхэлд нь тоймлон судалсан мэдээлэл хараахан байхгүй байна. Тиймээс энэ төсөл нь авлигын чиглэлээр өмнө нь хийгдсэн судалгаануудад дүн шинжилгээ хийж, цаашдын судалгааны чиглэл, удирдамжинд дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгаа нь баримт бичгийн судалгааны аргыг ашиглан авлигын чиглэлээр хийгдсэн судалгаануудын ерөнхий мэдээлэлд шинжилгээ хийсэн. Авлигын чиглэлээр хийгдсэн судалгааны мэдээллийг цуглуулахдаа интернэт, байгууллагын


архив зэрэг хэд хэдэн эх үүсвэрээс цуглуулсан бөгөөд ном зүйн хэсгийг ашиглан нэг судалгаагаар дамжуулан ижил төстэй өөр судалгааг олж байв.

Мэдээлэл цуглуулалтын хүрээнд нийт 45 судалгаа, шинжилгээний бүртгэл цугларсанаар олон улсын түвшний авлигын индекс, авлигатай шууд хамааралтай бус, арга зүйтэй холбоотой шаардлагатай мэдээлэл хязгаарлагдмал, судалгааны тайлан олдоогүй зэрэг нөхцлүүдийг харгалзан 35 судалгааны мэдээлэлд шинжилгээ хийсэн.

ҮР ДҮН

Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтээс хойш энэ чиглэлийн судалгааны ажлууд нилээд эрчимжсэнтэй холбоотой олон төрлийн авлигын чиглэлийн судалгаа хийгджээ. Энэ судалгаанд 2002-2006 оны хооронд хэрэгжсэн 8 төрлийн судалгаа, 2006 оноос хойш хэрэгжсэн 27 судалгааг хамруулсан.

Дүрс. 1 Авлигын чиглэлээр хийгдсэн судалгааны он (тоогоор)



2013 оноос хойш Авлигын чиглэлээр хийгдэж буй судалгааны тоо өсчээ. Үүнээс харахад Монгол улсад авлигын асуудал жил ирэх тусам хурцдаж, олны анхаарлыг татсан асуудал болж байгааг илтгэж байгаа ч, нөгөө талаар авлигын асуудлыг чухалчлан авч үзэх, авлигын асуудлаар үйл ажиллагаа явуулах, авлигыг бууруулах чиглэлд олон талууд оролцох болсон байна.

Авлигатай холбоотой судалгааг Монгол улсад хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгч гэсэн 3 түвшинд авч

үзсэн. Судалгааны үр дүнгээс харахад авлигын судалгааны 94 хувийг олон улсын болон төрийн байгууллагууд захиалан, сонгон шалгаруулалтын аргаар ихэвчлэн хараат бус хувийн хэвшлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж байна. Дараах хүснэгтээс олон улсын байгууллага, төрийн байгууллага, хувийн хэвшлийн авлигын судалгааны чиглэлээр гүйцэтгэж байгаа үүргүүдийг харж болно.

Дүрс.2 Байгууллагын төрөл болон үндсэн үүрэг (тоогоор)




Судалгааны үр дүнд мэдээлэл боловсруулсан нийт 35 судалгаанаас судалгаа 27, үнэлгээ 8 байсан. Үүнийг төрлөөр нь ангилвал бодлогын судалгаа, индекс, харьцуулсан судалгаа гэх мэт олон төрөл байгаа бөгөөд хамгийн олон нь олон нийтийн санал бодолд суурилсан судалгаа 8 хийгдсэн байна. Мөн нийт 8 төрлийн үнэлгээний ажил хийгдсэн байгаагаас 4 нь мониторинг буюу хяналт шинжилгээ хийх чиглэлээр, бусад 4 үнэлгээ нь байгууллага, албан тушаалтнуудыг үнэлсэн байна.


Дээрх судалгаа, үнэлгээний ажлыг хамарсан салбар, чиглэлээр нь авч үзвэл дийлэнх буюу 13 нь төрийн захиргааны байгууллагын үйлчилгээ, албан хаагчид зэрэг төрийн байгууллагуудыг хамарсан судалгаанууд байна. Тухайлбал: Төрийн эрх мэдлийг урвуулан ашиглахын эсрэг авах арга

хэмжээ, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжийн авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээ, төрийн байгууллагын нээлттэй ил тод байдал, төрийн байгууллагын шударга байдлын түвшинг үнэлсэн байна.

Дүрс.3 Судалгааны төрөл (тоо/хувиар)



Дүрс.4 Авлигын судалгааны салбар (тоо/хувиар)



Мөн 2 болон түүнээс дээш салбарыг хамарсан тохиолдолд салбар дундын гэж тооцсон болно.

Энэ чиглэлээрх судалгааг дурдвал Авлигын хандлагын судалгаа, Авлигын талаарх олон нийтийн санаа бодлын судалгаа, Авлига үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь, Авлигын индекс, Авлигын ерөнхий төлөв байдлын судалгаа. Гааль, боловсрол, газар, уул уурхайн салбартай холбоотой авлигын судалгаанууд тогтмол хийгдсээр иржээ.


ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Дээрх төслийн үр дүнд авлигатай холбоотой судалгааны материалуудыг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн. Энэ мэдээллийг цаашид авлигын чиглэлийн судалгааны суурь мэдээлэл болгон ашиглах боломжтой. Мөн авлигын чиглэлээр хийгдэж буй төсөл, судалгааны ажлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх юм.

“БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХАД ТАЛУУДЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ II” (БОХТОН II) ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН СУДАЛГАА



The Asia Foundation



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Байгаль Орчныг Хамгаалахад Талуудын Оролцоог Нэмэгдүүлэх нь II” (БОХТОН II) үр дүнгийн судалгаа нь 2014 онд хэрэгжсэн суурь судалгааны үргэлжлэл юм. 2016 оны хийгдэж буй төгсгөлийн үр дүнгийн судалгааны ерөнхий зорилт нь хувиараа ашигт малтмал олборлогчдын талаарх оролцогч талуудын үзэл бодолд гарсан гол өөрчлөлтийг тодорхойлж, 2014 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулан дүгнэлт гаргах юм. Энэ судалгаа нь дараахи өөрчлөлт, үзүүлэлтүүдийг тодруулахад чиглэгдсэн. Үүнд:

- Бичил уурхай нь орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулна хэмээн итгэж буйгаа илэрхийлсэн оролцогч талуудын хувь хэмжээнд гарсан өөрчлөлт
- Төслийн нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд бичил уурхайн талаарх иргэд, нутгийн захиргаа болон томоохон уул уурхайн компаниудын төлөөлүүдийн үзэл бодолд гарсан өөрчлөлт зэрэг багтна.




2016

6-р сар

2016

8-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Баянхонгор аймаг (Баян-Овоо сум, Бөмбөгөр сум, Галуут сум), Дорноговь аймаг (Айраг сум), Дундговь аймаг (Өлзийт сум), Сэлэнгэ аймаг (Мандал сум), Төв аймаг (Заамар сум), Өмнөговь аймаг (Цогт-Овоо сум), Увс аймаг (Өмнөговь сум) болон Улаанбаатар

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

БОХТОН II төсөл нь эрх эдлэгч болон үүрэг хүлээгч хоорондын оролцооны тухай төсөл юм. БОХТОН II төслийн хүрээнд Уул уурхайн яам (УУЯ), Ашигт Малтмалын Газар (АМГ), Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (МХЕГ) болон Байгаль Орчин Ногоон Хөгжлийн Яам (БОНХЯ), аймаг, сумдын засаг захиргаа нь үүрэг хүлээгч талууд болж байсан. Бичил уурхайн нөхөрлөлийн гишүүд мөн үүрэг хүлээгч тал бөгөөд байгаль орчинд ээлтэй тогтвортой үйл ажиллагаа явуулах үүргийг хүлээж буй юм. БОХТОН II төсөл нь үүрэг хүлээгчийн чадавхийг нэмэгдүүлж, хүлээсэн үүргээ биелүүлэх, чадавхийг сайжруулахад анхаарч ажилласан. Бичил уурхайчид бол хөдөлмөр эрхлэх, ажлаа чөлөөтэй сонгох, шударга таатай ажлын байрны нөхцөлөөр хангагдах, ажилгүйдлээс хамгаалагдах буюу зохистой ажлын байраар хангагдах зэрэг эрх эдлэгчид юм. Орон нутгийн иргэд ч мөн байгаль орчны доройтлын улмаас эрх нь зөрчигдөөд буй эрх эдлэгчид юм. БОХТОН II төсөл бичил уурхайчдын эрхийг дээшлүүлэх болон бичил

уурхайн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж буй орон нутгийн ард иргэдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэн ажилласан

БОХТОН II төсөл нь (2014-2017 он) 3,5 жилийн хугацаатай үргэлжилж буй бөгөөд Швейцарийн Хөгжлийн Агентлаг (ШХА)-аас хэрэгжүүлж буй Тогтвортой Бичил Уурхай (ТБУ) төслийн (2011-2014 он, III шат) нэг хэсэг бөгөөд 2010-2013 онд хэрэгжсэн БОХТОН I төслийн үргэлжлэл юм. 2016 онд тус төсөл нь ШХА-ын ТБУ төсөлтэй зэрэг хэрэгжсэн (2015-2018) юм.

БОХТОН II төсөл нь Монголын бичил уурхай эрхлэгчдийн зүгээс орон нутгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх, эрүүл орчинд ажиллаж амьдрах, зохистой ажлын байраар хангагдах эрхийг нь хэрэгжүүлэхэд чиглэн ажилласан. Энэ төсөл нь БОХТОН I төслийн үр дүн, амжилтад тулгуурласан бөгөөд эхний шатны хэрэгжүүлэгч түншүүд болох үндэсний хэмжээний 8 төрийн бус байгууллага (ТББ), орон нутгийн 10 ТББ, байгаль орчны 3 мэргэжлийн

байгууллагатай хамтран ажилласан. Эдгээр ТББ-аар дамжуулан өртөг зардал багатай нөхөн сэргээлтийн аргачлалыг нэвтрүүлэх боломж бололцоог хэлэлцэж, бичил уурхай эрхлэгчдийн ТББ-ыг чадавхижуулан орон нутгийн олон талт зөвлөлүүдээр дамжуулан зөрчлийг бууруулахад анхаарч ажилласан.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны ерөнхий загвар нь (2014 оны суурь судалгааны хүрээнд боловсруулсан) давтагдах хөндлөн огтлолын (repeated cross section) загвар бөгөөд үүнийг доорх график дээр харууллаа.

Дүрс 1: Төслийн дизайн

	2014 БОХТОН II Суурь судалгаа	2016 БОХТОН II Төгсгөл судалгаа	Өөрчлөлт
Оролцогчид (Респондентууд)	A_1	A_2	$A_2 - A_1 = X_1$

A_1 - БОХТОН I суурь судалгаа, A_2 - БОХТОН II төгсгөл судалгаа, X_1 - Өөрчлөлтүүд

ҮР ДҮН

2014 оны суурь судалгаатай харьцуулахад дараахи үндсэн өөрчлөлтүүд гарсан байна.

- Төслийн зорилгын түвшиний шалгуур үзүүлэлтийн хувьд,** орон нутгийн иргэдийн дунд бичил уурхайн зүгээс орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн талаарх үзэл бодолд эерэг өөрчлөлт (54.4%-62%) гарсан байна. Ихэнх оролцогчид эерэг хариулт өгсөн ба итгэлтэй байна/маш их итгэлтэй байна гэсэн хариулт нийт асуумжийн 60.9% -д, хагас бүтэцлэгдсэн ярилцлагын 59.1% -тай тэнцэж байна.

Орон нутгийн оролцогч талуудын хувьд үзэл бодол их хэмжээгээр өөрчлөгдөөгүй ч бусад судалгааны үр дүн бичил уурхайн зүгээс орон нутгийн хөгжилд үзүүлэх шууд болон шууд бус хувь нэмэр нь маш өндөр хэмжээнд байж болохыг харуулж байна (ХБСХ, 2015).

Харин сумын түвшин дэх оролцогч талууд зөвхөн бичил уурхайгаас шууд хүртэж буй эдийн засгийн хувь нэмрийг (орон нутгийн татвар, төлбөр гэх мэт) л чухалчлан үзэх хандлагатай байгаа ба бичил уурхайн зүгээс үзүүлж буй шууд ба шууд бус нөлөөллийг үнэлж чадахгүй байгаа тул эдийн засаг, байгаль орчин, нийгэмд оруулж буй хувь нэмрийг сурталчлах, нөлөөллийн үйл ажиллагааг явуулах шаардлагатай байна.
- Үр дүн 1:** Өртөг багатай нөхөн сэргээлт явуулах байгаль орчны шаардлагуудын талаар мэдлэг бүхий бичил уурхайчдын

хувь хэмжээнд мэдэгдэхүйц томоохон өөрчлөлт гараагүй байна. Хагас бүтэцлэгдсэн ярилцлагын үр дүнгээс харахад нөхөн сэргээлтийн тухай мэдлэгийн түвшинг ихэнх нь сайн (34.1%) гэж үзсэн бөгөөд нийт 81.8% нь дунд зэрэг, сайн болон маш сайн гэсэн хариултыг сонгожээ. Гэсэн хэдий ч энэ нь 2014 оны суурь судалгааны үзүүлэлттэй харьцуулбал ихээхэн сайжирсан хэрэг бөгөөд 2014 онд ихэнх нь (47.7%) өөрсдийн мэдлэгийн түвшинг зөвхөндүнд зэрэг хэмээн үзэж байсан юм.

Түүнчлэн байгаль орчныг нөхөн сэргээх шаардлагыг биелүүлнэ хэмээн үзсэн бичил уурхайчдын тоо нэмэгдсэн нь мэдэгдэхүйц эерэг өөрчлөлт гарсаныг харуулж байна (Бараг эсвэл бүрэн хэмжээнд хэрэгжих боломжтой хэмээн үзсэн хүмүүсийн хувь хэмжээ 11.4%-иар нэмэгдсэн). Ийнхүү нэмэгдсэн үндсэн хүчин зүйл нь тулгарсан хүндрэл болох санхүүжилт (13.8%), зөвлөгөө, мэдээлэл (8.3%) гэсэн хүндрэлүүд буурсанаас үүдсэн байж болно.

Туршилтаар хэрэгжүүлсэн нөхөн сэргээлтийн зардал багатай ногоон аргачлалын тухай мэдлэг бүхий уурхайчдын хувь хэмжээ нь ихээхэн нэмэгдсэн (2014 онд 35.4% байсан бол энэ хувь 65.9% болж нэмэгдсэн) ба орон нутгийн иргэдийн дундах энэ төрлийн мэдлэгийн түвшин сайжирсан нь байна. (2014 онд 32.2% байсан бол 2016 онд 38.0% болсон). Мөн туршилтаар

хийгдсэн нөхөн сэргээлтийн ногоон аргачлалыг хүлээн зөвшөөрөх байдал болон энэ талаар мэдэж буй хүмүүсийн хувь хэмжээ өссөн байна. (2014 онд 33.8% байсан бол 2016 онд 96.6% болж нэмэгдсэн). Ийнхүү оролцогч талуудын мэдлэгийн түвшин нэмэгдсэн нь тэдгээр талууд төслийн үйл ажиллагаанд шууд оролцох болсонтой холбоотой гэж үзэж байна.

- **Үр дүн 2:** Бичил уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг харилцан зөвшилцөж, баталгаажуулсан сумдын хувь хэмжээ нь 2014 онд 52.3% байсан бол 2016 онд 54.5% болж нэмэгдсэн байна. Түүнчлэн бичил уурхайн байгаль орчны төлөвлөгөөний хэрэгжилтэд зориулан хуваарилсан санхүүжилтын хэмжээ нь суурь судалгаагаар 11 сая төгрөг байсан бол 2016 оны судалгаагаар 34 сая төгрөг болжээ. Сонирхолтой нь төрийн санхүүжилт бүхий төслийн эзлэх хувь хэмжээ 2016 онд нэмэгдсэн байна.
- **Үр дүн 3.4:** Тухайн суманд бичил уурхай нь нэр хүнд муу гэж үзэж буй хүмүүсийн хувь хэмжээ 23.7%-иас 36.7% болж нэмэгдсэн байна. Бичил уурхайгаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн талаарх хүмүүсийнээрэг хандлага нэмэгдэж байгаа ч орон нутгийн зарим иргэд бичил уурхайг хөрсний эвдрэл гэмтэл, байгаль орчны бохирдол зэрэг сөрөг үр дагаваруудыг дагуулдаг хэмээн үзсээр л байна. Бичил уурхайн зүгээс амьжиргаа болон орон нутгийн хөгжилд үзүүлэх хувь нэмрийн талаарх оролцогчдын санал бодол үндсэндээ эерэг хэвээр байна.

Бичил уурхайн талаарх орон нутгийн иргэдийн ерөнхий үзэл бодол, сэтгэгдэл нь өнөөг хүртэл ерөнхийдөө сөрөг талтай хэвээр байна. Гэхдээ зорилтот бүлгийн ярилцлагын дүнгээс харвал орон нутаг дахь байгаль орчны асуудлууд нь ихэнхдээ томоохон хэмжээний уул уурхайн компаниудаас болж үүсч байгаа ч үүнийг нутгийн иргэдийн зүгээс уул уурхай гэ ерөнхийлөн дүгнэсэн байдлаар авч үздэг болох нь ажиглагдаж байна.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

2014 онд хийгдсэн суурь судалгаанаас хойш төслийн ихэнх үзүүлэлт дээр ахиц дэвшил гарч эерэг өөрчлөлтүүд бий болжээ. Бичил уурхайчид болон орон нутгийн захиргааны ажилтнууд зэрэг төсөлд шууд хамааралтай оролцогч талуудад гарсан өөрчлөлтүүдийг авч үзвэл:

1. Бичил уурхайн зүгээс орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн талаарх бүх оролцогч талуудын үзэл бодол, хандлага нэмэгдсэн байна. Энэ нь удаан хугацааны турш үргэлжилж байсан бичил уурхайчдын талаарх сөрөг хандлага буурч, тэдний эерэг нөлөөллийг олж харсанаар, бичил уурхайчды талаарх эерэг сэтгэгдэл шинээр үүсч байгааг харуулж байна.
2. Оролцогч талуудын зүгээс бичил уурхайг харж буй байдал, тэдний үзэл бодол ерөнхийдөө, зохистой байдлаар сайжирсан байна. Тухайлбал бичил уурхайн талаарх сөрөг бодол нь (Бичил уурхайгаас байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл болон орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэртэй хамаатайгаар) бүхий л оролцогч тал дээр буурчээ. 2014 оны суурь судалгааны үр дүнтэй харьцуулбал малчид, сумын иргэд болон бичил уурхайчид зэрэг орон нутгийн оролцогч талуудын бичил уурхайн зүгээс орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмрийн тухай санал бодол нь нэмэгдсэн байна. Энэ нь бичил уурхайчдын талаарх эерэг сэтгэгдэл маш өргөн хүрээнд тархсан бөгөөд ямар нэгэн бүлгээр хязгаарлагдаагүй байгааг харуулж байгаа юм.

БОХТОН II төсөл нь орон нутгийн удирдлага болон бичил уурхайчдад нөхөн сэргээлт болон мөнгөн усны асуудлыг үл хүлээн зөвшөөрөх чиглэлээр илүү гүнзгий мэдлэг олгожээ. 2014 болон 2016 оны мэдээллийг харьцуулахад бичил уурхайн эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн тухай мэдлэг бүхий хүмүүсийн тоо болон тэдний гүнзгийрүүлсэн мэдлэгийн түвшин нэмэгдсэн байна. Энэхүү эерэг өөрчлөлт нь БОХТОН II төслийн үйл ажиллагаанд шууд хамааралтай байсан хүмүүс болох бичил уурхайчид болон орон нутгийн удирдлагын дунд илүү ихээр ажиглагдаж байна.

ХОТЫН ЗАСАГЛАЛ" ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН 5 "ЧАДАВХИ БЭХЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ИНСТИТУЦЛЭХ"-Д ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ



The Asia Foundation



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Азийн Сан

Швейцарийн Хөгжлийн Агентлаг (ШХА)-н санхүүжилтээр хэрэгжүүлсэн.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зөвлөх үйлчилгээний зорилго нь төрийн албан хаагчдад сургалтын үйлчилгээ үзүүлэх боломжтой сургалтын байгууллагуудыг үнэлэх юм. Энэ зорилгын хүрээнд дараах дэд зориултуудыг тавьж байна. Үүнд:

- Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох
- Сургалтыг үнэлэхэд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлж, шинжилгээ хийх
- Төрийн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалтын агуулгыг тодорхойлох

Судалгааны үр дүнд үндэслэн боловсруулсан сургалтын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу орчны шинжилгээ хийн, сургалтын байгууллагуудыг үнэлэх юм.

Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд, төрийн албан хаагчдын дунд сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг зохион байгуулж, сургалтын байгууллагуудын чадавхийг үнэлэх ажлуудыг гүйцэтгэсэн.



2016

7-р сар

2016

12-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Хотын засаглал төсөлд зориулсан зөвлөх үйлчилгээний
төсөл нь Улаанбаатар хотын 9 дүүрэгт хэрэгжсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын Алба нь “Засаглалыг дэмжиж, төвлөрлийг сааруулах хөтөлбөр II”-ийн хүрээнд Швейцарийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр Азийн Сантай хамтран “Хотын Засаглал” төслийг 2015 оны 7-р сараас хойш хэрэгжүүлж байна. Энэ төсөл нь 2018 оны 12-р сар хүртэл хэрэгжих юм. “Хотын Засаглал” төсөл нь иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан үйлчилгээг үзүүлэх төрийн албан хаагчдын чадавхийг сайжруулах зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд ШХА-н захиалгаар IRIM судалгааны хүрээлэн төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой сургалтын байгууллагыг сонгох зөвлөх үйлчилгээг хийж гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, дүүргүүд болон хорооны төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан. Судалгааны зорилго нь төрийн албан хаагчдын сургалт болон сургалт зохион байгуулж буй байгууллагуудын талаарх санал бодол, сургалтын цаашдын хэрэгцээг тодорхойлох юм. Судалгаанд төрийн албанд 2-оос доошгүй жил ажилласан нийт 382 төрийн албан хаагчдыг хамруулсан.

Судалгааг зохион байгуулсаны дараа сургалтын байгууллагуудын чадавхийг үнэлсэн. Төрийн албан хаагчдад сургалт зохион байгуулах

сонирхолтой сургалтын байгууллагуудыг татан ороцуулахын тулд нээлттэй сонгон шалгаруулалт явуулсан. Төрийн болон хувийн хэвшлийн төлөөлөл болсон нэлээд олон сургалтын байгууллагууд үнэлгээнд хамрагдах сонирхлоо илэрхийлсэн. Байгууллагын чадавхийг үнэлэхдээ гол оролцогч талуудтай хагас бүтэцчилэгдсэн ярилцлага хийн ажиглалтын шалгах хуудсаар мэдээлэл авсан.


ҮР ДҮН

1. Сургалтын хэрэгцээний үнэлгээ

Төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж буй сургалт, сургалтын үр дүн, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс зэрэг судалгааны үр дүнг энэхүү хэсэгт танилцуулъя.

Судалгаанд оролцогчдын 86 хувь нь байгууллагаас нь тогтмол сургалт явуулдаг гэж хариулжээ. Мөн оролцогчдын 94 хувь нь зохион байгуулсан сургалт тэдний сургалтын хэрэгцээнд нийцсэн гэж үзсэн ба цаашид сургалтанд хамрагдах сонирхолтой болохоо олонхи нь илэрхийлж байсан юм. Судалгаанд оролцогчид сургалтын үр дүн, үр нөлөөг 10 онооноос 8 оноогоор үнэлсэн байна. Сургалтын ямар хэлбэрийг хамгийн тохиромжтойд үзэж байгааг авч үзвэл судалгаанд оролцогчдын олонхи нь (бараг 80 хувь) танхимын болон практик сургалт хослосон сургалтыг илүүд үзэж байна.

Дүрс. 1: Сургалтын тохиромжтой хэлбэр, хувиар



Сургалтын үр дүнд нөлөөлж буй гол хүчин зүйлийг үзвэл сургагч багшийн чадвар, сургалтын материалын чанар болон сургалтын төлбөр зэрэг байна.

2. Сургалтын байгууллагуудын чадавхийн үнэлгээ

Төрийн байгууллага болон хувийн байгууллагуудтай харьцуулахад, төрийн бус байгууллага нь санхүүгийн байнгын эх үүсвэр арай дутмаг байна. Энэ шалтгааны улмаас ТББ мэргэжил, чадвартай хүний нөөцөө хадгалж авч үлдэх, улмаар сургалтын чанар, зохион байгуулж сургалтын хөтөлбөрүүдийг жигд тасралтгүй явуулахад нөлөөлж байна. Тогтвортой санхүүгийн болон хүний нөөц дутмаг байдал нь эдгээр байгууллагуудын үйл ажиллагаагаа албажуулах, өөрсдийн нөөц хөрөнгөтэй (сургалтын хэрэглэгдэхүүн, төхөөрөмж болон сургалтын орон зай) болоход хязгаарлалт болж байна.

Нөгөө талаас сургалт авч буй байгууллагуудын санхүүгийн нөөц бага байдаг тул ажилтнууддаа тэр бүр сургалтанд хамруулж чаддаггүй, хүний нөөцдөө илүү анхаарах боломжийг нь хаагдуулж байна. Тухайлбал, хязгаарлагдмал санхүүгийн нөөцтэй байгууллагууд гол төлөв сургалтын үр нөлөөний үнэлгээ болон давтан сургалт зэрэг агуулга тусгагдаагүй сургалтын хөтөлбөрийг сонгох байдалд хүрж байна.

Эерэг үр дүнгээс дурдвал, сургалтын байгууллагууд нь сургалтын хөтөлбөртөө уламжлалт аргуудыг ашиглахаас зайлсхийж бүтээлч оролцооны аргуудыг өргөнөөр ашиглаж байна. Мөн олон улсын байгууллагууд, сургалтын институттэй идэвхитэй хамтран ажиллаж, шинэ шинэ сургалтын арга, аргачлалуудыг нэвтрүүлж өөрсдийн сайн туршлагыг бий болгож байна.

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Судалгаанд оролцогч төрийн албан хаагчид хөгжүүлэх сургалтанд хамрагдах сонирхол их, сургалтын үр нөлөөг нь сайн гэж үзэж байгаа тул тэдэнд чиглэсэн ур чадвар олгох, чадавхижуулах сургалтыг зохион байгуулах бүрэн боломжтой байна. Төрийн албан хаагчидын хамрагдсан сургалт нь ажлын бүтээмж, гүйцэтгэлд ихээхэн эерэг үр нөлөөтэй байна. Мөн цаашид зохион байгуулвал зохих сургалтын хэрэгцээгээ мэддэг, тодорхой, бүрэн дүүрэн ойлголттой байна. Судалгааны үр дүн нь төрийн албан хаагчдын авахыг хүсч буй сургалтын хэрэгцээг маш тодорхой болгож өгсөн тул цаашид сургалтын байгууллагуудыг сонгохдоо ашиглаж болно.

Сургалтын байгууллагууд нь олон улсын байгууллагууд болон өөр хоорондоо хамтрах замаар өөрсдийн сургалтын хөтөлбөртэй шинэ арга, аргачлалыг нэвтрүүлж байна. Сургалтын хөтөлбөр боловсруулалт болон сургалтын зохион байгуулалтын хувьд, мэргэжлийн байгууллагууд болон холбогдох чиглэлийн өндөр чадавхитай зөвлөхүүдийг гэрээгээр ажиллуулах хэлбэр нийтлэг байна.

Сургалтын үр дүнд тулгуурлан Хотын Засаглал төсөл нь НЗДТГ-тай хамтран цаашдаа мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж байна. Мөн төрийн албан хаагчдын чухал гэж тодорхойлсон хүчин зүйлүүдийг ашиглан сургалтын байгууллагуудыг эрэмбэлж, үйлчилгээ үзүүлэгч сургалтын байгууллагуудын талаархи мэдээллийн бааз үүсгэхээр төлөвлөж байна. Энэхүү мэдээллийн баазыг Хотын Засаглал төслийн явцад хэрэгжүүлэх чадавхи бэхжүүлэх үйл ажиллагаанд ашиглах боломж бүрдэж байна.

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Авилгатай Тэмцэх Газар (АТГ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь 2016 онд аймаг, нийслэл, дүүргийн авлигын эсрэг авч хэрэгжүүлсэн ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн тайланд дүн шинжилгээ хийх, дүгнэлт, тайлан бэлтгэх юм.



2016

7-р сар

2016

12-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Монгол улсын засаг захиргааны нэгжүүд болох 21 аймаг, 9 дүүргийн ЗДТГ болон НЗДТГ судалгаанд хамрагдсан.



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Авлигатай Тэмцэх Газар (АТГ)-аас хуульд заасан бүрэн эрхийнхээ дагуу төрийн үйлчилгээний хүнд суртлыг багасгах, ил тод, нээлттэй байдлыг хангах, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор дэс дараатай олон ажлыг хэрэгжүүлдэг. Үүний хүрээнд 2008 оноос эхлэн яам, агентлаг, аймаг, нийслэлийн түвшинд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, 2013 оноос төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, хүрсэн үр дүн, тухайн байгууллагын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж хэвшсэн билээ. Энэхүү үйл ажиллагаа нь авлигын эсрэг үйл ажиллагаанд байгууллага, албан тушаалтны санал санаачлагыг өрнүүлэх, олон нийтийн мэдээллийн хүртээмжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

IRIM судалгааны хүрээлэн нь 2016 оны аймаг, нийслэл, дүүргийн авлигын эсрэг хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн.

- Асуумж судалгаа: Төрийн байгууллагын албан хаагчдаас “удирдлагын авлигын эсрэг үйл ажиллагаа зохион байгуулах хүсэл эрмэлзэл, хүчин чармайлт үлгэр жишээ байдал”-ын талаар анкет бөглүүлсэн.
- Цахим хуудсын үнэлгээ: Тухайн байгууллагын албан ёсны цахим хуудаст ажиглалт хийн зориулалтын үнэлгээний хуудас бөглөсөн.
- Ажиглалт: ЗДТГ-уудын үйл ажиллагаатай танилцаж урьдчилан бэлтгэсэн шалгах хуудсын дагуу ажиглалт явуулсан.
- Ганцаарчилсан ярилцлага: ЗДТГ тус бүрээс 2 удирдлагатай гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн.
- Баримт бичгийн шинжилгээ: Төрийн байгууллага тус бүрээс авлигын эсрэг 2016 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, холбогдох нотлох баримтуудад дүн шинжилгээ хийсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН


Үнэлгээг АТГ-ын даргын 2015 оны А/88 дугаар тушаал болох “Төрийн байгууллагаас авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн бөгөөд нийт 19 төрлийн шалгуур үзүүлэлтээр үр дүнг гаргасан.

Судалгаанд тоон ба чанарын судалгааны аргыг хослуулан ашигласан. Үүнд:

ҮР ДҮН

Үнэлгээнд хамрагдсан байгууллагууд 2016 онд дунджаар 58 хувьтай үнэлэгдэж байгаа нь өнгөрсөн 2014, 2015 оноос үр дүнтэй харьцуулбал буурсан үзүүлэлт болж байна.

Дүрс.1: Төрийн байгууллагын дундаж үнэлгээ



Үнэлгээний дундаж үзүүлэлт доош татагдах гол шалтгаан нь зарим аймаг, дүүргүүдийн ЗДТГ-аас авлигын эсрэг хэрэгжүүлсэн жилийн үйл ажиллагааны тайлан, нотлох баримтаа ирүүлээгүй байна.

Төрийн байгууллагуудын үнэлгээний арга зүйд тусгагдсан шалгуур бүрээр задлан авч үзвэл дараах байдалтай байна. Таван үзүүлэлт “дунджаас дээш” үр дүн харуулсан, арван нэгэн үзүүлэлт “дундажтай ойролцоо” үр дүн харуулсан, гурван үзүүлэлт “дунджаас доош” үр дүн харуулсан. Цаашид байгууллагууд гүйцэтгэлийг сайжруулах тал дээр ахицтай ажиллах шаардлагатай гэж үнэлэгдсэн байна. Дунджаас доогуур үнэлэгдсэн буюу цаашид анхаарч шаардлагатай 3-н үзүүлэлтийг авч үзвэл:

- Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг ба шийдвэрийн төслийг олон нийтэд танилцуулах, сонирхогч бүлгүүдтэй харилцан санал солилцох
- Төрийн хяналтын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах
- Авлигатай тэмцэх зорилго бүхий төрийн бус байгууллага, иргэдийн сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, үйл ажиллагаандаа татан оролцуулах гэсэн үйл ажиллагааны биелэлт хангалтгүй үр дүнг харуулсан.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Үр дүнд суурилсан дараах зөвлөмжүүдийг дурдаж байна.

- ЗДТГ-уудын хувьд авлигын эсрэг үйл ажиллагааны тайлан мэдээгээ тухайн жилийн 11-р сарын 15-ны дотор АТГ-д ирүүлж ажиллах тал дээр анхаарах хэрэгтэй байна.

- Мөн байгууллагуудын жил тутмын тайланд тухайн жилийн мэдээлэл, нотлох баримтыг тусгахаас гадна цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ болон тулгарч буй бэрхшээл, ололт амжилттай холбоотой дүгнэлт, шинжилгээг өөр өөрсдийн байгууллагын жишээн дээр тусгаж байх нь үр дүнтэй байна.
- Цахим хуудас болон бусад эх сурвалжаар мэдээллийг ил тод болгох олон нийтэд мэдээлэх тал дээр хуульд заагдсан хугацааг баримталж ажиллах хэрэгтэй байна. Тухайн жилийн эхэнд эвсэл эхний хагас жилд багтаан мэдээлэх зарим мэдээллүүдийг 3, 4-р улиралд цахим хуудсандаа оруулж байгаа нь тухайн мэдээллийн үнэ цэнэ алдагдах, ашиглах боломж багасах зэрэг сул талуудыг үүсгэж байгааг анхаарах хэрэгтэй юм.
- Шилэн дансны хуулиар зохицуулагдаж буй мэдээллийн ил тод байдлыг хангахдаа “шилэн дансны нэгдсэн цахим хуудас”-ыг ашиглах, түүнд мэдээлэл оруулах байдал сайжирсан ч өөрийн цахим хуудсандаа шилэн дансны нэгдсэн цахим хуудсаас мэдээлэл авч болох талаар заавар мэдээлэл оруулах эсвэл шилжих холбоосыг заавал байршуулах шаардлагатай байна.
- Байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг өмнөх жилийн ололт амжилт, хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд суурилан төлөвлөх хэрэгтэй. Энэ нь авлигын эсрэг явуулж буй үйл ажиллагааг залгамж халаатай байх, хоорондын уялдаа холбоог хангахад эерэг үр нөлөөтэй. Цаашлаад нийслэл, дүүргийн төвшин дэх үр дүнтэй арга хэмжээг тодорхойлох, үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах боломжийг олгох юм.

ИРГЭДИЙН ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА



Нээлттэй
Нийгэм
Форум

IRIM
INSTITUTE FOR
RESEARCH AND
INNOVATION
MANAGEMENT



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нээлттэй Нийгэм Форум (ННФ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Нээлттэй Нийгэм Форум (ННФ) нь Монгол улсад эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэх замаар алслагдмал, эмзэг бүлгийн иргэдийн амьжиргааг сайжруулах зорилготой “Иргэдийн эрх зүйн чадавхийг дээшлүүлэх нь” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлээд байна. Тус хөтөлбөрийн эхний шат нь үндэсний хэмжээнд, тэр дундаа төвөөс алслагдмал нутагт оршин суугаа ядуу иргэдэд тулгамдаж буй эрх зүйн асуудал, шийдвэрлэж буй арга хэрэгслүүд, эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээ авах өнөөгийн хэрэгцээ, боломжийг тодорхойлох нь энэхүү судалгааны зорилго юм. Цахим хуудаст тавигдсан мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал зөвлөмж боловсруулах.




2016

7-р сар

2017

1-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Судалгаанд Улаанбаатар болон 8 аймгийн (Орхон, Ховд, Дорнод, Өмнөговь, Сэлэнгэ, Говь-Алтай, Өвөрхангай, Баян-Өлгий) нийт 30 сум

ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Хууль зүйн салбарын олон улсын хөгжлийн бодлогын чиг хандлага нь хууль, шүүхийн байгууллагын процесст төвлөрч байсан уламжлалт хандлагаасаа шударга ёсны хүртээмж, иргэдийн эрх зүйн чадавхийг дээшлүүлэхэд илүү чиглэж байна. Энэхүү бодлогын өөрчлөлтийн хүрээнд улс орнууд юуны өмнө иргэдийнхээ хууль зүйн туслалцааны хэрэгцээг судалснаар түүнд үндэслэсэн хэрэглэгч төвтэй, шударга ёсны хүртээмжтэй хууль зүйн үйлчилгээний бодлогыг тодорхойлж, байна. Уг судалгааг дэлхийн 40 гаруй оронд төрөл бүрийн аргаар (утас, цахим хүргэлт болон ярилцлага) хийсэн байна.

Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар “Монгол Улсын хэмжээнд шударга ёсны үйлчилгээний хүртээмж, алслагдмал, эмзэг бүлгийн иргэдийн хууль зүйн туслалцааны хэрэгцээг тодорхойлох судалгаа”-г Монгол Улсад анх удаа олон улсын арга зүйд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгааны дизайн нь ННФ-аас хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор иргэдийн амьдралд тулгарч байгаа бэрхшээлийг судлах замаар хийгдсэн ба тэдний туршлагад суурилсан иргэдийн “ойлголт” (perception) судалгаа юм. Судалгаанд түүврийг сонгох олон давхаргад түүврийн аргыг ашиглан иргэдийн хууль зүйн туслалцааны хэрэгцээг тодорхойлсон ба 7 аймгийг сонгохдоо тэднийг бүсчилсэн байдлаар сонгосон. Аймаг бүрээс авах түүврийн хэмжээг тогтоохдоо пропорциональ аргыг ашигласан. Өрхийг сонгохдоо кластер болгон багцалж санамсаргүй түүврийн аргаар сонгосон.

Судалгааны арга зүй нь хосолмол, хоёр шатлалттай байв.

- 1. Арга зүйн хүрээг тодорхойлох экспертүүдийн урьдчилсан судалгаа (scoping study):** Иргэдийн хууль зүйн туслалцааны хэрэгцээг тодорхойлох гол шалгуур, үндсэн хүрээг тодорхойлох

зорилготойгоор 15 эксперттэй гүнзгийрүүлсэн ярилцлага хийсэн.

2. Иргэдийн хууль зүйн хэрэгцээг тодорхойлох судалгаа: Иргэдийн хууль зүйн туслалцааны хэрэгцээ, нийтлэг тохиолдож буй хэрэг явдал, түүнийг шийдвэрлэж буй арга зам, арга хэрэгсэл, тулгамдаж буй асуудал, хууль зүйн туслалцааг хүртээмжтэй болгох үр дүнтэй арга хэрэгсэл зэргийг тодорхойлох зорилгоор 1630 иргэнтэй нүүр тулсан ярилцлага хийв.

Бид хууль зүйн асуудлуудаа 15 ерөнхий бүлэг 80 дэд асуудлуудад хуваан мэдээлэл цуглуулсан.

Судалгааны асуулгыг 4 гол хэсэгт хуваан мэдээлэл цуглуулсан. Үүнд:

1. Иргэдэд тулгарч буй нийтлэг бэрхшээл
2. Бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд мэдээлэл, туслалцаа авах байдал
3. Бэрхшээлийг шийдвэрлэх байдал
4. Хууль зүйн тогтолцоонд итгэх иргэдийн итгэл гэсэн түвшинд мэдээлэл цуглуулсан.

ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан иргэдийн 54.8 хувьд хуулиар шийдүүлэх асуудал буюу хууль зүйн үр дагавар бүхий бэрхшээл (цаашид “бэрхшээл” гэх) сүүлийн 3 жилд тулгарсан байна. Үүнд нийт 2618 бэрхшээл тулгарсан бөгөөд нэг хүнд ноогдох бэрхшээлийн тоо дунджаар 1.6 байна.

Дүрс 11. Бэрхшээл тохиолдсон иргэдэд тулгарсан бэрхшээлийн төрөл, давхардсан тоогоор (N=894)



Иргэдээр судалгаанд хамруулсан 15 төрлийн бэрхшээлийг ноцтой байдлаар нь үнэлүүлэхэд бүгд дундаас дээш үнэлгээ авснаас харвал иргэд эдгээр бэрхшээлийг бүгдийг шийдвэрлэх шаардлагатай ноцтой бэрхшээл гэж үзэж байна.

Бэрхшээл тулгарсан иргэдийн 49.5 хувь нь (443 иргэн) бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд ямар нэг арга хэмжээ авсан байх бөгөөд үүнээс 19.4 хувь (174 иргэн) нь хэн нэгнээс мэдээлэл, туслалцаа авах оролдлого хийжээ. Маш цөөн иргэн төрийн бус байгууллага, нотариатын байгууллага, хүний эрхийн комисс, Хууль Зүйн Клиник Төв, Хууль Зүйн Туслалцааны Төвөөс туслалцаа бага авчээ. Туслалцаа авахаар оролдсон иргэдийн 27.2

хувьд ойр дотныхондоо, 11.6 хувь нь цагдаад, 10.8 хувьд нь холбогдох төрийн байгууллагад хандсан байна.

Хэн нэгнээс туслалцаа аваагүй иргэдийн дунд юу ч хийгээд нэмэргүй гэж бодсон (24.7%), юу хийхээ мэдэхгүй (17.1%), тийм ч ноцтой асуудал биш гэж бодсон (11.6%), өөрт ямар эрх байгааг мэдээгүй (10.5%) хүмүүс байна.

Эдгээр иргэдээс 99 нь буюу нийт бэрхшээл тулгарсан иргэдийн 11.1 хувь нь асуудлаа бүрэн шийдүүлж чаджээ. Бэрхшээлээ шийдвэрлэж дууссан иргэдийн сэтгэл ханамж дундаас дээгүүр түвшинд байна. Эсрэгээрээ 143 иргэн (32.3 хувь) нь асуудлаа хөөцөлдөлгүй орхижээ. Асуудлаа

хөөцөлдөхөө больж байгаа гол шалтгаан нь ихэнхдээ эерэг үр дүн гарна гэдэгт эргэлзсэн (22.4%), цаашаа хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүй (18.1%), цаашид хөөцөлдвөл хэт их цаг үрнэ (15.2%), зардал шаардана (10%) гэж үздэгтэй холбоотой байна.

Судалгааны нэг онцлог нь эрх зүйн чадавхийн хувьд эмзэг бүлгийг тодорхойлох явдал байв. Тодруулбал, бэрхшээл тулгарсан ч ямар нэг байдлаар шийдвэрлэх боломжгүй, эсвэл хэрхэн шийдвэрлэхээ мэдэхгүй байгаа иргэдийг энэ бүлэгт хамруулсан. Энэ бүлэгт хамаарагдах иргэд нийт түүвэрт хамрагдагсдын 15.6 хувийг эзэлж байгаа бөгөөд ихэнхидээ боловсрол доогуур, орлого багатай иргэд багтаж байна.

Нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 43 хувь нь дээрх бэрхшээлүүд өөрт нь тулгарвал хаана, хэнд хандахаа мэдэхгүй байна. Харин энэ талын мэдлэг, мэдээллийг харъяа Засаг даргын тамгын газрын хариуцах ажилтнаас 19.6 хувь, хамгийн ойрын хуульч өмгөөлөгчөөс 13 хувь, интернет, тусгайлсан вебсайтаас 10.8 хувь нь авах сонирхолтой байна.

Хууль, шүүхийн байгууллага шударга ажилладаг гэж иргэдийн 26.9 хувь, дунд зэрэг гэж 35.3 хувь, шударга бус ажилладаг гэж 37.9 хувь нь үзэж байна. Сонирхолтой нь, хэрэв тухайн иргэн шүүхийн маргаанд оролцвол хууль, шүүхийн тогтолцоо өөрт нь шударга хандана гэх бүрэн итгэлтэй 39.2 хувь, дунд зэргийн итгэлтэй 23.9 хувь, итгэлгүй 36.9 хувь байна. Гэхдээ хууль, шүүхийн байгууллага баян, ядуу ялгаварлалгүй үйлчилж чадахгүй гэж нийт иргэдийн 62.2 хувь нь хариулжээ.

ДҮГНЭЛТ

Туслалцаа авсан иргэд албан бус журмаар эрх зүйн туслалцаа авсан тохиолдол хамгийн түгээмэл байна. Хуульч өмгөөлөгчийн туслалцааны хэрэгцээ нь тухайн асуудлын (бэрхшээлийн) хууль зүйн нөхцөл байдлыг ойлгох, дүгнэх, хуулийн талаас нь тайлбарлах, гарц олох, шүүхэд төлөөлөх асуудал дээр илүү байна. Нийт иргэдийн талаас илүү хувь нь ямар нэгэн хуулийн бэрхшээл тохиолдвол хаана хандахаа мэдэхгүй байгаа нь бэрхшээлээ шийдвэрлэх гэж оролдохгүй байгаа, туслалцаа авахгүй байх гол шалтгаан болж байна. Тиймээс бэрхшээл тулгарч буй иргэдийг асуудлаа таньж, хуулийн салбарын туслалцаа авах мэдлэг, мэдээллээр хангах иж бүрэн стратеги боловсруулах хэрэгтэй нь харагдлаа.

Судалгаанд оролцсон иргэдийн талаас илүү хувь Монголын хууль, шүүхийн тогтолцоонд итгэл муутай байна. Ялангуяа бэрхшээл тулгарсан иргэд хууль, шүүхийн тогтолцоонд итгэх итгэл бүр ч бага байна. Гэхдээ бэрхшээлээ шийдүүлэхийн тулд шүүхэд хандсан иргэдийн хувьд шүүхийн тогтолцоонд итгэх итгэл шүүхэд хандаагүй иргэдийнхээс илүү өндөр байна. Үүнээс үүдээд, шүүхэд хандаагүй иргэд хууль зүйн тогтолцооны тухайд шүүхийн шинэчлэлээс өмнөх үеийн төсөөлөлтэй байгаа бол шүүхэд хандсан туршлагатай иргэд энэхүү өөрчлөлтийг мэдэрч эхэлсэн гэж дүгнэж болох юм.

Бид энэ судалгаагаар дамжуулан Монгол Улсын хууль зүйн тогтолцоог боловсронгуй болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэгч талуудад ашиглагдах томоохон суурь судалгааны үр дүн болсон гэж найдаж байна.

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА



IRIM



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Зорилго: ЦЕГ-аас хэрэгжүүлж байгаа үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг үнэлэх, үйлчилгээ тэгш, хүртээмжтэй, чанартай, хүний эрхийг хүндэтгэсэн, хүнд сурталгүй, шуурхай байгаа эсэх талаар иргэд, үйлчилгээ авагчдын сэтгэл ханамж, хандлагыг судална.



2016

9-р сар

2016

11-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотод хэрэгжсэн

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журмын” 59, 60 дахь хэсэг болон Хууль зүйн сайдын А/175 тоот тушаалын дагуу ЦЕГ нь хэрэглэгчийн үнэлгээг жил бүр хөндлөнгийн судалгааны байгууллагаар гүйцэтгүүлдэг. Энэ нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээний чанар, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судлах нь ач холбогдолтой.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Үнэлгээнд Хууль зүйн сайдын А/175 тоот тушаалд тусгагдсаны дагуу ЦЕГ-ын харьяа 7-н байгууллага, 8-н үйлчилгээг хамруулсан.


Судалгаа авах үед цагдаагийн байгууллагаас үйлчилгээ авч байсан 240 иргэнийг түүвэрлэн асуумж судалгаанд хамруулсан.

ҮР ДҮН

МЭДЭЭЛИЙН ХҮРТЭЭМЖ

Иргэдийн цагдаагийн байгууллагатай холбоотой шаардлагатай мэдээллээ ямар эх сурвалжаас авахыг илүүд үзэж буйг дараах дүрсээр харууллаа.

Дүрс 1. Иргэдийн мэдээлэл авахыг хүсч буй эх сурвалж, хувиар




Иргэдийн ихэвчлэн мэдээлэл авахыг хүсэж буй эх сурвалжаар интернет, телевиз гэсэн мэдээллийн эх сурвалжууд нэрлэгдэж байна. Энэ нь мэдээлэл ихэвчлэн авдаг болон авахыг хүсэж буй сувгууд хоорондоо шууд хамааралтай байгааг илтгэж буй тул эдгээр мэдээлэл түгээх эх сурвалжуудыг түлхүү ашиглах нь үр дүнтэй байна.

Судалгаанд оролцогчдын талаас илүү хувь нь цагдаагийн байгууллагын талаарх мэдээллийг бүрэн хэрэгцээтэй байдаг гэж үнэлсэн бол 40

орчим хувь нь зарим мэдээллүүд нь хэрэгцээтэй байдаг гэж үнэлсэн байна. “Огт хэрэгцээгүй мэдээлэл байдаг” гэж хариулт өгсөн судалгаанд оролцогчид сэрэмжлүүлэг мэдээлэл болон ажлын тайлан, мэдээллийг өөрт ач холбогдолгүй гэсэн байдлаар хандах тохиолдол байна.

Үйлчилээний чанартай байдал-Үйлчилгээ авсан иргэдийн шаардлагатай үйлчилгээгээ бүрэн авсан эсэхийг дараах дүрсээр харууллаа.

Дүрс 2. Үйлчилгээний чанартай байдлын үнэлгээ



Нийт судалгаанд оролцогчдын 70 гаруй хувь нь цагдаагийн байгууллага үйлчилгээгээ хангалттай сайн үзүүлж чаддаг гэж, 7 хувь нь хангалтгүй муу үйлчилгээ үзүүлдэг гэж үзсэн байна. Судалгаанд хамрагдсан иргэдийн 45 орчим хувь нь тухайн үед авсан үйлчилгээгээ бүрэн авч чадаагүй, дутуу шийдвэрлэгдсэн гэсэн хариултыг өгсөн бол 40 орчим хувь нь тухайн асуудлаа бүрэн шийдвэрлүүлсэн байна.

Судалгааны мэдээллээс харахад цагдаагийн байгууллагаар үйлчлүүлэгчид үйлчилгээний чанарыг сайн гэж үнэлж, сэтгэл ханамжтай байгаа ерөнхий дүр зураг харагдаж байна.

Үйлчилгээний шуурхай байдал-Судалгаанд оролцсон иргэдийн дийлэнх буюу 53 хувь нь дуудлагын дагуу шуурхай ирнэ гэж итгэдэг болохоо илэрхийлжээ. Харин 5 орчим хувь нь дуудлага өгсөн ч шуурхай ирнэ гэдэгт итгэдэггүй гэсэн хариултыг сонгосон байна. Дуудлагын дагуу түргэн шуурхай үйлчлэх байдалд хариулт өгсөн судалгаанд оролцогчдын хувьд хүйс, цагдаагийн байгууллагаар үйлчлүүлж байгаа тоо, авч буй үйлчилгээний төрөл зэргээс хамаарсан ялгаа ажиглагдахгүй байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн тал хувь нь нэг өдрийн дотор шаардлагатай үйлчилгээгээ авч, асуудлаа шийдүүлж чадаж байгаа бол, 10 орчим хувь нь нэг болон түүнээс дээш өдрийг үйлчилгээ авахад зарцуулж байна.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

- Цагдаагийн байгууллагатай холбоотой мэдээллийг иргэд ихэвчлэн интернет, телевиз гэсэн эх сурвалжаас авч байна. Цаашид эдгээр мэдээллийн эх сурвалжаас мэдээ, мэдээлэл авахаас гадна лавлах утас, утасны мессеж гэсэн эх сурвалжаар мэдээлэл авах сонирхолтой байна. Мөн интернет эх сурвалж ашиглахдаа зөвхөн вебсайтаас гэлтгүй фэйсбүүк хуудас, гар утасны аппликейшн зэргийг ашиглах нь хүмүүсийн хэрэгцээ, сонирхлыг татах үр дүнтэй арга болж болох юм.
- Цагдаагийн байгууллагын үйлчилгээний түргэн шуурхай байдлыг сайжруулахын тулд ТҮЦ машин, лавлах утас, интернет үйлчилгээ ашиглах боломжийг эрэлхийлэх хэрэгцээтэй байна. Мөн төрийн нэг цонхны үйлчилгээнд цагдаагийн байгууллагын зарим үйлчилгээг байршуулсан тохиолдолд иргэд, олон нийтийн хүлээлтэд нийцсэн үйл ажиллагаа болох юм.
- Цагдаагийн байгууллагаас үйлчилгээ авагчдын хувьд үйлчилгээний чанарыг хамгийн өндөр онооны дундажтай үнэлсэн бол, үйлчилгээний шуурхай байдлыг хамгийн бага оноогоор үнэлсэн байна.
- Ажилтнуудын шударга байдал, хууль хэрэглэх чадварыг үйлчлүүлэгчид өндрөөр үнэлж байгаа учир ажилтнуудыг чадваржуулах, мэдлэг боловсролыг дээшлүүлэх үйл ажиллагаагаа бататгах, хадгалж үлдэх нь чухал байна.

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ БА НОГООН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ОРОН НУТГИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГУУДЫН СУУРЬ СУДАЛГАА

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH

 Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг (ГОУХАН)

Швейцарийн Хөгжлийн Агентлагын (ШХА) санхүүжилтээр төсөл хэрэгжсэн.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү суурь судалгаа нь орон нутгийн тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй боловсролын байгууллагуудын мэдлэг олгох үйл ажиллагаа, тулгарч буй бэрхшээл, эрсдэл, боломж, байгууллагуудын чадавхи, нөөц болон өрсөлдөх чадварыг тодорхойлох зорилготой юм. Мөн судалгааны үр дүнд тулгуурлан орон нутагт ногоон хөгжил болон тогтвортой хөгжлийн боловсролын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах юм.




2015

12-р сар

2016

3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Төсөл Дархан, Эрдэнэт хот, Ховд, Сүхбаатар, Өвөрхангай зэрэг таван аймаг болон Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүдэд хэрэгжсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн Газар нь 1992 онд РиоДе-Жанейро хотноо зохион байгуулагдсан Байгаль орчин, хөгжлийн талаарх НҮБ-ын дээд хэмжээний уулзалтаас хойш тогтвортой хөгжлийн бодлогыг Монгол Улсад хэрэгжүүлэх чиглэлээр идэвхи санаачлагатай ажиллаж байна.

Мөн Швейцарийн Хөгжлийн Агентлаг нь хамтын ажиллагааны стратегийн дагуу Монгол Улсад тэгш амьдрах боломжийг бий болгох, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад анхаарлаа хандуулж ирсэн юм. БСШУЯ болон БОНХАЖЯ-тай хамтран “Тогтвортой Хөгжлийн Боловсрол” төслийг төлөвлөн санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн ба энэ төслийг ГОУХАН хэрэгжүүлж байна.

ТХБ төслийн зорилго нь тогтвортой хөгжлийн боловсролыг Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн (ЕБС) системд нэвтрүүлж, тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн таатай

(институцийн, эрх зүйн, зохион байгуулалтын) орчинг бүрдүүлэхэд чиглэж байна. Мөн ТХБ-ын үзэл санааг жирийн иргэд болон шийдвэр гаргагчдын дунд төлөвшүүлэх, төсөлд хамрагдсан аж ахуйн нэгж, компани, байгууллагууд байгаль орчны удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, ISO 14001 баталгаажуулалт хийлгэх зорилготой юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Суурь судалгааны мэдээллийг ярилцлага, баримт бичгийн судалгаа зэрэг чанарын судалгааны арга болон асуумж, ажиглалт зэрэг тоон аргуудаар цуглуулсан.

Асуумж нь багш болон сурагчдад зориулагдсан ба тэдний дунд тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн үзэл баримтлалын талаархи мэдлэг, хандлага, дадал ямар байгааг тодорхойлох юм.

ТХБ төслийн зорилтот орон нутаг дахь ЕБС-ийн сурагчид, багш нарыг санамсаргүй түүврийн аргаар сонгосон ба нийт 250 багш, 524 сурагчдаас асуумжийн аргаар мэдээлэл авсан.

Оролцогч талуудтай хийсэн ярилцлага нь тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд, орон нутгийн боловсролын байгууллагуудын үйл ажиллагаа, давуу тал, сул тал, боломж, аюулыг үнэлэн тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулахад тулгарч буй бэрхшээл, эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн. Нийт 51 байгууллагыг ярилцлаганд хамруулж, ажиглалтын шалгах хуудасны тусламжтайгаар ажиглалт хийсэн.

Мөн судалгааны баг нь судалгаанд хамрагдсан боловсролын байгууллагуудын эрх мэдэл, үүрэг, хуулийн статус, айл ажиллагааны төлөвлөгөө, тогтвортой хөгжил ба ногоон хөгжлийн сургалтын хөтөлбөр, тайлан болон холбогдох баримт бичигт шинжилгээ хийн ажиллаа.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийн хүрээнд энэ хэсэгт мэдээлэл оруулах боломжгүй болно.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН УДИРДАХ АЖИЛТАНД ТАВИГДАХ МЭРГЭЖЛИЙН ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



Хөдөлмөрийн яам



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Хөдөлмөрийн Яам

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Зөвлөх үйлчилгээний зорилго нь Мэргэжлийн Боловсрол Сургалтын (МБС) байгууллагын удирдах ажилтанд тавих мэргэжлийн шаардлагыг боловсруулах явдал юм.

Судалгааны зорилгын хүрээнд дараах үндсэн зорилтуудыг тавьж ажилласан.

1. МБС-ын байгууллагын удирдах ажилтантай холбоотой мөрдөгдөж буй хууль, дүрэм журам, бодлогын баримт бичиг, мэргэшлийн хүрээ, ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээ зэрэг баримт бичгүүдийг судлах
2. МБС-ын байгууллагад ажиллаж буй удирдах ажилтнуудын өнөөгийн туршлага, ур чадвар, удирдлагын арга барилын талаар мэдээлэл цуглуулах, түүнчлэн Хөдөлмөрийн Яам, ажил олгогч тал, бусад оролцогч талуудаас хүсч буй МБС-ын байгууллагын удирдах ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлох хэрэгсэл, арга зүйг боловсруулах
3. Хүчин зүйлийн шинжилгээ хийх замаар мэргэжлийн шаардлагуудыг тодорхойлох
4. Одоо ажиллаж байгаа МБС-ын удирдах ажилтны ангилал тогтоох, түвшин тус бүрт байх шаардлагыг тогтоох, сургалтын хэрэгцээг тогтоох



2016

7-р сар

2016

10-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монголын мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг олон улсын чиг хандлагад нийцүүлэн бусад улс орнуудын түвшинд хүргэх, жишихүйц болгох, гадаад орнуудтай боловсролын дипломыг харилцан хүлээн зөвшөөрөх харилцааг хөгжүүлэх, кредит систем бий болгох, сургалтын хөтөлбөрийн уян хатан байдлыг хангах, төгсөгчидийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зэрэг чиглэлээр анхааран ажиллаж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавраас шалтгаалан тоон болон чанарын судалгааны аргуудыг ашигласан. Мөн баримт бичгийн шинжилгээг одоо мөрдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүд, олон улсын туршлагыг судлахад ашигласан. Сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгааг төрийн өмчийн 37-н МБС-ын захирлуудаас утсаар ярилцан мэдээлэл авсан.

ҮР ДҮН

- МУ-ын “Боловсролын тухай хууль” болон “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль”-д МБС-ын удирдах ажилтанд тавих мэргэжлийн шаардлага, түүний ур чадварын талаар тусгасан зүйл, заалт алга байна.
- Монголын МСҮТ-ийн удирдах албан тушаалтанд тавьж байгаа шалгуурыг авч үзвэл боловсрол, мэргэжил, мэргэшил, ажлын туршлага зэрэг хэт ерөнхий байгаа бөгөөд тухайн шалгуурыг хангаж байгааг батлан харуулахыг шаардаагүй байгаа нь нэг дутагдал болж байна. Монгол улсын хувьд энэ ажлын байрны мэргэжлийн шаардлага (Competence Framework) боловсруулагдаагүй байгаа

нь тухайн албан тушаалд томилох хүний ур чадварын шалгуурыг нарийн гаргахад саад болж байна.

- МТБ-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр: Дунд хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн баримт бичигт МБС-ын багш, удирдах ажилтны мэргэшлийн ур чадварыг тодорхойлж, цаашид хөгжүүлэх болон “МБС-ын удирдах ажилтны хөгжил” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх зэрэг ажил орсон.
- МБС-ын багшийн хөгжлийн хөтөлбөрт багшийг чадавхжуулан удирдах албан тушаалтан болж өсч дэвшихэд нь чухал үр дүнтэй байх зорилтууд орсон байна.
- Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмаар тогтоосон үр дүнгийн гэрээний загварыг ашиглан МБС-ын удирдах ажилтны үр дүнгийн гэрээг байгуулж байгаа боловч шалгуур үзүүлэлт нь хэмжиж болохуйц, хугацаатай, чанарын өөрчлөлтийг харуулах зэрэг шаардлагад нийцэхгүй байна.
- Үр дүнгийн гэрээгээр удирдах ажилтны хийх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж өгсөн хэдий ч түүний хэрэгжилтийн явц, гүйцэтгэлд хяналт тавих, эрсдлийг тодорхойлох, хяналт шинжилгээ болон үнэлгээ хийх талаар дурдаагүй орхигдуулсан байна.
- МБС-ын салбарын хүний нөөцийн сургалтын хөгжлийг гол төлөв багшаар хязгаарлаж үндсэн гурван чиглэлээр явуулж ирсэн байна. Үүнд: (i) ТМС-ийн тусгай мэргэжлийн багш, үйлдвэрлэлийн сургалтын мастер нарыг бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх; (ii) багшлах эрх олгох; (iii) зах зээлийн шинэ нөхцөлд ажиллах багш болон мэргэжлийн сургагч нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх. Сургуулийн удирдах

ажилтанд үйлдвэрлэлийн туршлагатай мастер буюу инженерийн боловсролтой хүн ажиллуулж иржээ.

- МБС-ын салбарын хөгжлийн хандлага, техник технологийн хурдацтай өөрчлөлттэй уялдуулан МБС-ын удирдах ажилтанг системтэй сургах тогтолцоо байхгүй байна.
- МБС-ын удирдах ажилтны сургалтыг сүүлийн 20 жилд олон улсын хандивлагч байгууллагын төслөөр санхүүжүүлж байна.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

1. МБСБ-ын удирдах ажилтанд тавих мэргэжлийн шаардлагыг өмчийн хэлбэр харгалзахгүй бүх сургуульд баримтлах талаар зохих эрх зүйн зохицуулалт хийх
2. МБСБ-ын удирдах ажилтанд тавих мэргэжлийн шаардлагын нэг чухал үзүүлэлтэнд эрх зүйн болон санхүүгийн боловсрол, мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байхаар оруулах, зохих сургалтанд хамруулсан байх
3. МБСБ-ын үлгэрчилсэн дүрмээр захиралд сургууль хөгжүүлэх, боловсролыг хөгжүүлэх сан байгуулах, гадаад дотоод ижил төстэй байгууллагатай гэрээ хэлцэл хийх, хамтран ажиллах, төгсөгчийг ажлын байртай холбох арга хэмжээ авах, иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлээ сонгоход нь туслах зэрэг эрх мэдлийг олгосон байна. Үүнийг удирдах ажилтны мэргэжлийн шаардлагын шалгуур үзүүлэлтэнд оруулах нь зүйтэй.
4. Үр дүнгийн гэрээг Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоо болон түүнээс уялдаатайгаар гарах Мэргэжлийн шаардлага (Competence Framework)-тай холбож боловсруулах хэрэгтэй.
5. Салбарын мэргэжлийн хүний нөөцийн сургалтыг салбар дундын зохицуулалт, нэгдсэн бодлоготойгоор явуулах шаардлага байна. Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд МБС-ын мэргэжлийн хүний нөөцийг, тэр дотроо удирдах ажилтныг чадавхижуулах, тасралтгүй сургаж хөгжүүлэх ажлыг удирдан зохицуулах.
6. Удирдлагын Академийн Манлайлалын сургалтын туршлага дээр үндэслэн дипломын зэргийн мэргэшүүлэх сургалт явуулж МБС-ын удирдах албан тушаалд ажиллах хүмүүст зориулсан мэдлэг, чадвар эзэмшүүлэх сургалт явуулах боломж байна. Энэхүү сургалтад МБС-ын салбарт ажиллаж байгаа, өсөх ирээдүйтэй, ажилдаа сонирхолтой (сэдэл тэмүүлэлтэй), албан тушаал ахиулж хөгжихийг эрмэлзсэн, шинийг эрэлхийлэгч залуу багш нарыг сонгон хамруулах.
7. Төрийн Албаны Зөвлөлийн зохих журамд МБСБ-ын удирдах ажилтаныг сонгон шалгаруулахад дээрх сургалтад хамрагдсан байдлыг нэг шалгуур үзүүлэлтээр оруулах
8. ММСС-ын “МБСБ-ын удирдлагын чадавх бэхжүүлэх” дэд төслийн хүрээнд зохион байгуулсан МБС-ын удирдлагын төлөвлөх, удирдах чадавхийг сайжруулах, эрэлтэд нийцсэн, чадамжид суурилсан, үр ашигтай шинэлэг үйлчилгээ үзүүлэх зэрэг чадварыг хөгжүүлэх 9 модуль бүхий сургалтын агуулгыг судлаж, МБС-ын удирдах ажилтны хөтөлбөрт тусгах.

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛИЙН ТӨСӨЛ "ДЭЭД БОЛОВСРОЛЫГ ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛТЭЙ УЯЛДУУЛАХ НЬ" ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам (БСШУСЯ)

Азийн Хөгжлийн Банк (АХБ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь БСШУСЯ болон их, дээд сургуулиудад дараах чиглэлээр техникийн туслалцаа үзүүлэх юм. Үүнд:

- Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгаа, төгсөгчдийг мөшгөх судалгааны загвар, хэрэглэгдэхүүн бэлдэх, зохион байгуулах болон шинжилгээ хийх;
- Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, оюутнуудад ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлдвэрлэлийн сургалтын хөтөлбөр болон хамтарсан судалгааны төслийн талаар гарын авлага бэлтгэх;
- Дээд боловсролын сургалтын байгууллагууд болон БСШУСЯ ба холбогдох байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт, семинар зохион байгуулах ажлуудыг хамарна.



2015

1-р сар

2016

10-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсад 2012-2013 оны хичээлийн жилд 99 дээд боловсролын байгууллагад 13200 багш ажиллан, 175600 оюутан суралцаж байжээ. Үүнээс төрийн сургуулиудад 105800, хувийн сургуулиудад 69400, гадаадын салбар сургуульд 400 орчим оюутан суралцаж байна. БСШУСЯ-наас гаргасан статистик мэдээгээр нийт төгсөгчдийн 59 хувь ажилгүй байгаа нь боловсролтой ажилгүйчүүдийн тоо нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Хэдийгээр хөдөлмөрийн зах зээл дээр мэргэжилтэй, өндөр чадвартай ажилтны эрэлт хэрэгцээ их байгаа ч их, дээд сургууль төгсөгчид ажлын байрны шаардлага хангах мэдлэг, чадварыг эзэмшихгүй төгсөж байна. Мөн олон сургуулиуд зардал багатай, чанар муутай хөтөлбөрөөр сургалт явуулж байна.

Энэ тулгамдсан асуудал нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, ажил мэргэжлийн зөвлөх үйлчилгээ, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, төгсөгчдийн ажил эрхлэлт, төгсөгчдийн талаарх ажил олгогчдын санал бодлын судалгаа, мэдээлэл дутагдалтай байгааг харуулж байна. Зарим их дээд сургуулиуд дээрх асуудлуудтай холбоотой судалгаа, мэдээллийн хэрэгцээг сайтар мэдэрч байна. Тухайлбал, МУИС, ШУТИС, СЭЗДС хөдөлмөрийн зах зээлийн судалгаа болон төгсөгчдийг мөшгөх судалгааг хийн энэ чиглэлээр тэргүүлэн ажиллаж байна. Гэхдээ эдгээр санаачлага нь эхлэлийн шатанд байгаа бөгөөд цаашид дээд боловсролыг хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулах ажлыг эрчимжүүлэх, оюутнуудын ажил эрхлэх чадварыг дээшлүүлэхийн тулд судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүнийг сайжруулах шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Төгсөгчдийг мөшгөх судалгаа (ТМС), Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа (АОСХС) болон Хөдөлмөрийн зах зээлийн

судалгаа (ХЗЗС) хийх;

- ХЗЗС-ны хүрээнд Монгол улсын дээд боловсролын үнэлгээ, ажил эрхлэлт болон дээд боловсролтой хүмүүсийн шилжилтийг үнэлэн, шинжилгээ хийсэн. Энэ шинжилгээ нь хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүдээр хийгдсэн.
 - ТМС-ны цогц хэрэглэгдэхүүнийг ашигласан. Энэ судалгааны шинжилгээ нь цаашид хэд хэдэн жилийн давтамжтай хэрэгжих юм. Мөн энэхүү судалгааны хэрэглэгдэхүүнийг бэлтгэхээс гадна түүврийн хэмжээг тодорхойлох, мэдээлэл цуглуулах, оруулах болон боловсруулах зөвлөмжүүдийг бэлтгэн, боловсруулсан.
 - Их дээд сургуулиуд АОСХС-г гүйцэтгэж, ажил олгогчдын сэтгэл ханамжийн түвшинг үнэлсэн. АОСХС гүйцэтгэхдээ ТМС-аас бүрдсэн мэдээлэл дээр үндэслэн гүйцэтгэсэн. АОСХС-г гүйцэтгэхдээ холбогдох гол байгууллагуудаас бэлтгэгдсэн асуулгын хүрээнд ярилцлагын аргыг ашиглан мэдээлэл цуглуулсан.
2. Гарын авлагуудыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
 - Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэх
 - Оюутнуудад ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх
 - Үйлдвэрлэлийн сургалтын хөтөлбөр болон хамтарсан судалгааны төсөл
 3. Сургалт, хэлэлцүүлгүүдийг БСШУСЯ, их, дээд сургуулиудын мэргэжилтнүүд болон бусад холбогдох талуудыг оролцуулан зохион байгуулах зэрэг үйл ажиллагаанууд багтаж байна.

Төслийн хүрээнд нийт 59 их, дээд сургуулиудыг сургалтад хамруулсан. Үүнээс МУИС, МУБИС, Этүгэн их сургууль, Шинэ анагаах ухааны дээд сургууль, Техник технологийн дээд сургууль болон Гурван-Эрдэнэ багшийн дээд сургуулиудад тогтмол сургалт зохион байгуулсан.



ҮР ДҮН

Хөдөлмөрийн зах зээлийн судалгааны үр дүнгээс харахад, 15-54 насны эмэгтэйчүүдийн 25 хувь нь дээд боловсролтой байхад эрэгтэйчүүдийн дөнгөж 16 хувь нь дээд боловсролтой байна. Нийслэлд ажиллах хүчний 32%, аймгийн төвийн 23%, сумын төвийн 19%, хөдөөгийн ажиллах хүчний 5% нь дээд боловсролтой байна. Улсын дунджаар ажиллах хүчний 6.4 хувь ажилгүй байхад дээд боловсролтой хүмүүсийн 5.6 хувь нь ажилгүй байна. Мөн Монголын дээд боловсролын өгөөж нь 40 хувь буюу дэлхийн дундаж үзүүлэлттэй ойролцоо байна. Хөдөөд боловсролын өгөөж өндөр, хэрэгцээ их боловч хотод дундаж цалин хөдөөнөөс 50%, аймгийн төвөөс 20% илүү байна. Ерөнхийдөө, өндөр боловсролтой хүмүүс хотод шилжин ирж байна.

Төгсөгчдийн мөшгөх судалгааг гүйцэтгэхдээ 2 туршилт асуулгаар хийгдсэн ба ТМС 1 нь төгсөөд нэг жил болсоны дараа, ТМС 2 нь төгсөөд гурван жил болсоны дараах ажил эрхлэлтийн байдлыг судалсан. ТМС 1 ба ТМС 2 судалгааг МУИС, МУБИС, Этүгэн их сургууль, Шинэ анагаах ухааны дээд сургууль, Техник технологийн дээд сургууль болон Гурван-Эрдэнэ багшийн дээд сургуулийн төгсөгчдийн хүрээнд туршигдсан.

Ажил олгогчийн сэтгэл ханамжийн судалгааны хүрээнд, төгсөгчдийн ур чадвар, ажил олгогчдын сэтгэл ханамж, их, дээд сургуулиуд ба ажил олгогч хоорондын хамтын ажиллагааны талаар мэдээлэл цуглуулсан. Энэ судалгааг мөн адил төгсөгчдийн ирээдүйн хэрэгцээнд зориулж сайжруулсан.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Боловсролын салбар нь өөрчлөгдөн буй хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, улс орны өрсөлдөх чадварт нийцэхийн тулд энэхүү хэрэгцээ шаардлагыг мэдэрч, өөрсдийн сургалтын үйл ажиллагааг уялдуулах шаардлагатай юм. Тиймээс ч, сургалтын хөтөлбөрөө шинэчлэх, цаашид боловсронгуй болгох, ажил олгогчидтой нягт хамтарч ажиллах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Хөдөлмөрийн зах зээлтэй уялдаа муутай шийдвэр гаргах нь өөр эрэлттэй мэргэжил, сургалтыг хайх зэрэг санхүүгийн хувьд алдагдалтай нөхцөл байдлыг гэр бүл, оюутнууд боловсролын байгууллагуудад бий болгож байна. Ийм учраас их, дээд сургуулиуд ХЗЗС, ТМС болон АОСХС-ыг тогтмол зохион байгуулах шаардлагатай юм. Бидний боловсруулсан судалгааны хэрэглэгдэхүүн болон хэрэгжүүлсэн сургалтууд нь сургуулиудыг шаардлагатай мэдээллээ цуглуулах, эрсдэлгүй шийдвэр гаргахад нь арга зүйн дэмжлэг болох юм.

БУЛГАН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

World Vision



IRIM

ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Дэлхийн Зөн-Монгол Олон Улсын Байгууллага (ДЗМОУБ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү үнэлгээний зорилго нь Булган Орон Нутгийн Хөгжлийн Хөтөлбөр (БОНХХ)-ийн өнгөрсөн 15 жилийн хугацаанд хүүхэд, гэр бүл, олон нийтийн сайн сайхан байдалд үзүүлсэн урт хугацааны үр нөлөөг үнэлэх явдал юм.



2016

2-р сар

2016

4-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Тус төсөл нь Булган аймгийн хүрээнд хэрэгжиж байна.

ҮНДЭСЛЭЛ

1999 онд Булган аймагт анхны Орон Нутгийн Хөгжлийн хөтөлбөр /ОНХХ/ хэрэгжиж эхэлснээс хойш ДЗМОУБ-ийн төсөл хөтөлбөрүүд маш хурдацтай өсөж дэвжиж, өргөн хүрээг хамарч байгаа билээ. Ядуурал, ажилгүйдлийн түвшин, дэд бүтцийн хөгжил, нийгмийн үйлчилгээний хүртээмжгүй байдал зэрэг шалгуур үзүүлэлтүүд дээр үндэслэн Булган аймгийн долоон сумыг тус хөтөлбөрийн зорилтот бүс болгон сонгосон. Хөтөлбөрийн нийт хэрэгжилтийн хугацаанд 28,000 гаруй хүн төслийн үр шимийг шууд болон шууд бус байдлаар хүртсэн байна.

ОНХХ нь дараах таван асуудалд чиглэдэг:

- Эмнэлгийн шинэ тоног төхөөрөмжүүдтэй болсоноор эрүүл мэндийн үйлчилгээны чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлсэн.
- Эмч нарын чадавхийг бэхжүүлэхэд чиглэсэн ажлууд нь эрүүл мэндийн үйлчилгээг тухайн орон нутгийн онцлогт тохирсон байдлаар, илүү түргэн шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлсэн.

- Орон нутгийн засаг даргын захирамжуудын дагуу “Гэрээр хүрч очих” үйлчилгээнүүдийг нэвтрүүлсэн.
- Эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийн үзүүлэлт буурсан.
- Хүүхдийн өвчлөл, эмнэлэгт хэвтэх хүүдийн тоо буурсан.
- Ундны усны хангамжийг нэмэгдүүлснээр халдварт өвчний тархалт буурсан.

Монголын нийгэм эдийн засгийн шилжилттэй холбоотойгоор ОНХХ-ийн зүгээс хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн тогтвортой байдлыг хангах үүднээс ОНХХ шилжүүлсэн.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

БОНХХ-ийн үр нөлөөг сум, тосгодыг хооронд нь нэгэн цагт харьцуулан харах зорилгоор цаг хугацааны нэг цэгт хэмжих аргачлалыг ашигласан. Хөтөлбөрийн үр шим хүртэгч, оролцогч талуудын үзэл бодол, ойлголтыг тодорхойлох зорилгоор чанарын мэдээлэл цуглуулалт болон дүн шинжилгээний аргачлалыг ашигласан бөгөөд үр шим хүртэгч болон оролцогч талуудын ойлголт, мэдээллийн нээлттэй байдалд суурилсан. Төслийн туршид дараах таван аргын дагуу мэдээлэл цуглуулалтыг хийв: Баримт бичгийн судалгаа, Ганцаарчилсан ярилцлага, Фокус бүлгийн ярилцлага, Ажиглалт болон Кейс судалгаа. Түүврийн хэмжээ, хүрээ зэргийг БОНХХ-ийн ажилтнууд болон орон нутгийн хамтрагч байгууллага, оролцогч талуудын санал дээр үндэслэн гаргасан.

ҮР ДҮН

Үнэлгээний хүрээнд нь БОНХХ-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох таван сэдвийн хүрээнд зорилтот орон нутаг, олон нийтэд үзүүлсэн хөтөлбөрийн үр нөлөө, үр дүнг үнэлэхийг зорьсон. Энэхүү хураангуйд бид БОНХХ-ийн үндсэн чиглэлүүдээс төслийн тогтвортой үргэлжлэх нөхцлийг дэмжсэн зарим үр дүнгээс түүвэрлэн харуулав.

БОНХХ-ийн тогтвортой байдал

Үйл ажиллагааны таван чиглэл тус бүрт хэрэгжүүлсэн ажлууд, тэдгээрийн тогтвортой үргэлжлэх байдлын үнэлгээг сайн, дунд зэрэг, муу гэсэн үзүүлэлтээр үнэлсэн. Орон нутгийн хүүхэд залуучууд, гэр бүлийн сайн сайхан байдлыг дэмжихэд БОНХХ нь бодитой үр нөлөөг үзүүлж чадсан байна. Доорх хүснэгтэнд судалгааны үр дүнгээс харуулав.

Хүснэгт 1: Төслийн тогтвортой үргэлжлэх боломж, үр шим хүртэгчдээр

Үр шим хүртэгчид	Орон нутгийн идэвхи санаачилга	Хамтын ажиллагаа	Талуудын оролцоо хувь нэмэр	Нийгмийн хариуцлага	Эрсдэлийн бууралт
Хүүхэд	Сайн	Сайн	Сайн	Сайн	Дунд зэрэг
Гэр бүл	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг
Хүүхдийн оролцооны зөвлөл	Сайн	Сайн	Сайн	Сайн	Муу
Багш ажилчид	Сайн	Сайн	Сайн	Сайн	Дунд зэрэг
Орон нутгийн иргэд, олон нийт	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг	Сайн	Муу

Хүснэгт 2: Төслийн тогтвортой үргэлжлэх боломж, хамтрагч талуудаар

Үр шим хүртэгчид	Орон нутгийн идэвхи санаачилга	Хамтын ажиллагаа	Талуудын оролцоо хувь нэмэр	Нийгмийн хариуцлага	Эрсдэлийн бууралт
Сум, аймаг орон нутгийн удирдлага, засаг даргын тамгын газар	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг	Дунд зэрэг
Булган аймгийн хүүхэд гэр бүлийн хөгжлийн төв	Сайн	Сайн	Сайн	Сайн	Дунд зэрэг
Боловсрол, соёлын төв	Сайн	Дунд зэрэг	Сайн	Сайн	Муу
Сургууль	Сайн	Сайн	Сайн	Сайн	Муу
Цэцэрлэг	Сайн	Сайн	Сайн	Сайн	Муу
Хүүхэд хамгааллын хамтарсан баг	Дунд зэрэг	Дунд зэрэг	Сайн	Сайн	Муу

Тогтвортой үргэлжлэх боломжинд тулгарч буй гол эрсдэл нь нийгэм-санхүүгийн хүчин зүйлтэй холбоотой байсан. Тухайлбал ядуурлын шалтгаанаас үүдэн иргэдийн нийгмийн идэвх оролцоо сул байх эрсдэлтэй бөгөөд үүнийг даван туулах нэг арга зам нь орон нутгийн хувийн хэвшлийн аж ахуй нэгж байгууллагуудыг дэмжих, тэдэнд чиглэсэн ажил зохион байгуулах явдал юм. Мөн санхүүгийн хүрэлцээгүй байдал, ажилчдын тогтворгүй байдал, сайн туршлагаа хөтөлбөрийн нэгдсэн тогтолцоо, бүтцэд бүрэн нэгтгэж, ашиглаж чадахгүй байх бусад эрсдлүүд байна.

Эрүүл мэндийн хөтөлбөрийн үр нөлөө

БОНХХ-ийн эрүүл мэндийн хөтөлбөрт төслийн оролцогч болон хамтрагч талуудын дийлэнх нь “сайн” үнэлгээг өгсөн.

Орон нутгийн түвшинд дараах үр нөлөөнүүд бий болсон байна:

- Эмнэлгийн шинэ тоног төхөөрөмжүүд нь эрүүл мэндийн үйлчилгээны чанарыг сайжруулахад чухал нөлөө үзүүлсэн
- Эмч нарын чадавхийг бэхжүүлэх ажлууд нь эрүүл мэндийн үйлчилгээг тухайн орон нутгийн онцлогт тохирсон байдлаар илүү түргэн шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлсэн
- Орон нутгийн засаг даргын удирдамжанд гэрээр зорчих үйлчилгээнүүд танилцуулагдсан
- Эх хүүхдийн өвчлөл, эндэгдлийн үзүүлэлт буурсан

- Хүүхдийн өвчлөл, эмнэлэгт хэвтэх хүүдийн тоо буурсан
- Ундны усны хангамжийг нэмэгдүүлснээр халдварт өвчний тархалт буурсан.

Дээр дурдсанчлан эерэг үзүүлэлтүүд олноор гарч ирсэн хэдий ч эрүүл мэндийн нөхцлийг үнэлэх шалгуур үзүүлэлт нь урт хугацааны, тогтвортой байгаагүй нь дараа дараагийн түвшинд сайжруулах шаардлагатай болох нь харагдсан.

БОНХХ хэрэгжиж эхэлснээс хойш Аймгийн эрүүл мэндийн төв, Засаг даргын тамгын газар, сургуулиуд, Скаут болон Улаан загалмайн нийгэмлэг зэрэг төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагууд хоорондын хамтын ажиллагаа ихээхэн сайжирсан үзүүлэлттэй байна.

Өөр нэг чухал үр нөлөө нь орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах идэвх оролцоо нэмэгдсэн явдал юм. Үнэлгээний үр дүнгээр иргэд, олон нийт өөрсдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ, мэдээлэл авах боломж, сонголт хийх боломжууд нэмэгдсэн эерэг үр дүн гарсан.

ДҮГНЭЛТ БОЛОН ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Дээр дурдсан үр дүн дээр үндэслэн дараах дүгнэлтүүдийг гаргаж байна:

- Тогтвортой үр нөлөө: Хөтөлбөрийн үр нөлөө, сайн туршлага, үр дүнтэй хандлагуудыг тогтвортой үргэлжлүүлэхийн тулд орон нутгийн бодлогын баримт бичгүүд, байгууллагын

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭ



IRIM



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Хөдөлмөрийн Яам (ХЯ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн (ХБИ) хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэнд үнэлгээ хийх, цаашид сайжруулах санал зөвлөмж боловсруулах юм.

СУДАЛГААНЫ ЗОРИЛТУУД:

- ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлийн бодлого хөтөлбөрийг зорилтот бүлэг, оролцогч талуудаар үнэлүүлэх
- Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулах
- Судалгааны үр дүнд үндэслэн сургалт, нөлөөллийн ажлын хэрэгцээг тодорхойлох




2016

3-р сар

2016

6-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Талбарын судалгаа нь Улаанбаатар хот, Баян-Өлгий, Хөвсгөл,
Сэлэнгэ болон Дорнод аймгуудад хийгдсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

2006 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” батлагдсан ба Монгол Улс 2009 онд тус конвенцийг дэмжин нэгдэн орсон билээ. Ийнхүү Монгол Улс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр тогтвортой бодлого, хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлж байна. Эдгээр бодлого, хөтөлбөрийн шугамаар хэрэгжиж буй үйл ажиллагаанууд ойрын жилүүдэд эрчимжиж байгаа тул бодит үр дүн, үр нөлөөг үнэлэх шаардлага гарч байна.

Энэ төсөл нь ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлийн бодлого хөтөлбөрүүдэд үнэлгээ хийх, хэрэгжилтийг сайжруулах санал зөвлөмж боловсруулах ажилд судалгааны мэдээллээр хангах болно.

ТӨСЛИЙН ДИЗАЙН


Судалгааны мэдээллийг дараах аргуудыг ашиглан цуглуулсан. Үүнд:

- 394 асуумж (ХБИ)
- 85 ганцаарчилсан ярилцлага (төрийн байгууллага болон ажил олгогч)
- 6 фокус бүлгийн ярилцлага (ТББ, ажил олгогчид)
- Баримт бичгийн судалгаа
- Баримт бичгийн судалгаагаар “Хөдөлмөрийн тухай хууль” (1999), “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль” (2016) болон бусад холбогдох эрх зүйн болон бодлогын баримт бичгүүдийг судалсан.

ҮР ДҮН

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 37 хувь нь ямар нэгэн байдлаар ажил эрхэлж байгаа нь улсын хэмжээнд эдийн засгийн идэвхтэй хүн амын 90 орчим хувь ажил эрхэлж байгаатай харьцуулахад 2.5 дахин бага байна.

Дүрс 1. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал




ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтэд дараах гол бэрхшээлүүд тулгарч байна. Тухайлбал:

- Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хөдөлмөрийн харилцааг, тэр дундаа хөдөлмөрийн маргаан үүссэн тохиолдолд хэрхэн зохицуулах талаар хуулийн тодорхой заалт байхгүй байна. Хөдөлмөрийн харилцаанд ХБИ-ийн ар гэр оролцдог нь асуудлыг улам ноцтой болгодог байна.
- Зарим ажил олгогчидод ХБИ-ийн талаар мэдлэг байдаггүй тул ХБИ-ийн бэрхшээлийн тодорхой хэлбэрт хориглосон болон зөвшөөрсөн ажлын байрны жагсаалтыг бий болгох хэрэгтэй. Ингэснээр ХБИ-д тохирсон ажлын байрыг санал болгоход тус болно.

Мөн судалгааны үр дүнгээс харахад, Хөдөлмөрийн тухай хуулийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зүйл заалтуудын (111-р зүйл) талаарх мэдлэг болон байгууллага дахь ажилтнуудын тоо хоорондоо хамааралтай байна. Тухайлбал, олон ажилтантай ажил олгогч нь цөөн ажилтантай байгууллагын ажил олгогч нараас илүүтэйгээр ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлийн бодлого, хөтөлбөрийн талаарх сайн мэдээлэлтэй байна.

Дүрс 2. Хөдөлмөрийн хуулийн 111-р заалтын талаарх мэдлэг



“Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 111-р зүйлд “25 түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулна” гэж заасан байна. Харин энэхүү шаардлагыг биелүүлээгүй байгууллагад шийтгэл оногдуулдаг. Энэ заалтын хэрэгжилт муу байгаа нь нэг талаас ажил олгогч байгууллагуудын хууль биелүүлэх байдал сул нөгөө талаас хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих үүрэг бүхий төрийн байгууллагын эрх мэдэл хүрэлцэхгүй байдагтай холбоотой байна.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Одоо хэрэгжиж байгаа хууль, хөтөлбөрийн талаар нэгдсэн ойлголтыг ХБИ болон хөдөлмөрийн харилцаанд оролцогч талуудад өгөх шаардлагатай байна. ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхийн тулд сонгон шалгаруулалтыг явуулахдаа тэдний бэрхшээлийн хэлбэр, онцлогт тохируулан уян хатан болгох шаардлагатай байна. Төрийн байгууллага, ажил олгогч болон ХБИ хоорондын хамтын ажиллагааг сайжруулбал дагаад хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх боломжтой байна.

ХБИ -ийг ажиллуулах боломжтой ажлын байр, ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтыг гаргах шаардлагатай байна. Энэ жагсаалт гарснаар ХБИ, ажил олгогч байгууллага, төрийн байгууллага /хөдөлмөрийн хэлтсийн мэргэжилтэн/, мэргэжлийн хяналтын байгууллага, ТББ зэрэг бүх оролцогч талууд ашиглах боломж үүсэх юм. Энэхүү ажлын байрны жагсаалтын дагуу ажилд зуучлах, ажилд авах, ажил орсоноор хөгжлийн бэрхшээлтэй иргэн нэг ажлын байранд тогтвортой ажиллахад эерэг нөлөө үзүүлнэ.

ЗЭЛҮҮД ТАЛ II: МОНГОЛЫН ЗЭРЛЭГ АН АМЬТНЫ ХУУЛЬ БУС ХУДАЛДАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг (ЛАСН)

Хамтрагч байгууллага "Легал Атлас" ХХК

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Судалгааны үндсэн зорилго нь Монгол дахь зэрлэг ан амьтны агнуур, худалдааны цар хүрээ болон тоо хэмжээний талаар багцаа тооцоолол гаргах явдал байв. Үүнээс гадна ЛАСН-ийн "Хуулийн хэрэгжилтийг сайжруулсанаар зэрлэг амьтдын хууль бус худалдааг бууруулах нь" төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх мэдээлэл цуглуулах давхар зорилготой байв.




2016

4-р сар

2016

11-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



IRIM
INSTITUTIONAL
RESEARCH
AND
INFORMATION
MANAGEMENT

Төсөл нь Улаанбаатар хот болон Булган, Дундговь, Говьсүмбэр, Орхон, Төв аймгуудаас бусад 13 аймгийг хамаран хэрэгжиж байна.

ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг нь 1826 онд байгуулагдсан амьтан хамгааллын шинжлэх ухаан, боловсрол, хамгааллын үйл ажиллагаагаараа дэлхийд тэргүүлэгч байгууллага юм. ЛАСН нь дэлхий дахинд ан амьтан, тэдгээрийн хүрээлэн буй орчныг хамгаалах үйлсийг сурталчилах, өрнүүлэх зорилготой.

ЛАСН одоогоор Монголд ан амьтан хамгаалах чиглэлээр хэд хэдэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаагийн нэг нь “Хуулийн хэрэгжилтийг сайжруулсанаар зэрлэг амьтдын хууль бус худалдааг бууруулах нь” төсөл юм. Энэхүү төслөөр дамжуулан ЛАСН нь хууль бус ан агнууртай тэмцэх, зэрлэг амьтдын хууль бус худалдааг бууруулах, холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хуулийн хэрэгжилтийг сайжруулахаар зорилт тавин ажиллаж байна.

Зэрлэг амьтдын хууль бус худалдааг бууруулахад оролцоотой төрийн байгууллагууд, тэдгээрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэх, хууль эрх зүйн ойлголтыг сайжруулах замаар дээрх зорилтуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Мөн түүнчлэн зэрлэг амьтдын хууль бус худалдааны асуудлаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа авч хэрэгжүүлж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Судалгаа нь үндсэн 2 бүрэлдэхүүн хэсэгтэй ба эдгээр нь өрхийн судалгаа болон зах зээлийн судалгаа юм. Судалгааны дизайн нь 2006 онд хийгдсэн “Зэлүүд тал: Монголын ан амьтны хууль бус худалдааны хямралтай асуудлууд” судалгааны дизайнд суурилсан ба энэ аргачлал нь судалгааны уялдаа болон харьцуулагдахуйц байдлыг хангасан.

Судалгаанд дараах шинжилгээний загварыг ашиглалаа. Үүнд:

1. Шинжилгээнд цаг хугацааны хэмжүүр ашиглаагүй. Харин цаг хугацааны нэг цэгт мэдээлэл цуглуулсан.
2. Судлагдаж буй асуудалд гарсан өөрчлөлтийг хэмжихээс илүүтэйгээр өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлоход төвлөрсөн.

Иймээс судалгааны үр дүнгээр нийгмийн бүлгүүдийн хоорондох өнөөгийн ялгааг л харуулахаас бус тэдгээрт гарсан өөрчлөлтийг хэмжихгүй юм.

Судалгаа нь зэрлэг амьтдын хууль бус худалдааны нийлүүлэлт (зэрлэг амьтдын ан агнуур, худалдаа - зах зээлийн судалгааны бүрэлдэхүүн хэсгээр төвлөрөн судалсан) болон эрэлт (зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний хэрэглээ-өрхийн судалгааны бүрэлдэхүүн хэсгээр судлагдсан)-ийг тодорхойлоход голчлон анхаарсан. Хэдий судалгаа нь 2 тусдаа бүрэлдэхүүн хэсгээс бүрдэж байгаа ч судалгааны асуултууд нь харилцан уялдаатай, харилцан нөхөж мэдээлэл авч байсан юм..

Өрхийн судалгаанд үндэсний хэмжээний төлөөллийг хангах үүднээс олон шатлалт түүврийн аргыг ашигласан. Судалгааны явцад

өрхийн асуумж, ажиглалтын хуудас зэрэг хэрэглэгдэхүүнүүдийг ашиглаж мэдээлэл цуглуулсан. Улаанбаатар хот болон сонгогдсон 13 аймгаас нийт 4000 өрхөөс судалгааны мэдээлэл цуглуулсан.

Зах зээлийн судалгаа нь ганцаарчилсан ярилцлага, ажиглалтын хуудас, зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний үнийн хуудас гэх мэт хэрэглэгдэхүүнүүдийг ашигласан. Ганцаарчилсан ярилцлагад оролцогчид нь ихэвчлэн зэрлэг амьтны хууль бус худалдаанд оролцогчид байв. Тухайлбал, анчид, тээвэрлэгчид, худалдаачид болон хууль сахиулах байгууллагын төлөөлөгчид гэх мэт. Ярилцлагад оролцогчдыг цасан бөмбөлөгийн аргаар түүвэрлэсэн. Үүнээс гадна зэрлэг амьтны гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өртгийг тодорхойлох зорилгоор голлох худалдааны цэгүүдээр зочилон үнийн мэдээлэл цуглуулсан. Зах зээлийн судалгаа нь Улаанбаатар хот болон 8 аймгийг хамарсан.

ҮР ДҮН БА САНАЛ ЗӨВЛӨМЖ

Мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийн хүрээнд уг төслийн үр дүнтэй холбоотой мэдээллийг энэхүү хэсэгт дурдахгүй болно.

МОНГОЛ ДАХ МӨНГӨН УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТЕХНИКИЙН ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

EX Research Institute, Япон

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Төслийн зорилго нь Монгол дахь мөнгөн усны менежменттэй холбоотой төслийг төлөвлөх, зохицуулах, ложистик болон зөвлөх үйлчилгээг хангах асуудлыг судлана. Энэ зорилгын хүрээнд:

- Монгол дахь Мөнгөн Минаматагийн Конвенцитай холбоотой хууль, тогтоол, журам, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл цуглуулах
- Талбарын судалгаа, ярилцлагуудыг товлон зохион байгуулах
- Хэлэлцүүлгийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.



2016

7-р сар

2016

12-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийг Улаанбаатар хотод хэрэгжүүлсэн.

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн Газар 2015 оны 9-р сарын 28-нд Мөнгөн усны Минаматагийн конвенцод нэгдэн орсоноор уг конвенцийн зүйл заалтуудыг дагаж мөрдөх шаардлага бий болсон. Энэ тэргүүнд манай оронд мөнгөн усны хог хаягдлыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах шаардлагатай байгаа ч одоогийн байдлаар мөнгөн усны хаягдлыг дахин боловсруулах, саармагжуулахад чиглэсэн дорвитой үйл ажиллагааны санал, санаачилга хийгдээгүй байна. Мөн түүнчлэн, мөнгөн усны хог хаягдлын талаар мэдээлэл дутмаг байгаа юм. БНХАУ, ОХУ гэсэн аюултай бодис нэвтрүүлэхийг хориглосон улсуудын дунд Монгол улс нь оршиж байгаа тул мөнгөн усны менежменттэй холбоотой яаралтай арга хэмжээ авч, эрүүл мэнд, аюулгүй байдлаа хангах шаардлага бий болоод байна.

EX Research Institute нь нотолгоонд суурилсан үйл ажиллагаа явуулах зорилгоор мөнгөн усны менежментийн техник хэрэгцээ, шаардлагыг үнэлэх төслийг санаачилсан. Энэхүү техник хэрэгцээг тодорхойлох судалгаа нь Японы Засгийн Газрын 'MOYAI Initiative'-н нэг хэсэг болж хэрэгжсэн. Энэхүү санаачилгын зорилго нь хамтрагч улс орнуудад Мөнгөн усны Минаматагийн Конвенцийг үр дүнтэйгээр нутагшуулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн хүрээнд ганцаарчилсан ярилцлага болон баримт бичгийн судалгааны аргуудыг ашигласан. Ганцаарчилсан ярилцлагад төрийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд (ТББ) болон хог хаягдал болон мөнгөн усны менежментийн талбарт ажиллаж буй оролцогч талуудыг хамруулсан. Ялангуяа судалгааны баг Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам, Эрүүл мэнд, Спортын Яам, Уул уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам болон Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар, Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газрын (Агаарын чанар

болон Хог хаягдлын менежментийн хэлтэс) ажилтнуудтай ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулсан. Мөн хоёр нүүрсний цахилгаан станц болон гурван хог хаягдлын хувийн компанийн төлөөлөлтэй ярилцлага хийсэн. Мөн цөөн хэдэн төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон олон улсын байгууллагуудтай уулзалтуудыг хийсэн. Судалгааны баг холбогдох 40 гаруй оролцогч талуудын дунд судалгааны үр дүнг танилцуулах уулзалтыг Цэнгэг Ус, Байгалийн Нөөцийн газарт 2016 оны 9-р сарын 27-нд зохион байгуулсан.

ҮР ДҮН, ЦААШДЫН ХАНДЛАГА

Мөнгөн усны менежментийн хувьд, Монгол улсад нэлээдгүй хууль болон байгаль орчны стандартууд хэрэгжиж байна. Мөн Минаматагийн Конвенцитай холбоотой хэд хэдэн төслүүд өнгөрсөн хугацаанд хэрэгжиж байжээ. Тухайлбал, "Мөнгөн усны тооллого болон Эрсдэлийн Менежмент дэх Минаматагийн Конвенцийн хэрэгжилт" (2011) ба Миниматагийн эхлэлтийн үнэлгээ зэрэг болно. Мөнгөн усыг Засгий Газрын 95-р тогтоолоор хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад оруулсан. Гэтэл иргэдийн дунд мөнгөн усны экспорт болон импортын талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг байна. Мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл Монголд маш бага байгаа бөгөөд харин олонхи бүтээгдэхүүнүүд нь Хятад гэх мэт бусад улс орнуудаас импортоор орж ирсээр байна. Мөнгөн усыг ашиглах, экспортлох, импортлох асуудлуудыг "Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль"-иар зохицуулж байгаа ч мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүнийг аль ч хуулиар зохицуулаагүй байна.

Монгол улсад өнгөрсөн хугацаанд ихээхэн хэмжээний мөнгөн ус ашиглаж байсан ямар нэгэн аж үйлдвэрлэл байхгүй байна. Мөн (2011) Эрүүл мэндийн салбарт мөнгөн ус агуулсан термометр,

сфигмоманометр, шүдний амальгам зэргийг худалдан авах, ашиглахыг хориглосон тогтоолын дагуу эдгээр бүтээгдэхүүний худалдан авалт болон ашиглалтыг бүрэн хориглосон. Үүнтэй холбоотойгоор, эдгээр мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүнүүдийг эрүүл мэндийн байгууллага болон шүдний эмнэлгүүдэд ашиглахаа зогсоосон.

Хэдий тийм боловч, өрхүүд болон эрүүл мэндийн байгууллагуудаас хориг гарахаас өмнө худалдан авч, борлуулсан мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүнүүдийг авч хаях асуудал шийдэгдэлгүй үлдээд байна. Одоогийн байдлаар, мөнгөн ус агуулсан эрүүл мэндийн багаж хэрэгслийг Онцгой Байдлын Ерөнхий Газраас гаргасан тушаалын дагуу “Химийн бодисын хог хаягдлыг түр хадгалах зориулалтын байр”-нд аюулгүйгээр хадгалж, аюултай хог хаягдлын нэгдсэн байгууламжид хүлээлгэн өгч байна. Тиймээс, цаашдын мөнгөн усны менежментийн чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөрүүд нь чийдэн, баттерей, халууны шил гэх мэт мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүнүүдийг ангилах, ялгах асуудлыг нэн түрүүнд шийдвэрлэх шаардлагатай.

Судалгааны үр дүнд, мөнгөн усны хаягдалтай холбоотой мэдээлэл дутмаг байгаа нь ажиглагдсан. Өнөөдөр Монголын зах зээлд борлуулагдаж буй мөнгөн ус агуулсан чийдэн, баттерей, гоо сайхны бүтээгдэхүүний талаарх судалгаа байхгүй байна. Хэдийгээр орон нутгийн төрийн байгууллагуудтай гэрээлсэн компаниуд өрхүүдийн хог хаягдлыг цуглуулж байгаа ч, хогийн цэгүүд дээр бусад хог хаягдалтай хольж, булахаас сэргийлж мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүнийг ангилж ялгах ажил хийгдэхгүй байна.

СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

Судалгааны баг анхаарал хандуулахуйц дараах гол зөвлөмжийг гаргаж байна.

1. Мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүн
 - Мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүний агууламжийг шинжилэх арга зүйг нутагшуулах
2. Бичил уул уурхай (БУУ)
 - Албан бус уул уурхай эрхлэгчид болон олон нийтийн дунд мөнгөн усны эрүүл

мэндэд үзүүлэх үр нөлөөг таниулж, мэдлэгийг нэмэгдүүлэх

- Мөнгөн усны хордлогыг шинжлэх, эмчлэх сайн туршлагыг хуваалцах
- Бичил уурхай эрхлэгчдийг мөнгөн усаар хангаж буй нийлүүлэгч болон нийлүүлэлтийн урсгалыг судлах
- Мөнгөн усгүйгээр алт ялгаж, цэвэрлэх үйл явцын талаар судалж, үр дүнг тархаах
- Албан бус уурхайн үйл ажиллагааг хянах үр дүнтэй арга хэмжээ авах
- Албан бус уурхайчдын үйл ажиллагааг зогсоох урт хугацааны стратеги боловсруулах (албан бус уул уурхай эрхлэгчдийг албажуулах, нэгтгэх, амьжиргааны түвшинг сайжруулахад чиглэсэн өөр боломжуудыг судлах замаар)

3. Мөнгөн усны хаягдлын менежмент

- Мөнгөн усны хог хаягдлын тооллого явуулах
- Өрхөөс гарч буй мөнгөн ус агуулсан бүтээгдэхүүнийг цуглуулах талаар сайн туршлагыг судалж, тархаах
- Мөнгөн усны хаягдлын үүсгэж болзошгүй эрсдэлийг танин мэдүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх

4. Хяналт болон тооллогыг гүйцэтгэх

- Био-хяналт (хүний үс, загас гэх мэт) болон эрсдэлийн үнэлгээний аргуудыг нутагшуулах
- Бодит мониторингийн мэдээлэлд үндэслэн мөнгөн усны хаягдлын тооллого хийх
- Монголд ашиглаж болохуйц Мөнгөн усны хаягдлын хяналтын аргачлалуудыг (нүүрсний шаталтын явц дах) нэвтрүүлэх

ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮД

ЭРХ ЗҮЙТ ЁС БА МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗАСАГЛАЛ



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Нэгдсэн Үндэстэний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ)

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Энэхүү төслийн зорилго нь төрийн байгууллагуудын уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой байгаль хамгааллын асуудлыг шийдвэрлэхэд мөрдөж буй зарчмыг үнэлэх юм. Үнэлгээ нь эрх зүйт ёсны зарчим хуулинд тусгагдсан эсэх, практик үйл ажиллагаанд мөрдөж буй эсэхийг тодруулах ба төрийн үйлчилгээ хууль ёсны байх, хүртээмжтэй байх зэрэг зүйт ёсны зарчмуудыг ямар хууль, журмуудаар зохицуулж байгааг шинжилэн судлана. Үнэлгээний хүрээнд:

- Сонгогдсон, давуу болон сул талыг тодорхойлох
- Үйлчилгээ үзүүлж буй төрийн байгууллагуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ болон ажлын гүйцэтгэлийг хүний эрхийн хандлага болон үйлчилгээ авч буй иргэдийн санал бодлоор дамжуулан үнэлэх
- Хуулиар заасан зохицуулалт болон практикт мөрдөж буй байдал хоёрын зөрүүг шинжлэхийг зорьсон.




2016

9-р сар

2017

3-р сар

ГАЗАРЗҮЙН ХАМРАХ ХҮРЭЭ



Төслийг Архангай аймаг (Цэнхэр сум) болон Өмнөговь аймаг (Цогтцэций сум) болон Улаанбаатар хотод гүйцэтгэсэн.

ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Монголын олборлох салбарын хөгжил нь нийгэм болон эдийн засгийн хөгжлийг дэмжихүйц хамгийн гол салбар юм. Гэтэл энэ салбарын байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийн менежментийн асуудал нь Монгол Улстай адил байгалийн нөөцөөс хамааралтай хөгжингүй орнуудын хувьд хамгийн гол сорилт болдог. Энэ нь ихэвчлэн байгаль орчны менежментийн асуудалд хяналт тавьж ажилладаг байгаль хамгааллын асуудал хариуцсан төрийн байгууллагууд болох агентлаг, яам болон засгийн газар нь салбарыг удирдах бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байгаагаас үүдэж байна. Энэхүү бүрэн эрх нь байгаль хамгаалах ажлыг удирдан чиглүүлэх, нийгмийн дэвшлийг урагш ахиулах, тогтвортой өсөлтийг хурдасгахыг шаарддаг. Гэсэн хэдий ч, газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын олборлолт

нь ихэвчлэн байгаль орчны доройтол, зөрчил, авлига, хүний эрхийн зөрчлийг дагуулдаг.

Улс орнуудыг эдгээр сорилтыг даван туулахад нь туслах зорилгоор НҮБХХ-өөс “Тогтвортой Байгалийн Нөөцийн Менежментийн төлөө Байгаль Орчны Засаглал” глобал төслийг санаачилсан. Энэ төсөл нь Колумби, Кени, Монгол болон Мозамбек гэсэн улсуудын холбогдох оролцогч талуудын байгаль орчин болон уул уурхайн яамд, холбогдох оролцогч талуудад дэмжлэг үзүүлэх зорилготой юм. Энэхүү шинэ санаачилгын хүрээнд, НҮБХХ нь уул уурхайн салбар дахь байгаль орчны зохицуулалтыг хариуцан ажиллах үүрэг бүхий БОАЖЯ, МХЕГ-ын үйл ажиллагаанд үнэлгээ хийх ажилд дэмжлэг үзүүлж байна.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

Төслийн хүрээнд НҮБХХ, Шведийн Судалгааны Хүрээлэн, Folke Bernadotte Academy байгууллагын хамтран боловсруулсан судалгааны арга зүйг ашигласан. Энэхүү арга зүй нь төрийн байгууллагын үйл ажиллагаан дахь хууль ёсны байдал, хүртээмжтэй байдал, санал бодлоо илэрхийлэх, сонсох эрх, ил тод байдал, гомдол гаргах, давж заалдах эрх, хариуцлагатай байдал гэсэн эрх зүйт ёсны 6 зарчмийг үнэлэхэд зориулагдсан.

Энэхүү үнэлгээ нь 3 хэсгээс бүрднэ. Эхний хэсэг нь хууль, эрх зүйн зохицуулалтын албан зураглал буюу холбогдох агентлагуудын үйл ажиллагаа явуулж буй институцийн орчны зураглал гаргах юм. Үүний хүрээнд, уул уурхай, байгаль орчин, захиргаатай холбоотой 17 хуулинд шинжилгээ хийсэн.

Хоёр дахь хэсэг нь төрийн албан хаагчдын хариуцлагын механизмыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ажлын орчинд тулгарч буй бэрхшээлийг илрүүлэх зорилготой санал бодлын судалгаа юм. Энэ судалгааг төрийн байгууллагын анхан шатны нэгжээс сумын түвшин хүртэлх бүхий л удирдлагын түвшинд ажиллаж буй төрийн албан хаагчдаас авсан. Тухайлбал, БОАЖЯ болон

МХЕГ, тэдгээрийн салбар, нэгжүүдэд ажиллаж буй уул уурхай болон байгаль орчны асуудал хариуцан ажиллаж байгаа 65 төрийн албан хаагчдыг үнэлгээнд хамруулсан.

Үнэлгээний гурав дахь хэсэг нь эдгээр агентлагуудын гаргасан шийдвэр, төрийн үйлчилгээг авч буй үйлчлүүлэгчдийн санал бодлын судалгаа юм. Үйлчлүүлэгч гэдэгт иргэд болон аж ахуйн нэгжүүдийг багтааж байна. Тухайлбал, үнэлгээнд уул уурхайн компаниуд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний компаниуд, байгаль хамгааллын чиглэлээр ажиллаж буй ТББ, сонгогдсон аймаг, сумдад амьдарч буй малчид, хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчдийг хамруулсан.

Энэхүү 3 хэсгийн хүрээнд цуглуулсан баримт бичгийн судалгаа болон санал бодлын судалгааны мэдээлэл нь харилцан бие биенээ шалгаж, нөхөн гүйцэнэ.

ҮР ДҮН, ЗӨВЛӨМЖ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

Энэхүү төсөл нь Жилийн тайланг бичих явцад хэрэгжиж байсан тул энэ хэсэгт мэдээлэл оруулах боломжгүй байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ГЭРЭЛТ ИРЭЭДҮЙ

World Vision

IRIM



ЗАХИАЛАГЧИЙН НЭР

Дэлхийн Зөн-Монгол Олон Улсын Байгууллага /ДЗМОУБ/

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхдийн Гэрэлт Ирээдүй”/ХБХГИ/ төслийн гол зорилго нь Улаанбаатар хотын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд/ХБХ/-ийн ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх явдал юм. Тус зорилгын хүрээнд дараах хоёр зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- ХБХ-ийг илрүүлэх үндэсний болон орон нутгийн стандарт, механизмийг сайжруулах
- ХБХ-эд тохирох боловсролын үйлчилгээ, сургалтын хэрэгсэлээр хангах, хөгжүүлэхэд нь гэр бүл болон боловсролын байгууллагуудыг чадавхжуулах

Энэ төслийг ДЗМОУБ-тай хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд IRIM Судалгааны Хүрээлэн нь уг төслийн Зорилт-1-н хэрэгжилтийг хариуцан ажиллаж байна.



2016

6-р сар

2017

9-р сар

ХАМРАХ ХҮРЭЭ

Улаанбаатар хотод хэрэгжиж байна

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ

Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Спортын Яамны /БСШУСЯ/ мэдээгээр 2014-2015 оны хичээлийн жилд бага, дунд сургуульд нийт 505816 суралцагч суралцаж байгаа ба нийт суралцагчдын дөнгөж хоёр хувийг (11072) ХБХ эзэлж байна. Тусгай боловсролын сургууль хүртээмжгүй, багш мэргэжилтнүүд хүрэлцээгүй байдлаас шалтгаалан улсын хэмжээнд ялангуяа хөдөө орон нутагт сургууль завсардаж буй хүүхдүүдийн дийлэнх хувийг ХБХ бүрдүүлж байна. Мөн оны мэдээгээр нийт сургуулийн насны ХБХ-ийн 30 гаруй хувь нь (4779) ямар нэг боловсролын үйлчилгээ авч чадалгүй сургуулийн гадна үлдсэн байна.

Манай улсад хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох нэгдсэн аргачлал, арга зүй дутмаг байгаагаас боловсрол, эрүүл мэнд, нийгэм хамгаалалын зэрэг салбарын тоо бүртгэл хоорондоо ихээхэн зөрүүтэй байна. 2014 онд IRIM Судалгааны Хүрээлэн нь Японы Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн Судалгааны Институтийн (JICARI) захиалгаар “Хөгжлийн бэрхшээл ба боловсрол” судалгааг үндэсний хэмжээнд хийж гүйцэтгэсэн ба энэ судалгааны үр дүнгээр ХБХ-ийн талаарх мэдээлэл, тоо баримт ихээхэн зөрүүтэй, тодорхой бус байгаа юм. Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хүүхдийн бэрхшээлтэй эсэхийг ихэнх тохиолдолд багш нар өөрсдийн хувийн туршлага дээрээ үндэслэн тодорхойлж байгаа бөгөөд ашиглаж буй нэгдсэн арга аргачлал, хэрэглэгдэхүүн огт байхгүй байна.

2014 онд Эрүүл Мэндийн Яам, БСШУЯ, Хөдөлмөр Нийгэм Хамгааллын Яамны /ХНХЯ/ сайд нарын хамтарсан тушаалаар манай улсад хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох үүрэгтэй Эрүүл Мэнд, Боловсрол, Нийгэм Хамгааллын Төв болон салбар комиссыг (ЭМБНХК) аймаг орон нутаг, нийслэл, дүүргийн түвшинд байгуулсан. Гэсэн хэдий ч өнөөдрийг хүртэл тус комиссын үйл ажиллагаа бүрэн жигдрээгүй, иргэд, эцэг эхчүүдийн дунд тус комиссын талаар мэдээлэл хангалтгүй байна. Иймд тусгай хэрэгцээтэй хүүхдүүдэд тулгамдаж байгаа асуудал, хөгжлийн

бэрхшээлийг эрт илрүүлж таних арга, аргачлал үндэсний хэмжээнд зайлшгүй шаардагдаж байна. Энэ хэрэгцээ шаардлагад үндэслэн IRIM Судалгааны Хүрээлэн нь ХБХГИ төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэх аргачлалыг нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тус аргачлал нь анхан шатны түвшинд /хороо, сургууль/ хүүхдүүдийн үйл ажиллагаанд тулгамдаж байгаа бэрхшээлийг илрүүлэх энгийн аргачлал байх бөгөөд албан ёсны оношилхо эрх бүхий ЭМБНХК-ийн оношилгоонд орох шаардлагатай хүүхдүүдийг илрүүлэх боломжтой болох юм.

ТӨСЛИЙН ДИЗАЙН

IRIM Судалгааны Хүрээлэн төслийн холбогдох үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна:

Суурь судалгаа

Төсөл хэрэгжихээс өмнөх нөхцөл байдлыг үнэлэх зорилгоор Улаанбаатар хотын гурван дүүрэгт суурь судалгааны ажлыг зохион байгуулсан. Суурь судалгааны хүрээнд зорилтот есөн сургуулийн багш, удирдлага, 18 хорооны нийгмийн ажилтан, дүүргийн мэргэжилтэн, ТББ-ын төлөөлөл, ХБХ-ийн эцэг эхчүүдээс нийт 312 асуумж, 60 хагас бүтэцлэгдсэн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.

Бодлогын судалгаа

Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд дэх ХБХ-ийн чиглэлээр холбогдох заалт, журамд дүн шинжилгээ хийсэн. Мөн судалгаагаар гарсан үр дүнг баталгаажуулах зорилгоор холбогдох төрийн болон ТББ-ын мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлагыг хийж гүйцэтгэсэн.

ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА СУДЛАХ СУДАЛГАА

Төслийн хүрээнд Австрали, Ирланд, Тайланд, АНУ -ын ХБХ-ийг тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоо, бодлого, үйл ажиллагааг харьцуулсан шинжилгээ хийн, туршлагыг судласан. Энэ судалгаанд дараах шалгуур үзүүлэлтүүдээр анализ хийсэн юм. Үүнд:

- ХБ-ийг үнэлэх тэй холбоотой дүрэм журам
- ХБ-ийг үнэлэхэд ашиглаж байгаа арга, аргачлал
- ХБ-ийг үнэлэх үйл явцад оролцогч талууд зэрэг шалгуур үзүүлэлт багтна.

Ажлын хэсгийг байгуулах

Төслийн гол зорилтын биелэлтийг хангах зорилгоор хөгжлийн бэрхшээлийг анхан шатанд оношлон илрүүлэх аргачлалыг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэгт ХБХ-ийн боловсролын чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүд болон дүүргүүдийн ЗДТГ төлөөлөл болон холбогдох ТББ-ын төлөөллүүд багтсан.

Илрүүлэх аргачлалыг турших

Туршилт үнэлгээг Улаанбаатар хотын есөн сургуулийн 500 хүүхдийн дунд хийхээр төлөвлөсөн. Хүүхдүүдийг түүвэрлэхдээ ХБХ, ХБ-тэй байж болзошгүй эрсдэлтэй хүүхдүүд болон ердийн хүүхдүүд гэсэн гурван бүлэгт хуваан үзсэн.

Төслийн багийн зүгээс цаашид үнэлгээний аргачлалыг ашиглах арга зүйг сургуулийн багш, нийгмийн ажилтнуудад эзэмшүүлэн талбарын үнэлгээг хамтран зохион байгуулна.

Туршилтын үр дүн дээр үндэслэн аргачлал болон ашиглах гарын авлагыг эцэслэж, хэвлэн дүүрэг, хороо, сургуулийн багш, ажилтан зэрэг төслийн оролцогч талуудад тараан, аргачлалын ашиглах арга зүйг түгээн дэлгэрүүлэхээр төлөвлөж байна.

Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын ажилтнуудыг сургах

ХБХ-ийг илрүүлэх аргачлалыг ашиглах арга зүй олгох сургалтыг өрхийн эмч, сургуулийн багш, хорооны нийгмийн ажилтан болон ХБХ-тэй эцэг эхчүүдийн дунд зохион байгуулахаар төлөвлөж байна.

ҮР ДҮН

Дээр дурдсан үйл ажиллагааны хэрэгжилтээс гарсан үр дүнг дурдвал:

1. Суурь судалгаа

Суурь судалгааны үр дүнгээр 2015-2016 оны хугацаанд ХБХ-ийн үнэлгээтэй холбоотой ямар нэгэн үйл ажиллагааг хэрэгжүүлсэн дүүрэг, хороо, сургууль байхгүй байна. Салбар ЭМБНХК-ийн цөөн гишүүд ХБХ-ийг үнэлэх зарим аргуудыг мэдэж байгаа ч яг хүүхдийг үнэлэхэд ашиглаж байгаа тохиолдол гараагүй байна.

2. Бодлогын судалгаа

ХНХЯ-ны харьяа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн хэлтэс нь Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 11 дүгээр сарын 9 өдрийн 136 тоот тогтоолоор Ерөнхий сайдын дэргэдэх ХБИ-ийн Зөвлөлийн Ажлын Алба болж салбар дундын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах эрхтэй болсон байна. Судалгааны дүнгээс үзвэл энэ ажлын алба нь яамдын ажлын уялдааг хангаж, нэгдсэн зохицуулалт хийн ажиллах эрх мэдэл, чадвахи дутмаг ажиллаж байна. Мөн холбогдох яамд хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, хамтын ажиллагаанаас гадна төрийн болон ТББ, олон улсын байгууллага /ОУБ/ хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо сул байна.

3. Олон улсын туршлага судлах судалгаа

Олон улсын туршлагыг судлан үзвэл хүүхдийн хэрэгцээнд нийцсэн тусгай боловсролын үйлчилгээг хүргэхдээ дунд сургууль болон тусгай боловсролын төвүүд /ТБТ/ -ын хамтын ажиллагаа их өндөр түвшинд байна. Сургууль дээр хүүхдийн бэрхшээлийг анхан шатны түвшинд илрүүлэх үнэлгээний баг ажилладаг бөгөөд тус багийн үнэлгээгээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дараагийн шатны нарийн оношлогоо, үнэлгээ шаардлагатай гэж үзвэл тухайн орон нутаг дахь ТБТ-д ханддаг байна. Албан ёсны оношилгооны баг нь хүүхдийн эмч, тусгай боловсролын багш, сэтгэл зүйч, согог засалч зэрэг мэргэжилтнүүдээс бүрдэнэ. Мэргэжилийн багийн үнэлгээгээр ХБХ-тэй хэрхэн ажиллах арга зүй, зааварчилгаа,

зөвлөгөөг сургуулиудад хүргүүлэн, хүүхдийн өөрийнх нь онцлог хэрэгцээнд нийцсэн байдлаар хөгжүүлэх, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг байна.

4. Ажлын хэсэг

ХБХ-ийг илрүүлэх олон талт аргачлалуудыг судласны дүнд ажлын хэсгийн зүгээс Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сангийн /НҮБХС/ аргачлалаар боловсруулсан хүүхдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй аливаа эрсдлийг тодруулах зорилготой “Вашингтон бүлэг-Хүүхдийн үйл ажиллагаа” модулийг төслийн хүрээнд ашиглахаар сонгосон юм. Энэ аргачлал нь олон улсад туршигдсан, НҮБХС-ийн зүгээс улс орнуудад санал болгож буй жишиг аргачлал бөгөөд манай орны хувьд анхан шатны түвшинд хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг илрүүлэх оновчтой аргачлал нэвтрүүлэх төслийн зорилттой ихээхэн уялдаж байгаа юм.

ДҮГНЭЛТ БА ЦААШДЫН ЧИГЛЭЛ

ХБХГИ төслийн хүрээнд дээр дурдсан олон талт ажлуудыг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэхээр зорьж байна.

- Нэгдүгээрт, илрүүлэх аргачлалын хэрэглээ өргөн хүрээтэй нэвтэрснээр ХБХ-ийн статистик бүртгэл тодорхой бөгөөд үндэслэлтэй гарах боломж бүрдэнэ.
- Хоёрдугаарт, салбар ЭМБНХК-ийн оношилгоонд орох шаардлагатай хүүхдүүд тодорхой болох бөгөөд хүүхдийн бэрхшээлийг тодорхойлох үндэсний механизм сайжирна.
- Хамгийн гол үр дүн нь ХБ-тэй эсэх нь тодорхойлогдоогүй байсан хүүхдүүдийн бэрхшээлийг таньж мэдсэнээр цаашид тэдгээр хүүхдүүдийн тусгай хэрэгцээнд нийцсэн үр дүнтэй сурч хөгжих боломжийг бүрдүүлэх юм.